

Зохиогч ЭЙМОН БАТЛЕР

АРДЧИЛАЛ

Орчуулагч Намхай ХАСАР

ДАА
ННА
Я-

Зохиогч: ЭЙМОН БАТЛЕР

Орчуулагч: Н.ХАСАР

Орчуулгын редактор: Х.БИЛГҮҮНБАЯР

Хэвлэлийн эх бэлтгэл: Б.ТӨГӨЛДӨР

Хэвлэлийн газрын редактор: Д.Хишгээ

Copyright ©2025 by London Publishing Partnership
Монгол орчуулгын эрх ©ЗоригАрдчиллынХүрээлэн

Энэхүү бүтээл нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан бөгөөд албан ёсны эрхтэйгээр англи хэлнээс орчуулсан болно. Зохиогчийн зөвшөөрөлгүйгээр бүхэлд нь болон хэсэгчлэн хуулбарлах, хэвлэн олшруулах, цахим мэдээллийн хэрэгслээр тараахыг хориглоно. Номоос эш татсан бол эх сурвалжийг зохиогчийн нэрийн хамтаар заавал дурдсан байна.

Хэвлэсэн: 2025 он I Анхны хэвлэл
ISBN:

Hashtag: zorigdemocracyinstitute

ЗОРИГ АРДЧИЛЛЫН ХҮРЭЭЛЭН

Утас: (+976) 7511-2024 / 9902-2772

И-мэйл: Contact@ZID.mn

Сошиал: Зориг Ардчиллын Хүрээлэн

Веб: <https://www.ZID.mn/>

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Ардчилсан намын төв байр #412



САЙН ЦАГИЙГ
САНУУЛ УХААНААР

ГАРЧИГ

АРДЧИЛЛЫГ ОЙЛГОХ НЬ	6
АРДЧИЛЛЫН ТҮҮХЭЭС	19
АРДЧИЛСАН ИНСТИТУЦИУД	42
АРДЧИЛСАН ЗАРЧМУУД	56
ОРЧИН ҮЕИЙН ТӨЛӨӨЛЛИЙН АРДЧИЛЛУУД	73
АРДЧИЛЛЫН АШИГ ТУС	90
АРДЧИЛЛЫН ШҮҮМЖ	105
АРДЧИЛЛЫН ХЭТИЙТСЭН МАГТААЛ	124
АРДЧИЛСАН ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ	137
ШАХАЛТАНД ОРСОН АРДЧИЛАЛ	149
ИРЭЭДҮЙН ОРОЛЦОО	160
АРДЧИЛАЛ БА ХИЛ ХЯЗГААР	176
ТУРШЛАГААС ҮҮДЭЛТЭЙ СУРГАМЖУУД	193
АРДЧИЛЛЫН ТУХАЙ ЭШЛЭЛҮҮД	207
211	УНШИЖ СУДЛАХ МАТЕРИАЛУУД
217	ГОЛЛОХ НЭР ТОМЬЁОНУУД
221	АШИГЛАСАН БОЛОН НЭР ДУРДСАН БҮТЭЭЛҮҮД
227	ЗОХИОГЧИЙН ТУХАЙ

I

АРДЧИЛЛЫН ОЙЛГОХ НЬ

НОМЫН ТУХАЙ

Энэхүү ном нь ардчиллын мөн чанар, ашиг тус, хязгаар, давуу болон сул тал нь юу вэ гэдгийг тайлбарласан гарын авлага юм. Ардчиллыг хэн бүхэнд хялбараар ойлгуулах нь номын маань зорилго. Өөрсдийгөө ардчиллын талаар гайгүй сайн мэднэ гэж боддог хүмүүс хүртэл ардчиллын шүүмжлэхүйц шинж чанаруудыг нь анзааралгүй өнгөрөөчихсөн байдаг тул тэдэнд ч ном маань тустай.

Дэлхийн хүн амын гуравны хоёрыг бүрдүүлж буй зуу орчим улс ардчилсан гэгдэх засаглалтай. Гэвч цөөхөн хэд нь л ардчиллын идеалыг бодитоор хэрэгжүүлж, голлох зарчмууд хийгээд институциудыг нь хүндэтгэн үзэж байна. Иймээс ардчиллыг зөвөөр ойлгох нь нэн чухал.

Ном маань ардчиллыг тайлбарлаж, жинхэнэ ардчилал болон өнөө цаг үеийн хуурамч ардчиллуудын ялгааг тодотгон харуулах болно. Ардчиллын түүхийг тоймлож, ардчилал гэх үг нь хэрхэн өөрчлөгдөж байгааг дурдаж, ардчилалд хүргэх арга замуудыг хэлж өгөх ба ардчиллын хязгаар, ардчиллын давуу болон сул талуудыг хураангуйлна. Эцэст нь, яагаад өнөөдөр хүмүүс ардчилалд итгэл алдарч буйг авч хэлэлцэн, асуудлын шийдлийг санал болгосноор ном төгсөнө.

АРДЧИЛЛЫН АСУУДАЛ

Ардчилал хэмээх үгийн утга өөрчлөгдсөн нь ардчиллыг ойлгож, мэдье гэсэн хүмүүст тулгардаг хамгийн том бэрхшээл. Манай өнөөгийн ардчилал нь эртний Грекчүүдийн (тэд энэ санааг анх бодож олсон гэдэг) ардчиллаас тэс өөр. Тэд ‘ардчилал’ гэдэг үгээр иргэд нь өөрсдөө нээлттэй хурал цуглаан зохион байгуулж хуулиа баталдаг, гол бодлогуудаа тодорхойлдог (дайнд оролцох эсэхээ шийдэх г.м), албан тушаалтнуудаа томилдог засаглалын тогтолцоог хэлдэг байв. Харин бидний хувьд ардчилал гэдэг нь олон түмэн тогтмол хугацаанд буюу тодорхой цөөн хэдэн жилийн зайтайгаар сонгуульд саналаа өгөх байдлаар өөрсдийнх нь өмнөөс хууль баталж, бодлого боловсруулж, төрийн албан хаагчдыг томилдог төлөөлөгчдөө (ерөнхийлөгч, парламентын гишүүд, сенаторууд) сонгодог засаглалын тогтолцоо.

Орчин цагт ч олон утгыг агуулна. Ардчиллыг сонгууль нь чөлөөт, шударгаар явагддаг, саналаа нууцаар хураадаг, олон нэр дэвшигчдийн сонголттой, албан тушаалтнуудын эрх мэдэл нь хязгаарлагдмал, албан тушаалтнууд нь хууль ёсонд захирагдан албан үүргээ гүйцэтгэж байгаа эсэхийг хянадаг бие даасан шүүхийн тогтолцоотой засаглалын тогтолцоо гэж тодорхойлж болно. Нөгөө талаар, ‘ардчилал’

гэсэн үгээр дээрх идеал шинжүүд хагас дутуу эсхүл огт байхгүй тогтолцоонуудыг ч тодорхойлох нь олонтаа. Өөрсдийгөө ‘ардчилсан’ гэж тодорхойлдог олон улс оронд үнэн хэрэгтээ санал хураалт нь нууцаар явагддаггүй, сонгуулийн хорооны албан тушаалтнууд нь шударга бус үйлдэлд гаршсан, сонгогчид нь дарамт дор саналаа өгдөг, нэр дэвшигчид нь айдастай, хэвлэл мэдээлэл нь олон нийтийн санаа бодлыг хянадаг, иргэдийн төлөөллүүд нь авлига ялзралд автсан байх нь элбэг.

Зарим тохиолдолд улс орнууд ардчилсан дүр эсгэдэг (сонгууль, парламент, шүүх) боловч зөвхөн цор ганц нам л сонгуульд нэр дэвшигчдээ оролцуулах эрхтэй байх нь бий. Ийм системд бодлого боловсруулагчид, шүүгчид нь удирдан захирагчийн гарын аясаар хөдөлдөг агаад албан тушаалтнууд нь иргэдийн ахуйг амьдралыг шийдэх хязгааргүй эрх мэдэлтэй байдаг. Үүний тод жишээ нь Умард Солонгос. Энэ улсад сонгуулийн ирц бараг л 100 хувь. Солонгосыг Нэгтгэх Ардчилсан Фронтын нэр дэвшигчдэд өгсөн саналын хувь нь өмнөх дүнтэй ойролцоо (түгшүүрийн дохио).

АРДЧИЛЛЫГ ХЯЗГААРЛАХУЙ

Ардчилал нь олонход хүссэн бүхнээ гүйцэлдүүлэх эрхийг олгодог гэдэг санаа бол ардчиллыг дагадаг хамгийн нийтлэг төөрөгдөл. Бага зэрэг лавшруулан судлахад л тус ойлголтын буруу нь мэдэгдэнэ. Сонгуульд яллаа гээд л олонх нь цөөнхөө хорьж цагдах, цөлөх, эрүүдэн шүүх, алж хөнөөх, тэдний орон гэр, бизнес, эд баялгийг нь хураан цөлмөх эрхтэй болчих хэрэг үү? Хүн төрөлхтөнд олонхын зарчмаас илүү дээгүүрт тавигддаг үнэт зүйлс бий. Олонх тэрхүү үнэт зүйлсийг уландаа гишгэхээр шийдсэн гэдэг нь тэдний үйлдлийг улс төр, ёс суртахууны хувьд зөвтгөх зөвтгөл болж чадахгүй.

Аль 2400 жилийн өмнө эртний Грекийн сэтгэгч Платон, түүний шавь Аристотель хоёр үүнийг ойлгосон байжээ. Тэд ардчиллыг маш аюултай засаглалын хэлбэр гэж үздэг байсан нь чинээлэг, сурвалжит гаралтай байсантай нь ч холбоогүй. Ардчилал нь хялбархнаар олон түмний дээрмийн шинжтэй засаг захиргаа болж хувирах боломжтой ба ийм нөхцөлд хэний ч амь нас, эрх чөлөө, өмч хөрөнгөнд баталгаа гэж үгүй. Аристотель (НТӨ 350 он) өөрийн ‘Улс төр’ номондоо “Шударга ёс зонхилж чадаагүй үед ард түмэн өөрсдөө хаан болж, ганцаар төр барихыг зорьж, эзэн дээдэс шиг аяглахад хүрдэг” гэж бичсэн удаатай.

Хоёр мянган жилийн дараа газрын эзэд, боолын эзэд, мөн өөр бусад алдартнуудаас бүрдсэн 55 хүн шинэ тутам байгуулагдсан Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хуулийг хэлэлцэн батлахдаа яг дээрх асуудал дээр санаа сэтгэлээ чилээж байсан түүхтэй. Тэд Грек маягийн бүх асуудлыг ард иргэдээр шийдвэрлүүлдэг ардчиллыг бус, ард нийт өөрсдийнхөө өмнөөс шийдвэр гаргах төлөөллөө сонгодог ардчилсан бүгд найрамдах ёсыг цогцлоосон билээ. Тэд хувь хүмүүс болон цөөнхийн эрхийг хамгаалах зорилгоор албан тушаалтнуудын эрх мэдлийг хязгаарлан, шийдвэр гаргах процессыг нарийн хянамгайгаар боловсруулсан боловч хуулийн хамгаалалт нь хүн амын дөрөвний нэгийг бүрдүүлж байсан боолууд болоод уугуул Америкчуудад хүртээлгүй байсан нь харамсалтай.

Ардчиллын институциуд нь бидний амьдралыг өмнөөс минь шийдвэрлэх бус, бидний үнэт зүйлсийг сахин хамгаалах үүрэгтэй гэдэг нь жинхэнэ либерал ардчиллын үзэл баримтлал (орчин үеийн утгаараа). Ардчиллын үндсэн зорилго нь ард иргэдийг хязгаарлан хянах бус, чөлөөлөх явдал гэдэгт итгэдэг либералууд нь (либерал гэх үгийг Европт ойлгогддог утгаар нь ашиглав) албадлага, хүчирхийллийг хамгийн нам түвшинд, хувь хүний эрх чөлөөг

хамгийн дээд түвшинд байлгах гэж төр засгийг байгуулсан хэмээн үздэг. (Батлер 2015)

Эрх чөлөө, энх тайвныг хадгалж хамгаалахын тулд олонхын засаглал хязгаарлагдах ёстой. Жинхэнэ бодит либерал ардчилалд дийлэнх олонх, тэр ч бүү хэл мянган хүн ч нэг хүний эсрэг хүссэн бүхнээ хийх эрхгүй бөгөөд олонх нь хувь хүн нэг бүрийн үндсэн эрхийг харгалзаж, хүндэтгэх ёстой гэж либералууд хэлдэг. Эдгээр эрх, эрх чөлөө нь олонхын санаа бодол, хүсэл зоргоос илүү тэргүүлэх ач холбогдолтой ба төр засгийг байгуулахын үндсэн шалтгаан нь үүнийг хамгаалах явдал аж.

Либералууд хувь хүний эрх гэдэгт чухам юуг багтаах, хаанаас эх сурвалжаа авдаг вэ гэх зэрэг асуудлууд дээр тэр бүр санал нийлдэггүй. Гэсэн ч либерал ардчилалд л хувь хүмүүсийн эрх, эрх чөлөө өөр бусад ямар ч тогтолцоотой харьцуулахад хавьгүй илүү хамгаалагддаг. Америкийн улс төрийн эдийн засагч Жейми Лемке (2016) олон янзын улс төрийн тогтолцоонуудын өрсөлдөөн нь иргэдийнхээ хувь хүний онцлог, эрх чөлөөг дээдэлдэг улсууд руу хүмүүсийг илүү олноороо шилжин суурьшихад түлхэц болдог гэсэн санааг дэвшүүлсэн.

СЭТГЭЛ ТАТАМ АРДЧИЛАЛ

Ардчилсан тогтолцоог дэмжигсдийнхээр хууль тогтоох үйл явц нь хэн нэг элит хувь хүний (хаан эсхүл ерөнхийлөгч), бүлгийн (захирагч гэр бүл болон сурвалжтанууд) өнгө үзэмжээр тодорхойлогдох ёсгүй. Олон нийт өөрсдөө хуулиа тогтоож, түүнийгээ мөрдөж амьдрах, үгүйдээ л хууль тогтоогчдоо өөрсдөө сонгох нь зүйтэй. Сонгогчид улс төрийн тэгш эрхтэй байхыг ардчилагчид шаарддаг. Аль болох олон иргэнийг санал өгөх боломжоор хангах нь хамгийн идеал нөхцөл. Хүмүүс чухал асуудлуудын талаар бодож сэтгэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй байх ёстой. Сонгогчид өөрсдийн төр засгийн тухайд сайтар мэдээлэлтэй, чадварлаг, ухаалаг байх нь мөн адил хамгийн идеал нөхцөл. Үүний зэрэгцээ тогтвортой, итгэлтэй, зүй зохистой институциуд олон нийтийн шийдвэрийг зөв хөрвүүлж бодлого болгох шаардлагатай.

Үнэхээр ч ардчиллын идеалууд сэтгэл татам. Бараг бүхий л төр засаг өөрийгөө эдгээр идеалуудыг нандигнан эрхэмлэдэг хэмээдэг ч бодит байдал дээр тийм байдаггүй нь харамсалтай. ‘Ардчилал’-аар овоглуулах нь хүндэтгэл хүлээснийг харуулах бэлгэ тэмдэг. Хорьдугаар зууны Английн алдарт зохиолч Жорж Оруэллын (1946) цохон тэмдэглэснээр

“Аливаа улсыг ардчилсан гэж дуудахад улсыг нь магтаж байна гэдгийг мэддэг болохоор аль ч дэглэмийг хамгаалагчид өөрсдийн дэглэмийг ардчилал гэж нэрлэдэг”.

Үр дүнд нь ‘ардчилал’ гэх үгийн утга санаа алдагдав. ‘Ардчилсан’ сонгуульд ялалт байгуулсан олонхын намууд өөрсдийгөө бусдыг хавчин гадуурхах, төрийн мөнгийг явцуу эрх ашгийнхаа төлөө зарцуулах, засгийн газрын ажил үүрэг, гэрээ хэлцлийг өөрсдийн хамсаатнуудад олгох эрхтэй гэж үзэх нь бий. Дарангуйлагчид улс төрийн өрсөлдөгчдөө хорьж цагдан, 100 хувийн саналаар ялалт байгуулдаг хуурамч сонгууль зохион байгуулахын сацуу өөрсдийгөө “ардчиллаар сонгогдсон” гэж тунхаглана. Олон оронд эрх баригчдыг шүүмжилсэн л бол эх орноосоо урвасан зүйл заалтаар яллагдах боломжтой. Эрх мэдлийг ийнхүү урвуулан ашиглах үйлдэл нь ардчиллын үзэл санааг өөрийг нь гутаадаг.

ОЙЛГОЛТЫН БАС БУС АСУУДЛУУД

Ардчилал гэх үгийн утга санааг ингэж зориудаар гуйвуулдаг. Үүнээс гадна ардчиллын мөн чанарын талаарх эндүүрлүүд өргөн хүрээнд тархав. Ази тивд маш олон хүн ардчиллыг зөрчил тэмцэл, шийдэмгий бус байдал, богино хугацааны бодлогод төвлөрөх зэрэг үр дагаварыг бий болгодог гэж буруушаана. Тэд ардчиллын хүч, дэмжлэг, уян хатан чанар зэрэг шинжийг нь үл хайхардаг. Гэтэл Өрнөдөд харин ч эсрэгээрээ маш олон хүн хөгжил дэвшил, эрх чөлөө, тэгш байдал, энх тайвныг авчрах цорын ганц түлхүүр нь ардчилал гэж боддог. Тэдний ардчиллын талаарх үзэл бодол хэт өөдрөг тул ардчиллын сул талуудыг олж хардаггүй.

Үнэн хэрэгтээ ардчиллыг сохроор тахин шүтэх нь ардчилалд учирч болох хамгийн том аюул. Ардчиллыг шүтэн бишрэгчид ардчилал нь олонхын зөвшилцөлд тулгуурладаг учраас засаглалын хамгийн сайн хэлбэр гэнэ. Гэтэл олонхын санал хураалт шийдвэр гаргах хамгийн шилдэг арга зам мөн л юм бол бид яагаад бүх шийдвэрээ энэ маягаар гаргаж болохгүй гэж? Олон хүнийг гижигддэг тус санааны үр дүнд, нэгэн цагт хувь хүний эрх чөлөөний асуудал хэмээн тооцогддог байсан яаж амьдрах, юу идэж уух, ямар үг хэлэх гэх мэт зүйлс улам бүр олон нийтийн бодол санаа бодолд захирагдаж,

хязгаарлагдах боллоо.

Ардчилалд зориулалтын бус үүрэг даалгавар оноож болохгүй. Либералуудынхаар ардчилал нь хувь хүн дангаараа шийдвэрлэх боломжгүй улс орны батлан хамгаалах мэтийн цөөн хамтын шийдвэрүүдийг гаргахаас илүү хүрээ хязгаараас давах зорилготой байсангүй. Ардчилал нь хувь хүнийг олонхын хүсэл зоргод захирагдуулах, эрх чөлөөг нь хумих бус, хүний эрх чөлөөг хамгаалах, өргөжүүлэх зорилготой. Ардчилал нь албадлагыг хамгийн бага хэмжээнд байлгахын төлөө бий болсноос бус, албадлагыг хуульчлах зорилготой байсангүй.

БҮРЭН ТОДОРХОЙ ОЙЛГОХ ШААРДЛАГА

Ардчиллыг тодорхой хэмжээгээр хязгаарлах ёстойг умартан, сул талыг нь мартагнуулах нь ардчиллыг тахин шүтэхийн эмгэнэл. Олонхоор шийдвэр гаргах аргачлал нь харьцангуй цөөн тооны хамтын шийдвэрт л тохиромжтой. Хувь хүн асуудлаа өөрөө бүрэн дүүрэн шийдвэрлэх явдлыг гажуудуулах хэрэгсэл нь ардчилал биш. Хувь хүний эрх чөлөөг хүндэтгэж буй үед л ардчилал хүчин төгөлдөр оршино.

Ардчиллын идеал, бодит байдал хоёрын хооронд асар том зөрүү бий. Олонхоор шийдвэр гаргах үйл явцыг хэт өргөжүүлбэл улс төр нь том, жижиг гэлтгүй хүний амьдралын бүхий л хүрээнд нэвтэрч ардчиллын үзэл санааг гутаадаг. Ийм ч учраас хүмүүс ардчилалд дургүйцэж, ардчиллыг зөвхөн улс төрийн ашиг хонжооны арга хэрэгсэл гэж харах эрсдэл үүсдэг.

Иймээс ардчилал нь чухам юу вэ, юу биш вэ гэдгийг ойлгох нь маш чухал. Бид ‘ардчилсан’ гэж гэгддэг улс төрийн тогтолцоонуудын яг аль нь ардчиллын идеал, зарчимд нийцэж байгааг тодорхойлж чаддаг байх хэрэгтэй. Ардчиллын гол зорилгыг ойлгож, сул талуудыг нь хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Ардчилал юуг шийдвэрлэхэд тохиромжтой, тохиромжгүй болохыг ойлгох ёстой. Ардчилсан сайн засаглалыг бий болгоход шаардлагатай бүхнийг,

ардчиллыг гажуудуулдаг бүхнийг олж мэдсэн байх шаардлагатай. Дийлэнх олонхын саналыг үл тоогоод ч хамаагүй хадгалж хамгаалбал зохих эрхэм дээд үнэт зүйлс байдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Ардчиллыг тодорхой хүрээгээр хязгаарлаж байх хэрэгтэйг ухаарах хэрэгтэй. Ардчилал нь хадгалан, хуулбарлахад хэцүү соёл, ёс суртахуун, институцийн тулгуур дээр оршин тогтнодгийг үнэлж, ойлгох ёстой. Ардчиллыг ойлгох, хэрэгжүүлэх, хадгалж хамгаалахад ихээхэн хүчин чармайлт шаардлагатай гэдгийг үргэлж санаж явах хэрэгтэй.

II

АРДЧИЛЛЫН ТҮҮХЭЭС

‘Ардчилал’ (демократи) хэмээх үг нь Англи хэлэнд XVI зуунд Франц хэлнээс орж ирсэн боловч эх сурвалж нь нэн эртнийх. Микенийн үеийн Грекчүүд хүн амын бүлгийг дамос гэж нэрлэдэг байсан нь магадгүй Иракийн Өмнөд нутагт оршин тогтнож байсан Шумерын думу гэсэн ойлголтоос гаралтай байж болно. Сонгодог Грек хэлэнд демос нь ‘ард түмэн’ эсхүл ядуусын ‘олонх’ гэсэн утгатай болж, кратос (‘эрх мэдэл’ буюу ‘хяналт’)-тай нийлж ‘демократи’ гэдэг үгийн үндсийг бий болгосон.

ГРЕКИЙН АРДЧИЛАЛ

Месопотами буюу Тигр, Евфрат мөрний хөндийд орших ‘үржил шимтэй хавирган сар’ хэмээх газар ойролцоогоор 5000 жилийн өмнө суурьшсан Шумерийн иргэншил нь дэлхийн ууган соёл иргэншил. Зарим эрдэмтэд Шумерчуудыг эртний ардчиллын зарим элементийг агуулсан төрийн тогтолцоотой байсан гэж таамагладаг ба Урук хотын Гильгамеш зэрэг хаадууд нь ганцаар захирах бус, ахмадын зөвлөлтэй хамтарч эрх мэдлээ хэрэгжүүлдэг байсан байх магадлалтай. Гэсэн хэдий ч үүнийг барим тавим нотлох нотолгоо хомс.

Дорно зүгт буюу Хиндустанд хүртэл ойролцоогоор 2600 гаруй жилийн өмнө тусгаар тогтносон ‘бүгд найрамдах улсуудад’ ардчиллын зарим хэлбэр үүссэн байж болзошгүй. Хаад буюу Ража нар нь эрх чөлөөт эрчүүдэд нээлттэй, өргөн хүрээний улс төрийн эрх мэдэлтэй, тогтмол цугладаг зөвлөлдөх хурлуудын хүрээнд засаг барьдаг байлаа. Мөн л дэлгэрэнгүй мэдээлэл дутмаг агаад судлаачид үүнийг жинхэнэ ард түмний засаглалын жишээ мөн байсан эсэх дээр санал зөрдөг.

Харин 2500 жилийн өмнө Грект (голчлон Афинд) ардчилал нь бодит утгаараа хэрэгжиж байсныг нотлох баримтууд хангалттай бий.

Грекийн сонгодог иргэншлийн үед ойролцоогоор 1000 орчим жижиг ардчилсан дэглэмтэй хот-улсууд (эдгээр полисын нэршил нь улс төр гэх үгийн үндэс болсон) оршиж байв. Эдгээр жижиг нийгэмлэгүүдэд эрх мэдэл цөөн элитүүдийн гарт тун хялбарханаар төвлөрөх боломжтой байлаа. Ардчиллын санаа нь үүнээс сэргийлж, улс төрийн бодлогоо илүү өргөн хүрээнд нийтээрээ шийдвэрлэхэд оршиж байсан. Хэдийгээр Афин нь ‘ардчилсан’ гэх шошготой байсан хэдий ч эмэгтэйчүүд, хүүхдүүд, боолууд, гадаадын иргэдийг улс төрд оролцуулдаггүй байв. Нийт хүн амын цөөн хэсгийг л хамрах 6–10 мянга орчим Афины эрчүүд нээлттэй хуралдаан зохион байгуулж, хууль тогтоомж, дайн байлдаан, албан тушаалтнуудын томилгоо зэрэг асуудлуудаа хэлэлцэн шийдвэрлэдэг байжээ.

Афины төрийн зүтгэлтэн, цэргийн жанжин Перикл (НТӨ 431) ардчиллын идеалыг тун оновчтой тодорхойлсон. “Хамтын бүрэн эрхт байдал, улс төрийн тэгш эрх, эрх чөлөө, хүлцэн тэвчихүй, хууль дээдлэх ёс болон бусдын болон өөрийн эрх үүргийг хүндэтгэх”. Гэвч олон нийтийн нээлттэй хуралдааны хэт эрх мэдэл болон тогтворгүй шинжийг Аристотель, Платон зэрэг эртний сэтгэгчид анхааруулж байлаа. Ядуу иргэдийн олонх нь зөв шийдвэр гаргах ухаан мэдлэггүй, харалган учир демагогуудын нөлөөнд

хялбархан автах боломжтой гэв. Тэд ардчилал нь олны хүчээр дарангуйлах дарангуйллын шинэ хэлбэр буюу олонхын дарангуйлал болж хувирна гэдгээс санаа нь зовниж байв. Эсвэл олонх зүгээр л чинээлэг хүмүүсийн (тэднийг өөрсдийг нь оролцуулаад) өмчид халдаж, олонхын саналд үндэслэж дээрмээ хууль ёсны болгоно гэдгээс айж байв.

Уг асуудлаарх Платоны шийдэл нь төрийн хэргийг 'философич хаадад' даатгах юмсанж. Харин Аристотель төгс хүн, төгс хаан бодит байдал дээр оршдоггүй гэдгийг сайтар ойлгосон байдаг. Тэрээр ардчилал нь (эртний Грекийн ардчиллыг ядуусын засаглал гэж тооцож болно) ард иргэдийг олигархиас (чинээлэг хүмүүсийн засаглал) хамгаалж болох ч ардчиллыг өөрийг нь хязгаарлахын тулд баян ядуугийн ангиллын аль алинд нь багтдаггүй иргэд (дундаж анги) шаардлагатай гэж сургамжилж үлдээжээ. Тийм иргэн тун цөөхөн байсан нь гачлантай.

РОМЫН БҮГД НАЙРАМДАХ УЛС

Эртний Ромын сэтгэгчид ижил төстэй байдлаар ардчиллаас болгоомжилж байв. Үгүйдээ л тэдний хувилбар нь тодорхой институциудын хүрээ хязгаараар хязгаарлагдаж байсан. Хожим нь Цезариудын ганцаар засаглах ёсоор солигдсон ч гэлээ Ром нь анхандаа Бүгд найрамдах (Латинаар *res publica* буюу ‘ард түмний зүйл’) төрийн засаглалтай байсан.

Бүгд найрамдах засаг гэдэг нь шийдвэр гаргах эрх мэдлийг тодорхой хүрээнд хязгаарласан, тодорхой дүрэм журмын дагуу үйл ажиллагаа явуулдаг засаглалын хэлбэр юм. Эдгээр дүрэм журам нь албан тушаалтнуудын эрх мэдлийг хязгаарлаж, цөөнх болон хувь хүмүүсийг элдэв дур зоргын шийдвэрээс хамгаалах зорилготой. Бүгд найрамдах засаг нь олон нийтийн төлөөлөгчид хууль тогтоодог ‘ардчилсан’ эсхүл өөрсдийгөө сонгодог элитийн буюу ‘олигархи’ дэглэмийн аль алин нь байж болох ч хүлээн зөвшөөрөгдсөн тодорхой дүрэм журмаар хязгаарлагддаг.

Ромын бүгд найрамдах улсад дээрх шинжүүдийн аль алин нь холилдсон байдалтай байсан бөгөөд хэзээ ч жинхэнэ ёсоороо ард түмэн засаглаж байсангүй. Тус улсын хоёр консул бараг л хаантай дүйцэхүйц эрх мэдэлтэй байсан ба тэднийг иргэд бус, язгууртнуудын хорооноос

сонгодог байв. Ромын сенат ч мөн адил олон нийтийн төлөөлөгчдээс бус язгууртнууд болон сурвалжтангуудаас бүрддэг байлаа. Гэсэн хэдий ч сонгуулийн эрхтэй сонгогчид болох эрэгтэй иргэд (cives) тодорхой тооны зарим чухал албан тушаалтнуудыг, тухайлбал хууль тогтоомжид хориг тавих эрхтэй трибун болон хуулийг хэрэгжүүлэгч магистратуудыг сонгох, огцруулах боломжтой байв.

Онцгой байдлын үед иргэдийн оролцоо бүр ч илүү хумигддаг байсан нь энэ үед Сенат болон консулууд диктаторыг томилох эрхтэй байсанд оршино. Диктаторууд нь тодорхой хугацаанд хүчин төгөлдөр үйлчилдэг онц бүрэн эрхтэй төр баригч. Удалгүй диктаторууд насан туршийн эрх мэдэлтэй хаад болон хувирчээ. Анхны хаад нь хуучны Бүгд Найрамдах Улсын институцийн хэлбэрийг ёс төдий хадгалахыг эрмэлздэг байсан ч гэлээ бодит эрх мэдлийг хэн атгаж байгаа нь хэнд ч тодорхой байсан.

ДУНДАД ЗУУН

Исландын Алтинг нь НТ 930 онд байгуулагдсан. Одоо ч оршин тогтнож буй уг байгууллагыг дэлхийн хамгийн анхны парламент гэж тооцдог. Бүх эрх эрх чөлөөт эрчүүдэд нээлттэй байсан ба тэд жил бүр Тингвеллир дэх ‘хуулийн хад’-ны өмнө цугларч хэлэлцүүлэг өрнүүлдэг байв. Хууль өгүүлэгч гэх нэг хүн тухайн цагт мөрдөгдөж буй бүх хууль, журмыг уншиж танилцуулдаг байсан. Хэдий уг уулзалтаар ерөнхий хэлэлцүүлэг өрнүүлдэг байсан боловч зөвхөн нэр нөлөө бүхий 50 иргэн л хуулийн асуудлаарх шийдвэрийг гаргадаг байж.

1215 онд Английн сурвалжтангууд дарангуй хаан Жонтой нүүр тулж, хааныгаа Магна Карта хэмээх баримт бичгийг хүлээн зөвшөөрөхийг шаардсан нь хаадын эрх мэдлийг хязгаарлаж, ялангуяа шинэ хууль тогтоомж, татвар соёрхон батлахад Баронуудын өөрсдийнх нь зөвшөөрөл шаардлагатай гэдгийг тулган хүлээлгэсэн. Энэ нь Английн парламентын эх үндэс болсон юм (Butler 2015b).

Энэ цаг үетэй зэрэгцэж Европын бусад хэсэгт худалдаа, арилжаанд тулгуурласан хотууд хөгжиж, өөр өөрсдийн хууль журмаа боловсруулж байлаа. Ингээд Хаадын бурханаас эхтэй эрх мэдлийн тухай ойлголтонд сорилт

учирснаар шийдвэрийг ганц нэг хүчирхэг, төвлөрсөн эрх мэдэлтэй удирдагч бус олон нийтийн зөвшилцөлд тулгуурлан гаргах тухай санаа улам бүр түгсэн байна.

XV зууны сүүл үеийн Италийн хот улсуудыг бүгд найрамдах улсууд гэж нэрлэх боломжтой. Гэхдээ илүү нарийвчлан өгүүлбэл эдгээр нь хуульчлагдсан олигархын засаглал байлаа. Шийдвэр гаргах эрх мэдэл нь олон түмэнд бус, цөөн тооны бүлэглэлд төвлөрч байсан ч тодорхой хүлээн зөвшөөрөгдсөн дүрэм журмын хүрээнд явагддаг байв. Философич, дипломатч Никколо Макиавелли (1513) улс төрийн үйл явцад олон нийтийн үзэл бодол чухал гэдгийг сайтар ойлгож өөрийн нөлөө бүхий улс төр, төрийн удирдлагын тухай бүтээлдээ ард түмний дэмжлэгийг авах нь маш чухал болохыг тухайн цагт засаглаж асан олигархиудад зориулж зөвлөсөн байдаг.

ТҮРҮҮ ОРЧИН ҮЕ

Хойд Европт, ялангуяа арилжаа худалдаанд тулгуурласан эдийн засагтай Нидерланд мэтийн улсуудад эрх мэдэл улам бүр төвлөрсөн бус шинжтэй болж эхэлсэн. Ардчиллын үзэл санаа цааш түгэхэд XIV-XV зууны үеийн Реформаци ихээхэн нөлөөлөв. Реформацийн нөлөөгөөр хүн бүр Бурханы өмнө тэгш эрхтэй гэсэн үзэл санаа дэлгэрч, ард олны бичиг үсгийн боловсрол эрс дээшилжээ. Протестант урсгалын номлолоор сүсэгтэн Бурханы үгийг санваартнуудаар дамжуулахгүй бие дааж судлах нь илүү чухал.

Британийн арлуудад Хүчирхэг хаант засаглал (автократ) болон ардчиллын үзэл санааны хоорондох зөрчил гаарч 1640-өөд онд Чарльз I хаан парламентын зөвшилцөлгүйгээр татвар нэмэгдүүлэх шийдвэр гаргасан нь иргэний дайнд хөтөлсөн. 1647 онд язгууртны давуу эрхийг эсэргүүцэгч Левеллерүүд хаант засаглалыг юугаар орлуулах талаар хэлэлцүүлэг өрнүүлэв. Тэдний санал болгосон ардчилсан засаглал, бүх нийтийн байнгын шударга сонгууль, хуулийн өмнөх тэгш байдал, шашны хүлцэл, албадан цэрэг татлагыг халах зэрэг саналууд нь орчин үеийн ардчиллын гайхамшигтай институциудын эхлэл болсон. Гэвч Чарльзыг түлхэн унагасны дараа эрх мэдэлд хүрсэн парламентын лидер Оливер Кромвель

өмнөх хаанаас дутахгүй автократ болж хувирчээ. Тэрээр Левеллерүүдийг баривчилж, арван хоёр жилийн хугацаанд цэргийн засаглал тогтоосон байна.

Энэ явдалтай холбоотой үймээн самуун эцэстээ төр засгийн эрх мэдлийн эх сурвалж, төрийн үүрэг юу вэ гэдгийг эрэгцүүлэхэд хүргэжээ. XVII зууны Английн философич Томас Хоббс (1651) төр нь хувь хүмүүс нэг нэгнийнхээ шунал, харилцан түрэмгийллээс өөрсдийгөө хамгаалах зорилготой ‘нийгмийн гэрээ’-нээс үүдэлтэй гэж үзсэн. Тэрээр энэ шинэ дэг журмын ‘тэргүүн’ болох хаан бүрэн хяналтыг хэрэгжүүлэх эрх мэдэлтэй байх ёстой, учир нь энэ нь яг л хүний биеийн толгойтой ижил гэдэгт итгэсэн байна. Эрх мэдлийг хэн ч сөрөх ёсгүй, учир нь энэ нь нийгмийг эмх замбараагүй дайны байдалд буцааж авчирна гэж тэр үзсэн. Харин арай хожуу үеийн Английн философич Жон Локк (1689) ‘нийгмийн гэрээ’-ний үзэл санааг арай өөр өнцгөөс тайлбарлав. Тэрээр хувь хүмүүс өөрсдийн эрх, эрх чөлөөг хамгаалж, өргөжүүлэхийн тулд төрийн аппаратыг байгуулдаг гэх онолыг боловсруулсан. Тиймээс төрийн эрх мэдэл нь зөвхөн хувь хүмүүсийн сайн дураар шилжүүлсэн эрхээр хязгаарлагдана. Хаан нь ард түмэндээ үйлчлэхийн тулд оршдог учраас өөрийн хүслийн дагуу дур зоргоор

үйлдэх эрхгүй. Хэрэв хаан ард түмний итгэлийг хөсөрдүүлж, дарангуйлж эхэлбэл түүнийг түлхэн унагаах эрх ард түмэнд бий гэж Локк үзсэн.

Тухайн цагт Жеймс II гэх өөр нэг хаан хаан ширээнээсээ ховхорсон байв. Ирээдүйн эзэн хаан Уильям III ард түмэн болон парламентын эрх мэдлийг хүндэтгэж, хүлээн зөвшөөрнө гэдгээ 1689 оны Эрхийн тунхаг хэмээх баримт бичгээр баталгаажуулж гэмээнэ хаант засгийг дахин сэргээхэд хүрэв. Үндсэн хуулийн арга хэрэгслээр хааны эрх мэдлийг хязгаарласнаар Англи нь Үндсэн хуульт хаант улс болсон билээ. Өнөөдрийг хүртэл ийм нэршилтэй хэвээр байгаа ч хааны эрх мэдэл улам бүр хумигдаж, голлох эрх мэдэл олон нийтийн сонгуулиар бүрддэг парламентад шилжсэн тул орчин үеийн Британийг Үндсэн хуульт ардчилал гэж нэрлэх нь илүү зохистой байж мэднэ.

ҮНДСЭН ХУУЛЫТ БҮГД НАЙРАМДАХ ЗАСАГ

Жон Локкийн үзэл санаа хожмын Америкийн Нэгдсэн Улсыг үндэслэн байгуулсан хүмүүст ихээхэн нөлөө үзүүлсэн. Локкийн адилаар тэд хааны дур зорго, хязгааргүй эрх мэдлийг эсэргүүцэж, 1776 оны Тусгаар Тогтнолын Тунхаг-т Жорж III хааны “эрх мэдлээ зүй бусаар урвуулан ашиглаж, хууль бусаар халдлага үйлдсэн” жишээнүүдийг нэг бүрчлэн тоочсон байдаг. Тэд улс төрийн тэгш байдалд онцгойлон ач холбогдол өгч байсан боловч мөн адил тун хялбархан олонхын дарангуйлал болж хувирах боломжтой гэж ардчиллаас эмээж байв. Уг асуудлыг хэлэлцсэний эцэст олон түмний улс төрийн оролцоо нь зөвхөн сайн засаглалын нэг хэсэг гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Тэд тодорхой дүрэм журам, зарчимд тулгуурлаж нарийн чамбай зохион байгуулагдсан, ард түмний сонгосон төлөөлөгчид шийдвэр гаргадаг, гэхдээ эдгээр төлөөлөгчид бусдын л адил хуульд захирагдаж, эрх мэдэл нь Үндсэн хуулиар тодорхойлогдож, хязгаарлагддаг бүгд найрамдах засаглалын тогтолцоог байгуулахыг эрмэлзсэн.

Ардчилал нь эрх чөлөө биш. Ардчилал нь хоёр чон, нэг хонь өдрийн хоолондоо юу идэх тухай санал хураалт явуулж байгаатай ижил. Эрх чөлөө нь 99 хувийн саналаар ч хүчингүй болгох боломжгүй тодорхой тооны эрхийг хүлээн зөвшөөрч, танин мэдэхээс эхтэй.

— Марвин Симкин ‘Хувь хүний эрх’ Лос Анжелес Таймс

Францын философич Монтескью (1748) ардчиллын үйл ажиллагаа, зорилго хэзээ ч бүрэн дүүрэн хэрэгжих чадамжгүй, учир нь хүмүүс нийтийн сонирхлоос илүүтэй хувийнхаа сонирхлыг тэргүүн эгнээнд тавьдаг гэж үзсэн. Ялангуяа төрийн албанд томилогдсон хүмүүс эрх мэдлээ урвуулан ашигладаг гэдэг нь Локк, Америкийн үүсгэн байгуулагчид болон тэдэнтэй үзэл бодол нэгдсэн олон хүний онцгой анхаарлыг татсан асуудал байв. Монтескьюгийн үзсэнээр, албан тушаалтнууд эрх мэдлээ урвуулахаас сэргийлэх цорын ганц арга нь хяналт, тэнцэл аж. Энэ нь тодорхой эрх мэдлийг өөр төрлийн эрх мэдлээр тэнцвэржүүлж хянах тухай санаа юм. Дөчөөд жилийн дараа эдгээр бүх санаа АНУ-ын шинэ Үндсэн хуульд тусгалаа олсноор эрх мэдлийн хуваарилалт, сонгуулийн коллегууд, албан тушаалтнуудын эрх мэдлийг хязгаарлах гэх мэтчилэнгээр хязгаарлагдмал төлөөллийн засаглалыг бий болгохыг зорьсон бусад механизмуудаар илэрхийлэгдсэн. (Гэвч эдгээр улс төрийн эрх, хамгаалалтууд нь тухайн үед Америкт амьдарч байсан 800,000 орчим боол болон уугуул иргэдэд хүртээлгүй байв.)

Харин Францын хувьд үйл явдал тэс өөрөөр өрнөлөө. 1789 оны хувьсгалын дараагаас бий болсон Айдсын Хаанчлалын эрин (1793–1794) нь Америкийг үүсгэн байгуулагчдын ардчилал нь

эмх замбараагүй байдал руу гулсчих боломжтой гэх болгоомжлол нь зөв байсныг нотолсон. Сонгогдсон олигархиуд нь олон нийтийн ‘нийтлэг хүсэл зорго’-ын дагуу засаглаж болно гэх Францын хувьсгалчдын итгэл үнэмшил нь үндсээрээ буруу байж, ердөө саналын зөрүү, хэрүүл маргаан, хүчирхийллийг л дагуулсан. Энэхүү Айдсын Хаанчлалын Эрин нь Английн улс төрийн онолч Эдмунд Беркийг (1790) ‘Ардчиллын үед олонх нь цөөнхдөө хамгийн харгис дарангуйллыг үйлдэх боломжтой’ гэж өгүүлсэн “Францын Хувьсгалын тухай эрэгцүүлэл” хэмээх бүтээлээ туурвихад хүргэсэн.

ЛИБЕРАЛ АРДЧИЛАЛ

1835 онд Францын өөр нэгэн сэтгэгч Алексис де Токвиль ‘Америк дахь ардчилал’ номоо хэвлүүлжээ. Америкийн бүгд найрамдах улсын илэрхий амжилт нь зөвхөн эрх мэдлийн төвлөрлийг задалсан, хяналт тэнцэл, хуваарилалт (‘федерализм’) болон Үндсэн хуулийн бусад чухал арга хэрэгслүүдээс шалтгаалаагүй гэж тэрээр дүгнэв. Америкийн нийгмийн соёл, ёс суртахуун ч мөн адил амин чухал гэж Токвиль үзсэн. Америкийн сүм хийд, буяны байгууллага, клуб, харилцан туслах нийгэмлэг, олон нийтийн холбоод гэх мэтийн иргэний нийгэм нь сонгуульд саналаа өгөх олон нийтийг сургаж, хариуцлагажуулах гол үүргийг гүйцэтгэдэг. Нийтлэг сонирхол, ёс суртахуун нь олонхын дарангуйлал руу халтирхаас сэргийлэх чадамжтай. Гэхдээ хүмүүс зөвхөн тухайн соёлынхоо л нэг хэсэг байж чадаж байгаа тохиолдолд л энэ нь боломжтой аж.

XIX зууны Английн их сэтгэгч Жон Стюарт Милл орчин үеийн либерал ардчиллын зарчмуудыг (1861) ерөнхийд нь тодорхойлсон. Грекчүүдийн нэгэн адил тэрээр хувийн сонирхолдоо хэт хөтлөгдсөн харизматик демагогуудаар удирдуулсан мунхаг, харалган олонхын дарангуйллаас эмээж байв. Эртний Афинтай харьцуулбал илүү өргөн

олон нийтийг хамарсан, бүх иргэдээ нэг дор цуглуулах боломжгүй болсон түүний ертөнцөд шууд ардчилал нь огт хэрэгжих боломжгүй байсан. Түүний бодлоор орчин цагт хэрэгжих боломжтой цорын ганц тогтолцоо нь төлөөллийн ардчилал. Гэхдээ олон түмний төлөөлөгчид нь зөвхөн сонгогчдынхоо өрөөсгөл үзлийг тоть шиг давтагчид байх ёсгүй. Харин тэд бие даан, хариуцлагатайгаар бодож, сэтгэж, үйлдэх ёстой, тэр ч бүү хэл зарим тохиолдолд шаардлагатай бол олон нийтийн санаа бодлыг ч сөрөх ёстой. Эдмунд Берк энэ тухай (1774) ‘Бристолын сонгогчдод хандсан үг’ хэмээх илтгэлдээ “Төлөөлөгч чинь таны өмнө зөвхөн хөдөлмөрөөрөө бус, эрүүл ухаанаараа үүрэг хүлээсэн. Хэрэв тэр таны бодол санаанд нийцүүлж өөрийн шүүн тунгаах чадвараа золиосолж байгаа бол танд үйлчлэх биш, таниас урвасан хэрэг” гэж мэдэгдсэн байдаг.

Хүний эрх гэдэг бол ямар нэг бурхнаас заяагдсан бэлэг эсхүл бидний мөн чанарын нэг хэсэг гэж Локк болон Америкчууд үзсэн бол, хүний эрхийг бидний даган мөрддөг ёс зүйн дүрэм хэмээн Милл тайлбарласан. “Эрх чөлөөний тухай” (1859) бүтээлээрээ алдартай Милл төр засаг зөвхөн хүний эрхийг хүндэтгэж, иргэдийн амь амьдрал, эрх чөлөө, хувийн өмчийг хамгаалж чадаж байгаа тохиолдолд л

оршин тогтнож, үндсэн үүргээ гүйцэтгэж чадна хэмээж байлаа. Дийлэнх олонх бусдын эрхийг хязгаарлахыг эрмэлзэж байгаагаас үл хамааран “Хүнийг бусдад хор хөнөөл учруулахаас сэргийлэх нь төрийн цор ганц үүрэг” гэжээ.

АРДЧИЛЛЫН ӨРГӨЖИЛТ...

Энэ цаг үеэс эхлэн либерал ардчиллын зарчмууд хэлбэржиж эхэлсэн ч гэсэн Британийн парламент нь бүрэн дүүрэн ардчилсан шинжтэй болж хараахан чадаагүй байв. Гэсэн ч XIX зуунд улам бүр хүчээ авсан либерализм нь авлигад идэгдсэн сонгуулийн тогтолцоог өөрчлөхийг шаардсан хүчирхэг олон нийтийн хөдөлгөөн болж хувирсан. Тухайн үед гагцхүү томоохон өмч эзэмшигчид л сонгуульд саналын эрхтэй байсан бөгөөд зарим газрын эзэд бүхэл бүтэн парламентын тойргийг хяналтдаа байлгаж, хээл хахууль, авлига, айдас сүрдүүлэг газар авсан байлаа. 1832 оны Их Шинэтгэлийн хууль нь нөхцөл байдлыг сайжруулахад дэм болсон ч үүний үзүүлсэн голлох нөлөө нь сонгогчдын хүрээг тэлсэнд оршино. Жижиг газрын эзэд болон түрээслэгчид санал өгөх эрхтэй болжээ. 1867 онд өрнөсөн дараа дараагийн реформ нь сонгуулийн эрхийг улам өргөжүүлж, орлого багатай ч 'нэр хүндтэй' ажилчин ангийн эрчүүдийг хамруулсан.

Англи гэлтгүй олон улс оронд эмэгтэйчүүдэд санал өгөх эрх олгоход олон жил шаардагдсан. Эмэгтэйчүүдийн сонгуулийн эрхийн анхны түүчээлээгчид дэлхий бөмбөрцгийн нөгөө хагасын Шинэ Зеланд, Австралид байсан ч Австралийн уугуул иргэдийн хувьд зарим

мужид 1965 он хүртэл уг эрхээ эдэлж чадахгүй байдалтай байсаар байв. Финлянд, Норвеги улсууд Дэлхийн Нэгдүгээр дайны өмнө эмэгтэйчүүдийг санал өгөх эрхтэй болгосон бол Австри, Герман, Польш, Орос, Нидерланд, АНУ, Швед зэрэг улсууд удалгүй энэ эрхийг баталгаажуулжээ. Их Британи 1918 онд өөрийн гэсэн өмчтэй эмэгтэйчүүдэд, хожим нь 1928 онд илүү өргөн хүрээнд сонгуулийн эрх олгосон. Харин Португаль, Швейцарьт эмэгтэйчүүд 1970-аад оныг хүртэл сонгуулийн эрхгүй байсан ба бидний өнөөгийн цаг үед ч гэсэн зарим улсад эмэгтэйчүүд сонгуульд оролцох эрхгүй байсаар байна.

... ХИЛ ХЯЗГААРАА ДАВСАН УУ?

Сонгуульд санал өгөх эрхтэй хүмүүсийн оролцоог зөвхөн өмчтэй эрчүүдээс нийт хүн амыг хамартал өргөжүүлсэн нь төлөөллийн засаг төрийн (өнөө үед үүнийг бүх нийтээрээ ардчилал гэж нэрлэх болсон) зүй ёсны легитим байдлыг илүү баталгаажуулж, энэ арга хэрэгслийг илүү өргөн хүрээнд хэрэгжүүлэх ёстой гэх үзэл санаанд түлхэц болж өгсөн. Ардчилал ийнхүү өргөжсөн явдал нь нийтлэг хөгжил дэвшлийн хурдацтай эрин үетэй давхацсан учраас сонгуульд оролцуулах эрхийг улам бүр өргөжүүлэх үндэслэлийг нэмэгдүүлсэн. (Үнэндээ эдийн засгийн өсөлт нь олон нийтийн санал хураалтаас илүүтэй чөлөөт худалдаа, нээлттэй зах зээл зэрэг либерал санааны хэрэгжилттэй холбоотой гэж үзэх нь зохимжтой.)

XX зуунд ийнхүү “ардчилал” нь зүй ёсны легитим шинжтэй гэх үзэл хандлага давамгайлснаар ардчилал өөрөө амьдралын бүхий л хүрээнд тархаж, эрүүл мэнд, боловсрол, тэтгэврийн хуримтлал, хандив буяны үйлс зэрэг хувь хүний түвшинд шийдвэрлэдэг асан олон асуудлыг хамтын шийдвэрээр шийдэх болжээ. Төрийн оролцох асуудлын хүрээ тэлэхийн хэрээр сонирхлын бүлгүүдэд өөрсдийн нөлөөг ашиглан татаас тусламж, татварын хөнгөлөлт гэх мэтийн тусгай эрх дархыг олж авах боломж

улам бүр нэмэгдсэн. Зууны эцэс гэхэд улс төрчид, лоббичид, ТББ-ынхан, комиссууд, шүүхүүд, зохицуулах агентлагууд, улс төрийн хэвлэл мэдээлэл, судалгааны төв гэх мэтийн байгууллагуудыг хамруулсан төрийн элит давхарга бүрэлдэн бий болж, хувь хүний амьдралтай холбоотой бүх асуудал уг бүлгийн анхаарлаас ангид байх боломжгүй болов.

Амьдралын бүхий л асуудал олонхын саналаар шийдэгддэг байсан бол яах байсныг төсөөл дөө. Зөвхөн пицца идэж, деним жинс өмсдөг болох боломжтой. Номын сангийн тавиур дээр зөвхөн алдартнуудын хоолны дэглэм, дасгалын номнууд л хөглөрөх байсан.

— П.Ж.О'Рурк (1991), Янхнуудын Парламент

АРДЧИЛАЛ МӨХСӨН ҮҮ?

Төлөөллийн төр засгийн легитим шинж илэрхий байвч шүүмжлэгсэд үүний бодит хэрэгжилт нь бүхэлдээ бүтэлгүйтсэн гэх нь бий. Тэдний хувьд бидний бий болгосон зүйл бол ардчилал бус харин ч сонгуулийн популист олигарх төрийн хэлбэр бөгөөд энэ нь ямар ч зарчимгүй хувийн сонирхол, богино зайн чиг баримжаанд тулгуурлаж, төрийг хяналтгүй данхайлгаж, хүнд суртлын бүтэц, крони капитализм, хариуцлагагүй хэт их зарлагад хөтөлж түүнчлэн олонхын саналаар хувь хүний эрх чөлөөг дарангуйлж байна гэж шүүмжилдэг. Маш олон энгийн хүмүүс улс төрийг өөрсдөдөө хамаагүй эсвэл өөрсдийн хяналтаас ангид зүйл гэж тооцох болсон хийгээд ингэж улс төрөөс хөндийрсөн нь улс төрийн элитүүдэд тэднийг улам бүр хялбархан мөлжих боломжийг олгох болсон гэж тэд үздэг. (Периклийн Афинчуудад хэлсэн ёсоор, та улс төр сонирхохгүй байна гэдэг нь улс төр таныг сонирхохгүй байна гэсэн үг биш.)

Гэвч харьцангуй либерал ардчилалтай улсууд дахь амьдрал, улс төр нь урьд цагийн олигархиудтай харьцуулахад хавьгүй илүү эрх чөлөөтэй, нээлттэй хэвээр байгаа нь үнэн. Мэдээж ардчиллын идеал нь зөвхөн хайхрамжгүй байдлаас бус авлига ялзралд идэгдэж болзошгүй.

Бидний өнөөгийн харьцангуй гэгээрсэн цаг үед ч гэсэн ‘ардчилсан’ гэж өөрсдийгөө нэрлэдэг засгийн газрууд сонгууль луйвардах, сонгуулийн эрхийг зүй бусаар хязгаарлах, цензур тогтоох, хөрөнгө хураах, дур зоргоор баривчлах, шүүхийг улс төржүүлэх, хууль ёсны шүүхийн шийдвэргүйгээр хорих зэрэг үйлдлүүдийг үйлдсээр байна. Үүнийг өөрчлөх эхний алхам бол ардчилал гэдэг нь чухам юу болох, ямар институци, зарчмуудаар хамгаалагддагийг тодорхой ойлгох зайлшгүй шаардлагатай.

III

АРДЧИЛЛЫН ИНСТИТУЦИУД

Бараг бүх засгийн газар өөрийгөө ардчилсан хэмээн тунхаглаж легитим харагдуулах гэж оролддог ч гэсэн ардчиллын идеалд тун цөөхөн нь л дөхөж очдог. ‘Ардчилсан’ гэгдэх дэглэмүүд хуурамч сонгууль зохион байгуулж, хэвлэл мэдээллийг хянаснаар шүүмжлэлийг боомилж, цагдаа шүүхийг ашиглан улс төрийн өрсөлдөгчдөө намнаж, хууль ёсны болон санхүүгийн эрх мэдлээ урвуулж өөрсдийгөө болон ойр дотны хүмүүсээ бэлжүүлэх нь элбэг. Экономист Интеллиженс Юнитын тайланд дурдсанаар дэлхийн хүн амын ердөө 5.2 хувийг хамарсан 22 улсыг л бүрэн дүүрэн, хууль ёсны ардчилал гэж тооцох боломжтой. Тэдгээр улсуудын 15 нь Баруун Европын улс аж. Албан ёсоор улсынхаа нэрэнд ‘ардчилсан бүгд найрамдах’ гэх нэршлийг багтаасан улсууд (тухайлбал Алжир, Этиоп, Хойд Солонгос, Лаос, Непал) хамгийн авторитари шинжтэй байх нь бий.

Иймд бид ардчилал гэж чухам юуг хэлээд байгаа тухай тодорхой ойлголттой болсноор, өөрсдийгөө өрөөлд ардчилсан мэтээр буруу ойлгуулдаг дэглэмүүдэд хууртагдахгүй байх нь чухал. Жинхэнэ ардчиллыг хуурамч ардчиллаас ялгахын тулд ардчиллын гол зарчмуудыг тодорхойлж, зураглалыг нь гаргах шаардлагатай.

АРД ТӨРИЙН ЭРХ МЭДЭЛ БА ҮНДСЭН ЗОРИЛГО

Ингэхийн тулд бид эхлээд төрийн үүрэг, зорилго юу вэ гэсэн асуултыг хөндөж, дараа нь ардчилал нь уг зорилгыг биелүүлэхэд хэрхэн тусалдаг вэ гэдгийг тодруулах хэрэгтэй.

Локк, Милл болон бусад либерал онолчдын хариултыг хураангуйлъя. Нийгмийн амьтан болох хүн төрөлхтөн ихэвчлэн бие биетэйгээ зохицож амьдардаг боловч заримдаа хүч хэрэглэх явдал давамгайлах, дээрэмдэж тонох, залилан мэхлэхээс буцахгүй хүмүүсийн албадлагад өртдөг. Төр байснаараа хувь хүмүүс зохион байгуулалттай шударга ёсны тогтолцоогоор хүчирхийлэл, албадлагаас сэргийлүүлж, эрх чөлөөгөө хамгийн дээд хэмжээнд эдлэх боломжтой болдог. Төр нь хувийн бие даасан онцлогтой бодгаль бус зөвхөн иргэдийн аюулгүй байдлыг хангах, эрх чөлөөг хамгаалахын төлөө оршино.

Эдгээр зорилгод хүрэхийн тулд иргэд төрд тодорхой эрх мэдэл өгөхөөс өөр аргагүй. Тухайлбал гэмт хэрэгтнүүдийг баривчлах, шийтгэхэд хүчирхийлэл, албадлага ашиглаж таарна. Энэ нь төрд хэмжээгүй эрх мэдэл өгнө гэсэн үг биш. Төрийн эрх мэдэл нь ард түмний нэрийн өмнөөс хэрэгжих ёстой. Төрийн эрх мэдэл иргэдээ хянахад ашиглагдаж огтоос

болохгүй, чингэвэл зорилгоо бүрэн үгүйсгэсэн хэрэг болно. Эл зохицуулалтууд нь зөвшилцөлд тулгуурлах ёстой. Мөн төр засгийн шийдвэрүүд хүн бүрт нөлөөлдөг тул хүн бүр энэ үйл явцад оролцож, тэдний үзэл бодол тэгш үнэ цэнтэй байвал зохино. Ардчилсан шийдвэр гаргах механизмын шаардлага эндээс үүсдэг.

Эрх мэдэл хүнийг эвддэг. Хязгааргүй эрх мэдэл хязгааргүй эвддэг. Аугаа хүмүүс ихэвчлэн өөдгүй хүмүүс байдаг. Эрх мэдэл тэднийг ялзруулах үед эсхүл тэд бүрэн дүүрэн ялзралдаа живсэн цагт бид үүнийг хамгаас тод хардаг.

— Лорд Актон (1887), Бишоп Крейтонд бичсэн захидал

Хэдий ийм ч гэсэн төр нь хүчирхийлэл, албадлага хэрэглэх эрх мэдэлтэй учраас олонхын зүгээс уг эрх мэдлийг бусдын эсрэг ашиглах заналхийлэл цаг ямагт байсаар байдаг. Хүн бүр хувийн сонирхолтой гэдэг илт үнэнийг эш үндэс болгох аваас хүмүүс эрх мэдлээ өөрсдийн тусын тулд урвуулж ашиглана гэдгийг бид мэддэг байх ёстой. XVIII зууны Шотландын философич Дэвид Хьюм (1758) “Засаглалын тогтолцоог зохион байгуулж байх явцад хүн бүрийг муу санаатай, зөвхөн хувийн ашиг сонирхолдоо хөтлөгддөг гэж тооцож байх ёстой”-г анхааруулжээ. Хоёр зуун жилийн дараа Англи-Австрийн сэтгэгч Ф.А Хайек дэлхийн дайны цаг үед бичигдсэн Боолчлогдох Зам (1944) бүтээлээрээ ардчилал нь туйлын хялбархнаар цөөн хүмүүсийн тоталитари дарангуйлал руу гулсах боломжтой болохыг зурагласан. Үнэхээр

ч 2020 оны Ковид-19 цар тахлын үеэр ардчилсан улсын иргэд улс төрчид нь тэдний өдөр тутмын амьдралын үйл ажиллагааг өргөн хүрээнд хязгаарлах маш их эрх мэдэлтэй байсныг ойлгоод олноороо балмагдсан.

Хэрвээ хяналтгүй бол олонхын засаглал нь цөөнх болон хувь хүнийг эрх мэдэлтнүүд болоод олонхын хувийн ашиг сонирхлоос хамгаалж чадахгүй. Иймээс хувь хүний үндсэн эрх, эрх чөлөө нь ямар ч олонхын шийдвэрээс дээгүүр байдаг, засгийн газар зөвхөн эдгээрийг хамгаалахын тулд л оролцдог хязгаарлагдмал, либерал ардчилал л жинхэнэ ардчилал юм. (Butler 2013). Эдгээр хязгаарлалтуудыг Үндсэн хуульд ч албан ёсоор тусгаж болно.

Гэхдээ зарим онолчид ардчилал нь дарангуйлал руу гулсчих аюул нь бодит хэдий ч хэтрүүлэгтэй гэж үзсэн. Жишээлбэл Турк-Америкийн эдийн засагч Дарон Ажемоглу, түүний Британи хамтрагч Жеймс Робинсон (2006) нар улс төрийн институциуд, эдийн засгийн тогтолцоо, иргэний нийгэм хүчтэй байдаг газруудад ардчилал урт хугацаанд тогтвортой оршиж чаддагийг нотлохыг оролджээ. Мөн адил улс төр судлаач Андре Алвес, Жон Медоукрофт (2014) нар судалгаандаа харьцангуй аядуу ардчилалтай, төр болон хувийн хэвшлийн холимог эдийн засгийн тогтолцоотой улсууд нь дэлхийн хэмжээнд өргөн тархсан байдаг бөгөөд урт хугацаандаа тогтвортой байгааг дурдсан байна. Харин тоталитари дэглэмүүд урт хугацаандаа

тэсэж үлдэхэд хүндрэлтэй байгааг онцлов. Тэдний дүгнэснээр эрх баригч бүлэг болон тэднийг тойрон хүрээлэгсдийн тоо хэмжээнд бодит хязгаар байдаг. Учир нь мөлжигсдийн тоо нэмэгдэх тусам тэдэнд мөлжигдөх бүтээлч, шаргуу, хөдөлмөрч иргэдийн тоо цөөрч, ажиллаж хөдөлмөрлөх эдийн засгийн сэдэл нь буурдаг байна.

АРДЧИЛЛЫН ҮНДСЭН ҮҮРЭГ

Онолын эрдэмтэд ардчилал нь хамтын шийдвэрийг гаргах шударга, зүй ёсны аргачлал гэдгээс гадна ардчиллыг өөр бусад шалтгаануудын улмаас ч дэмжих нь бий. Тэдний зарим нь улс төрийн тэгш байдлыг бүрдүүлсэн, ёс суртахуунд тулгуурласан цорын ганц улс төрийн тогтолцоо учраас ардчиллыг сайн зүйл гэж үздэг. Өөр бусад нь ардчилал нь нийгмийн оролцоо, хувь хүний хариуцлага, энх тайван, хөгжил цэцэглэлтэд хөтөлдөг сайн үр дагаврыг бий болгодог гэж мэтгэнэ. Энэ бол бүрэн дүүрэн нотлогдсон гэж үзэх аргагүй маргаантай сэдэв.

Гэвч хүмүүсийн ихэнхи тохиолдолд орхигдуулдаг ардчиллын нэг том давуу тал бий. Бид ардчиллыг голчлон шийдвэр гаргагчдыг сонгох аргачлал гэж ойлгодог. Гэвч ардчиллын хамгийн чухал ач холбогдол нь эдгээр шийдвэр гаргагчдыг хязгаарлах, тэднийг энх тайвнаар халж солих боломжийг олгоход оршдог. Эцсийн эцэст хууль тогтоогчид бол сахиусан тэнгэрүүд биш бидний л адил энгийн хүмүүс. Хүнийг эрх мэдэл амархан эвддэг. Албан үүргээ гүйцэтгэх явцдаа тэд бидний сонирхлоос илүүтэй өөрсдийнхөө сонирхлыг нэн тэргүүнд тавьдаг байж болно. Эсхүл цаг хугацаа өнгөрөхийн хэрээр тэдний эсхүл бидний үзэл хандлага өөрчлөгдөж, биднийг тэд төлөөлөх

шаардлагагүй болдог. Ямар ч шалтгаантай бай сонгуулиар албан тушаалтныг зайлуулах чадамж бидэнд байдаг учраас л бид тэднийг эрх мэдлээ төвлөрүүлж, урвуулж ашиглахаас урьдчилан сэргийлж, анхаарлыг нь нийтийн ашиг сонирхол руу хөтөлдөг. XX зууны Англи-Австрийн философич Сэр Карл Поппер (1945) ‘Төр засгийн зүй зохистой байдал, мэргэн ухаанд бүрэн дүүрэн хэзээ ч итгэх аргагүй... [Иймээс] Хэн засаглах ёстой вэ?’ гэсэн асуултыг бид ‘Хэрхэн улс төрийн институциудыг сайтар зохион байгуулж, чадваргүй муу удирдагчид хэт их хохирол сүйтгэл учруулахаас нь урьдчилж сэргийлэх боломжтой вэ?’ гэсэн шинэ асуултаар орлуулах ёстой.” тухай бичжээ.

ШУУД АРДЧИЛАЛ

Өмнө дурдсанчлан, ардчилал нь шууд болон төлөөллийн гэсэн хоёр хэлбэртэй. Шууд ардчилал нь нийтийн санал асуулга явуулах байдлаар иргэд өөрсдөө улс төрийн асуудлуудаа (жишээлбэл, татварын хувь хэмжээ, батлан хамгаалахын эсхүл халамжийн бодлого гэх мэт) хамтдаа шийдвэрлэдэг. Гэвч өнөөдөр шууд ардчиллын аргаар асуудал шийдэх нь ховорджээ. Шууд ардчилал тодорхой хэмжээнд хадгалагдаж үлдсэн улсуудын нэг нь Швейцарь юм. Тэнд улс төрийн гол эрх мэдэл Холбооны Засгийн газраас илүүтэй 27 кантон, 3000 коммунд хадгалагддаг. Кантонуудын хэмжээ харилцан адилгүй. Цюрихын хүн ам 1,5 сая байхад Аппенцель Иннерходен гэдэг кантонд ердөө 16,000 хүн амьдардаг байх жишээтэй. Референдум тогтмол явагддаг бөгөөд жижиг кантонууд иргэдийн хурал чуулганаар асуудлуудаа шийдвэрлэдэг. Өөр нэг жишээ гэвэл Шинэ Английн 1000 орчим хотод зохион байгуулагддаг Хотын чуулганууд юм.

XVII зуунаас эхтэй эдгээр чуулганууд нь авто зам, лиценз, төсөв зэрэг орон нутгийн асуудлуудаа өөрсдөө шийдвэрлэдэг ч гэсэн шийдэх асуудлуудын хүрээ нь харилцан адилгүй. Иймээс зарим газарт эдгээр чуулганууд төлөөллийн байгууллага болон хувирч,

томоохон хотуудын иргэд бүгд оролцохын оронд төлөөлөгчдөө сонгодог болсон байна. Орчин үеийн үндэстний төрт улсуудын хувьд иргэд хууль тогтоох чуулган болж өөрсдөө хуран чуулах аргагүй болсон. Иймээс заримдаа референдум зохион байгуулж нийт сонгогчдын дунд тодорхой тооны асуудлаар санал хураалт явуулдаг боловч ингэх нь өнөөгийн улс орнуудад тулгарч буй комплекс асуудлуудыг шийдвэрлэх шалгарсан арга болж чадаагүй гэдэг нь тодорхой.

Зарим активистууд орчин үеийн ардчиллыг онлайнаар санал асуулга явуулах байдлаар илүү шууд хэлбэртэй болгох боломжтой гэж үзэж байна. Гэхдээ олонхоор шийдвэр гаргах үйл явц нь тодорхой хүрээгээр зайлшгүй хязгаарлагдаж байж гэмээнэ илүү легитим шинжтэй байж чадна. Түүнчлэн иргэд бодлого боловсруулах, улс төрийн хүнд хэцүү шийдвэрүүдийг тасралтгүй гаргахад хангалттай байж чадахуйц сонирхол, тэсвэр тэвчээртэй эсэх нь эргэлзээтэй.

ТӨЛӨӨЛЛИЙН АРДЧИЛАЛ

Дээрх шалтгаануудын улмаас өнөө цагт төлөөллийн ардчилал нь бидний хувьд нийтлэг хэм хэмжээ болжээ. Уг тогтолцоонд иргэд нь өөрсдөө хууль тогтоодоггүй, харин хотын дарга, парламентын гишүүд, ерөнхийлөгч зэрэг төлөөлөгчдөө сонгож, тэдэнд хууль тогтоож, бодлого боловсруулах эрхийг олгодог.

Үүнийг жинхэнэ ардчилал биш гэж шүүмжлэх хүмүүс бишгүй их. Тэдний үзэж байгаагаар, будагчин хөлслөх нь гэрээ өөрөө будахтай адилгүй, иргэдийн үүрэг нь эрх баригчдыг сонгохоор л хязгаарлагдах хязгаарлагдмал юмсанж. Гэвч иргэдэд ядаж л эрх баригчдаа сонгох сонголт байдаг бөгөөд хэн ч тэдэнд удирдагчийг хүчээр тулган хүлээлгэдэггүй. Мөн тэдэнд улс төрийн үйл хэрэгт оролцох эрх нь байдгаас гадна улс төрийн албан тушаалд нэр дэвших, нийтийн хэлэлцүүлэгт хувь нэмрээ оруулах боломж нь нээлттэй.

Үүнээс гадна өнөөгийн төлөөллийн ардчилал бүхий олон улсад иргэдийн шууд оролцоо, хяналтын хэлбэрүүд тодорхой хэмжээнд хадгалагдан үлдсэн. Тухайлбал, референдум буюу олон нийтийн санал асуулгаар чухал асуудлуудыг шийдэх, өргөдөл болон санаачилгаар сонгогчдын бүлэг парламентад санал хураалт явуулах эсхүл референдум зарлах

шаардлага гаргах, төлөөлөгчдийн алба хаших хугацааг хязгаарлах, эргүүлэн татах замаар сонгогчид төлөөлөгчдөө албан тушаалаас нь огцруулах олон боломж бий. Хэдий ийм байдаг ч иргэдийн олонх нь өдөр тутмын улс төрийн асуудлуудыг өөрсдөө шийдвэрлэхээс илүүтэй цаг завтай, мэдлэг боловсролтой, туршлагатай мэргэшсэн хүмүүст нь даатгахыг илүүд үздэг.

Иймээс өнөөдөр ‘ардчилал’ гэсэн үг нь ихэвчлэн төлөөллийн засаглалыг илэрхийлэхэд хэрэглэгддэг бөгөөд энэ үгийн хэдийнээ орчин үеийн утга санаа нь үүнийг илэрхийлдэг болж өөрчлөгдсөн. Гэвч уг үгийн хэрэглээ нь заримдаа будилаан үүсгэдэг. Нэг үгэнд олон төрлийн засаглалын хэлбэрийг багтааснаас гадна төлөөллийн тогтолцоонд шууд ардчиллын давуу талыг агуулдаг гэж ойлгогддог. Тухайлбал хууль тогтооход иргэдийн оролцоог хангадаг гэж хүмүүст ойлгогдох боловч ихэнхи тогтолцоонд иргэдийн бодит оролцоо бага эсхүл огт байхгүй байх нь элбэг.

ЛИБЕРАЛ АРДЧИЛАЛ

Төлөөллийн засаглалын өргөн хүрээнд либерал ардчилал оршино. Либерал ардчилал гэдэг нь сонгодог либерализмын зарчимд суурилсан төлөөллийн тогтолцоог хэлнэ. Либерал ардчиллаас салгаж ойлгох огт боломжгүй хэв шинж нь хувь хүний эрх билээ. Тухайлбал амьд явах, эрх чөлөөтэй байх, өмчлөх зэрэг эрхүүдийг ямагт хүндлэн дээдэлж, хамгаалах ёстой бөгөөд аль ч тохиолдолд ‘ардчилсан’ шийдвэрээр үүнд халдаж болохгүй. Либерал ардчилал гэж тодорхойлогддог улсуудын хувьд эдгээр эрхүүдийг хамгаалах өөр бусад арга хэрэгслүүдийг цогцлоосон байдаг. Үүнд шийдвэрийг хууль ёсны процедурын дагуу гаргах, засгийн газрын эрх мэдлийг хязгаарлах Үндсэн хуулийн заалт, хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн хуваарилалт, хараат бус шүүхийн тогтолцоо зэрэг багтана. Мөн олон нийтийн оролцоог дэмжихэд чиглэсэн шударга, чөлөөт сонгууль, хүн бүр нэр дэвших боломж, нам хоорондын өрсөлдөөн, хараат бус хэвлэл мэдээлэл, нээлттэй улс төрийн мэтгэлцээн хэлэлцүүлэг зэргийг хамруулж ойлгоно. Либерал ардчиллын хэлбэрүүд нь харилцан адилгүй.

Жишээлбэл, Дани, Япон, Испани, Их Британи зэрэг улсууд Үндсэн хуульт хаант засаглалтай

гэж нэрлэгдсэний хувьд төрийн тэргүүн нь хаан байдаг ч гэсэн хааны эрх мэдэл Үндсэн хуулиар хязгаарлагддаг. Франц, Ирланд, АНУ зэрэг бусад улсуудын хувьд төрийн тэргүүнээ сонгуулиар сонгодог хэдий ч үндсэн хуулиар хязгаарлагддаг Үндсэн хуульт Бүгд Найрамдах улсууд. Эдгээр тогтолцооны аль алинд нь л Үндсэн хуулийн элементүүд тухайлбал төрийн тэргүүн (хаан эсхүл ерөнхийлөгч), парламентын танхимууд (сенат эсвэл төлөөлөгчдийн танхим), төрийн бие даасан эрх мэдлийн салаа мөчрүүд (гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх) тус бүр өөр өөрийн эрх хэмжээтэй зэрэгцэн оршиж байна.

Либерал ардчиллыг зөв хэрэгжүүлэх нь амаргүй. Үүний үйл ажиллагаа хэрхэн явагддаг, аль эрх, эрх чөлөөг олонхын шийдвэрийн өмнүүр тавих ёстой вэ гэх мэт нь маш түвэгтэй маргаан дагуулсан сэдэв юм. Тухайлбал либерал ардчилалд олонх санал зөрөлддөг цөөнхөө дур мэдэн баривчлах, хорих, цөлөх эрхгүй нь тодорхой мэт харагддаг боловч баячуудад өндөр татвар ногдуулахыг зөвшөөрч болох уу? Иргэдийг өөрөө өөрсдөдөө хөнөөлтэй шийдвэр гаргахаас урьдчилж сэргийлэхийн тулд тэдний амьдралын хэв маягт хөндлөнгөөс оролцож (мансууруулах бодис, согтууруулах ундаа, элсэн чихрийн хэрэглээг хязгаарлах гэх мэт) болох уу? Эсхүл улс үндэстний ашиг сонирхлын

үүднээс иргэдийн эдийн засгийн сонголтыг (хаана, хэрхэн, амьдарч, хөдөлмөрлөх гм.) зааж чиглүүлж болох уу? Либерал ардчиллын эрх баригчид дайн, цар тахлын үед тодорхой төрлийн эрхүүдийг түр хязгаарлах, эсхүл терроризмын аюулаас сэргийлэхийн тулд иргэдийн харилцаа холбоог тагнаж чагнах эрхтэй байж болох уу?

Дээрх асуултуудад ердөө тийм/үгүй гэсэн байдлаар хариулах аргагүй. Либерал ардчиллын суурь зарчмуудын талаар ард нийт зөв ойлголттой болсон цагт л либерал ардчилал дархлаажна.

IV

АРДЧИЛЛЫН ЗАРЧМУУД

БҮХ НИЙТИЙН СОНГУУЛИЙН ЭРХ

Либерал ардчиллын үлгэр жишээ гэж нэрлэгдэхүйц улсуудыг ажиглаад байхад дараах онцлог шинжүүд, институциуд дурайж харагдана.

Бүх нийтийн сонгуулийн эрх: Либерал ардчилал нь бүх нийтийн сонгуулийн эрх болон улс төрийн тэгш байдал дээр тулгуурладаг. Бараг бүхий л насанд хүрсэн иргэн сонгуульд санал өгөх эрхтэй бөгөөд тэдний санал ижил жинтэй. Хүүхдүүд, хүнд хэлбэрийн сэтгэцийн эмгэгтэй хүмүүс санал өгөх чадамжгүй учраас тэднийг мэдээж сонгуульд оролцуулдаггүй. Зарим улс орнуудад хоригдлууд тэр ч бүү хэл ял шийтгэлээ эдэлж дууссан гэмт хэрэгтнүүд үйлдсэн гэмт хэрэг нь нийгмийн хэрэг явдалд оролцоход тохиромжгүй гэх үндэслэлээр сонгуульд оролцох эрхээ хязгаарлуулдаг. Бусад тохиолдолд иргэн бүр сонгуульд оролцох боломжтой.

Гэвч иргэн гэж чухам хэнийг тооцох вэ гэдэг дээр ч маргаан өрнөх нь бий. Урьдын цагт зөвхөн өмчтэй эрчүүдийг хариуцлагатай байдлаар санал өгөх чадамжтай гэж үздэг байв. Мөн адил шалтгаанаар цагаач, түр оршин суугчдад сонгуулийн эрх олгохыг эсэргүүцдэг хүмүүс ч бий. Өөр нэг асуудал нь тодорхой улсуудад олон янзын угсаатны бүлгүүд аж төрдөг учраас угсаатны онцлог (Украйн дахь Оросууд),

хэл соёл (Канад дахь Францчууд), шашин шүтлэгээрээ (Сомали, Босни, Ирак, Пакистан гэх мэт) хуваагддаг нөхцөл байдал байна. Эдгээр бүлгүүдийн аль нэг нь хамтын шийдвэрт нөлөөлөх нөгөө бүлгийнхээ эрхийг хүлээн зөвшөөрдөггүй. Либерал зарчим нь иргэншлийн тодорхойлолтыг аль болох өргөн хүрээнд хамруулахыг шаарддаг ч иргэншлийн дүрэм нь тодорхой, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой ба үүнийг хэрэгжүүлэхэд бэрхшээл тулгардаг.

Нээлттэй сонгууль: Либерал ардчилалд хүн бүр нийтийн албан тушаалд нэр дэвших эрх нь нээлттэй. Хүүхдүүд, ялтнууд, сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн сонгуулийн эрхийг хязгаарлаж болох ч улс төрийн нам, шашин, нийгмийн давхарга, гэр бүл, угсаа гарвал, хүйсээр ялгаварлан нэр дэвшүүлэх нь хориотой. Мөн эрх баригчид улс төрийн өрсөлдөгчөө тодорхой албан тушаалд тохиромжгүй гэж үзэн сонгуульд оролцуулахгүй байх боломжгүй. Либерал ардчилал нь иргэддээ өөрийн төлөөлөгчөө үзэмжээрээ сонгох шийдвэрийг итгэмжлэн даатгадаг.

Либерал ардчилалд сонгууль байнгын, чөлөөт, шударга шинжтэй. Сонгуулийн давтамжийн хувьд улс бүр харилцан адилгүй. АНУ-д төлөөлөгчдийг хоёр жил тутам, ерөнхийлөгчийг

дөрвөн жил тутам, сенаторыг зургаан жил тутам сонгодог. Францад 2000 оны референдумаар ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааг долоон жилээс таван жил болгон богиносгосон. Олон улс оронд сонгогдсон албан тушаалтны бүрэн эрхийн хугацааг хязгаарладаг. Хамгийн чухал нь сонгууль хангалттай олон удаа явагдаж, албан тушаалтнуудын бүрэн эрхийн хугацаа богино байснаар нэгд, хэн нэг дарангуйлагчийн эрх мэдэл төвлөрөхөөс сэргийлдэг, удаад нь ялагдсан тал нь хүчирхийлэлд дулдуйдахаас илүүтэй дараагийн сонгуулийг тайвнаар хүлээх нь илүү тохиромжтой гэдгийг мэддэгтэй холбоотой.

Чөлөөт сонгууль гэдэг нь сонгогчид айдас, дарамтгүйгээр саналаа өгч, хэнд санал өгөхөө өөрсдөө чөлөөтэй сонгох боломжтой байхыг хэлнэ. Үүний тулд жинхэнэ нууц санал хураалт зайлшгүй шаардлагатай. Либерал ардчиллууд ихэвчлэн эдгээр нөхцөлийг хангахын тулд хараат бус хяналтын зөвлөлүүдийг ажиллуулдаг.

Шударга сонгууль гэдэг нь хувь хүн болон улс төрийн намууд тэгш эрхийн үндсэн дээр нэр дэвших, сурталчилгаа явуулах, тайван жагсаал цуглаан зохион байгуулах боломжтой байхыг хэлнэ. Сонгуулийн тойргийг эрх баригч улстөрчид бус хараат бус зөвлөлүүд объектив байдлаар тогтоодог. Саналыг зөв тоолж тэдгээр саналууд нь сонгуулийн үр дүнг тодорхойлдог.

Гэхдээ ‘шударга’ гэдгийн нарийн тодорхойлолт нь улс орон бүрт харилцан адилгүй. Жишээ нь Их Британид сонгуулийн санхүүжилтийн хязгаар бага боловч улс төрийн намуудад өгөх хандивт хязгаар байхгүй. Харин АНУ-д хандивыг хязгаарладаг ч санхүүжилтийн хэмжээг нарийн тодорхойлоогүй.

Чөлөөт хэлэлцүүлэг: Чөлөөт, шударга сонгууль нь асуудлуудыг чөлөөтэй хөндөж, хэлэлцэх боломжтой үед л хүчин төгөлдөр. Энэ нь үг хэлэх эрх чөлөөтэй байх шаардлагыг бий болгодог бөгөөд үүнд ямар нэг үймээн самууны хэргээр буруутгагдах айдас дарамтгүйгээр эрх баригчдыг шүүмжлэх эрх багтана. Мөн эрх баригчдад үйлчилдэг бус төрийн хяналтаас ангид бие даасан, хараат бус чөлөөт хэвлэл мэдээлэл хэрэгтэй. Түүнчлэн иргэд төр засгийнхаа талаар үнэн зөв мэдээлэл авах эрхтэй хийгээд боломжтой байх ёстой бөгөөд төр албан ёсоор мэдээллийн урсгалыг хянаж, монопольчилж огт болохгүй.

Шударга, зүй зохистой төлөөлөл: Албан тушаалтнууд иргэдийнхээ өмнө бодит хариуцлага хүлээх ёстой. Хэрвээ төлөөлөгчид эрх мэдлээ хэтрүүлсэн эсхүл иргэдийн эрхийг зөрчсөн гэж үзвэл иргэд өөрсдийн зөрчигдсөн эрхийг сэргээлгэхийн тулд хандаж болох хараат бус шударга шүүхийн байгууллага, шүүгч албан

тушаалтнууд байх ёстой. Зарим тохиолдолд төлөөлөгч албан тушаалаа урвуулан ашигласан гэж сонгогчид үзвэл түүнийг хэзээ ч эргүүлэн татах боломжтойг заасан заалтыг хуулинд тусгаж болно. Сонгуулийн үндсэн зорилгод нийцүүлэн төлөөлөгчид сонгуулийн үр дүнг хүндэтгэж, хэрэв ялагдах аваас албан тушаалаа шилжүүлэхэд бэлэн байх ёстой. Эцсийн эцэст либерал ардчиллын хамгийн гол зорилго нь улс төрийн эрх мэдлийг тайван арга замаар шилжүүлэхэд оршдог. Төрийн эрх мэдэл нь эрх баригчдыг албан тушаалд нь бүх насаар нь хадахын тулд хэрэгждэг бус харин сонгогчдын сонголтыг хүндэтгэхэд чиглэгдэх учиртай.

Эрхүүд ба зарчмууд: Хувь хүний үндсэн эрхүүдийг тодорхойлж, нийтээр хүлээн зөвшөөрч, хүндлэн дээдэлж, хуулиар баталгаажуулах нь маш чухал бөгөөд үр дүнд нь сонгуулиар олонх болсон бүлэг этгээд тэдгээр эрхийг боомилох боломжгүй болдог. Эдгээр эрхүүдийг хүний мөн чанарын салшгүй нэг хэсэг гэж үзэх эсхүл эрхүүд нь үр дүнтэй гэдгээ нотолсон учраас хүлээн зөвшөөрсөн эсэхийн аль нь ч байлаа гээд хүмүүс тодорхой ямар эрхүүдийг эдлэх тал дээр өргөн хүрээнд санал нэгдсэн байх ёстой агаад тэдгээрийг хамгаалах нийтлэг амлалт, баталгаа шаардлагатай.

Эдгээр үндсэн эрхүүдийн тухайд либерал

ардчилсан улсуудад бага зэрэг өөр хоорондоо ялгаатай үзэл баримтлалууд зонхилдог болох нь мэдээжийн хэрэг. Гэвч бүгдээрээ хүн бүр амьдрал, эрх чөлөө, өмч, аз жаргалд тэмүүлэх эрхтэй гэдэг дээр санал нэгддэг. Гэвч нарийвчилсан хууль журмаар иргэдийг өмчийн газар дээрээ юу барьж болох эсэх, юу хориглогдох, мөн таныг баривчлан хорихыг зөвтгөх үндэслэл болсон гэмт хэрэг гэдэг нь чухам юу вэ гэсэн асуудлын хувьд улс орон бүр харилцан адилгүй.

Үндсэн Хууль: Ихэнх либерал ардчиллууд нь хувь хүний үндсэн эрхийг хамгаалж, сонгуулиар олгогдсон эрх мэдлийн хүрээ хязгаарыг тогтоож, эрх мэдлийн хуваарилалт зэрэг эрх мэдлийг тэнцвэржүүлж хянах хяналтын механизмыг бий болгосон бичмэл Үндсэн хуультай байдаг. Мэдээжийн хэрэг энэ нь Үндсэн хууль нь зөвхөн цорын ганц баримт бичгийн хэлбэртэй байх ёстой гэсэн үг биш. Жишээлбэл, Их Британид Магна Карта, Эрхийн тунхаг, Парламентын хууль, Төрийн эрх мэдлийн төвлөрлийг задлах хууль зэрэг хууль зүйн хүчин төгөлдөр баримт бичгүүд болон өв уламжлалууд нь иргэдийн үндсэн эрх, засгийн газрын үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлдог.

Эдгээр хамгаалалтуудыг олонхын хүсэл зоргын дагуу устгаж үгүй хийхгүй гэдгийн

баталгаа болгож Үндсэн хуульд өөрчлөлт хийхийн тулд дийлэнх олонхын санал болон хуулийн дагуу уг үйл явц явагдах ёстой гэдгийг ихэнх Үндсэн хуулиудад өөрт нь тусгасан. Тухайлбал АНУ-ын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулахын тулд Сенат болон Төлөөлөгчдийн танхимын гуравны хоёроос доошгүй санал, мөн мужийн хууль тогтоогчдын дөрөвний гурвын зөвшөөрөл шаардлагатай. Харин Их Британи үүний онцгой жишээ болдог. Онолын хувьд Парламент нь улсынхаа Үндсэн хуулийн заалтуудын аль ч хэсгийг өөрчилж болох ч уг үйл явц ихэнхи тохиолдолд маш урт удаан, нарийн хяналттай нийтийн хэлэлцүүлгийн дор явагддаг.

Гэвч эцсийн дүндээ бичмэл Үндсэн хуультай байсан ч гэсэн хуулиар хувь хүний эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн баталгаажуулж чадахгүй. Үүний тулд олон нийтийн сэтгэлгээ, соёлд нь эдгээр үнэт зүйлсийн төлөөх тууштай хатуу итгэл үнэмшил шингэсэн байх учиртай.

ЛИБЕРАЛ ТӨЛӨӨЛЛИЙН ХҮСҮҮШТЭЙ ЭЛЕМЕНТУУД

Либерал ардчиллын үлгэр жишээ гэж нэрлэгдэхүйц улсуудыг ажиглаад байхад дараах онцлог шинжүүд, институциуд дурайж харагдана.

Оролцоо: Эдгээр зайлшгүй онцлог шинжүүдээс гадна өөр бусад хүсүүштэй элементүүд ч бий. Жишээлбэл ардчиллын үйл явцад өргөн хүрээнд, идэвхтэй, сайн дурын оролцооны соёлыг бий болгох нь ач тустай. Энэ нь олон төрлийн санаа бодлыг илэрхийлэх, уралдуулах боломжийг олгож, ардчилсан үйл явцын легитим шинжийг улам бүр нэмэгдүүлдэг. Гэхдээ либералуудын хувьд ардчиллыг легитим болгодог гол шинж нь иргэдийн улс төрийн оролцоог хамгийн дээд хэмжээнд хүргэх бус харин хувь хүний эрх чөлөө, аюулгүй байдлыг хамгийн дээд түвшинд хангах явдал гэж үздэг.

Нэр дэвшигчид: Улс төрийн намууд нь ардчиллын салшгүй нэг хэсэг. Учир нь тэдгээр нь сонгогчдод танигдахуйц ‘шошго’ болж өгдөг. Гэхдээ үүнд ч бас хязгаарлалт бий. Хэрэв намууд өөрсдийн шошгоо хэт хатуу хянавал (тухайлбал нэр дэвшигч бүрийн сонгуулийн хөтөлбөрийг нарийн зааварлаж, парламентад тэдний саналыг ‘хүчээр нэгтгэн’ удирдах зэрэг) нэр дэвшигчид бие даасан байдлаа алдаж, олон нийт тэдний

хувийн үзэл бодлыг ойлгох боломжгүй болно. Энэ нь нэр дэвшигчдийг намын батлагдсан жагсаалтаар бус ил тод байдлаар сонгох ёстойг харуулж байна.

Федерализм буюу холбооны тогтолцоо:

Идеалын хувьд шийдвэр гаргах бололцоог боломжтой хамгийн доод түвшинд шилжүүлэх ёстой. Ингэснээр орон нутгийн онцлогийг сайтар мэдэхгүй хүмүүс бус тухайн шийдвэрийн үр дагавар амьдралд нь нөлөөлдөг хүмүүс өөрсдөө асуудлаа шийдвэрлэх боломжтой болдог. Гэхдээ орон нутгийн шийдвэрүүдэд зохих түвшний төвлөрсөн хяналт хэрэгтэй. Жишээлбэл хэрэв тодорхой нэг орон нутагт аль нэг угсаатны болон шашны бүлэг давамгайлдаг бол (ийм байх нь элбэг) олонх нь цөөнхийнхөө эрхэнд халдаж болохгүй. Илүү өргөн уудам нутаг дэвсгэрт ялгаатай үзэл бодол холилдож, зэрэгцэн оршдог учраас л цөөнхийн эрхийг хамгаалж, хүндэтгэх боломж магадлал нь илүү нэмэгддэг.

Иргэний хүлцэн тэвчихүй: Энэ бүхнээс гадна либерал ардчилал нь олон янзын өөр хоорондоо ялгаатай үзэл санааг хүлээн зөвшөөрдөг, нийгэм эдийн засгийн тогтвортой байдал, энх тайван оршиж байгаа нөхцөлд л хамгийн үр дүнтэй байх боломжтой нь ойлгогдож байна. Эдгээр хүсүүштэй элементүүдийг өөрсдийгөө

‘ардчилсан’ гэж тодорхойлдог улсууд хэр зэрэг
бодитоор хэрэгжүүлдэг эсэх нь тодорхойгүй.

ЛИБЕРАЛ АРДЧИЛЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шударга ёс: Өмнө нь дурдсанчлан либерал ардчиллын үндсэн зорилго нь хувь хүний эрх чөлөөг хамгаалах, өргөжүүлэх, тэднийг албадлагаас сэргийлэх явдал билээ. Тиймээс энэ нь залилан, хүчирхийлэл, тэр тусмаа эрх баригчид эрх мэдлээ урвуулан ашиглахаас сэргийлж, шийтгэдэг шударга ёсны тогтолцоотой байхыг шаарддаг.

Үүнийг хэрэгжүүлэхийн тулд хууль тогтоомжууд нь тодорхой зарчимд тулгуурласан, бүрэн тодорхой, харьцангуй тогтвортой, олон нийтэд ойлгомжтой байх шаардлагатай. Хууль тогтоомжууд нь урьдчилан таамаглах боломжтой, дур зоргын бус, дагаж мөрдөх боломжтой байх шаардлагад нийцэх ёстой. Шударга ёсны үйл явц нь өөрөө мөн адил зарчимд тулгуурласан, урьдчилан таамаглах боломжтой, ‘хуулийн процесс’-ын дагуу явагдах ёстой. Тухайлбал дур зоргоор баривчилж хорихыг хориглож, яллагдагчдад өөрсдийнх нь эсрэг тулгаж буй ял шийтгэлийг мэдэгддэг, шударга шүүхээр шүүлгэх, чимээгүй байх зэрэг эрхүүдээ эдлэх боломжийг нь олгодог байх ёстой.

Хувь хүний эрх, эрх чөлөөг улам бүр баталгаажуулахын тулд цагдаа, шүүх, шүүгчид

бие даасан байх ёстой бөгөөд улс төрийн эрх мэдэлтнүүдийн хараа хяналтад орж, тэдэнд үйлчилж болохгүй. Эрх баригчид нийтийн өмч хөрөнгийг шамшигдуулсан гэж сэжиглэгдсэн тохиолдолд шударга ёсны тогтолцоо айдас дарамтаас ангидаар зохих мөрдөн байцаалтыг эхлүүлж, ял шийтгэлийг оноох чадамжтай байх шаардлагатай. Хэрэв эрх баригчид өөрсдийн ашиг сонирхлын үүднээс Үндсэн хуулийг өөрчлөх эсхүл буруугаар тайлбарлахыг оролдвол үүнийг нь ч мөн хязгаарлаж, няцааж чаддаг байх ёстой.

Өмчлөх эрх: Либерал ардчилал нь өмчөө эзэмших, захиран зарцуулах эрхийг зөвхөн хувь хүний үндсэн эрх гэж үзээд зогсохгүй үүнийг албадлагаас хамгаалах хэрэгсэл, эдийн засгийн хөгжил дэвшлийн гол хөдөлгөгч хүч хэмээн дээдэлдэг. Хүн өөрийн цаг зав, хөдөлмөрөө зарцуулан өмчөө бүтээн бий болгосон бол түүнийгээ өмчилж, захиран зарцуулах эрхтэй. Тиймээс шударга ёсны тогтолцоо нь хүний бие махбодыг хамгаалдагтай ижил өмчийг нь ч бас хамгаалдаг. Олон улс оронд эдгээр дүрэм журмууд нь харилцан адилгүй байж болох ч хувь хүн өмчөө бусдад алдахаас хамгаалуулах, өмчөө чөлөөтэй захиран зарцуулах, бэлэглэх эсвэл худалдах замаар бусдад шилжүүлэх боломж нь нээлттэй байдаг. Эдгээр дүрэм

журам нь шүүхийн шийдвэрээр хамгаалагдаж, хэрэгжих боломжтой байдаг.

Татвар: Эрх чөлөөг хамгаалахын тулд батлан хамгаалах болон шударга ёсны тогтолцоо зайлшгүй шаардлагатай бөгөөд татвар нь эдгээрийг санхүүжүүлэх боломжийн арга мэт санагддаг. Гэвч ингэх нь хүмүүсийн өмч хөрөнгийг түүнийг хамгаалах үүрэгтэй төр засаг нь хурааж авахыг хэлж байгаа хэрэг. Сайн дурын хандивт найдах нь ‘үнэгүй зайдлах’ гэх эдийн засгийн бэрхшээлийг бий болгож, хүмүүсийн зарим нь төрөөс үзүүлж буй үйлчилгээг ямар ч хүчин зүтгэл, өртөг төлбөргүйгээр эдлэхэд хүргэдэг. Хэрэв албан татвар нь цорын ганц боломжит арга хэрэгсэл гэж үзвэл либерал ардчилал нь татварыг бага байлгаж, зөвхөн иргэдийн эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг хамгаалахад л зориулагдах нөхцлийг баталгаажуулдаг. Гэвч олонх нь хуримтлагдсан хөрөнгийг өөртөө ашигтай байдлаар зарцуулж цөөнхөө (жишээ нь ‘баячуудыг’) мөлжих боломжтой байдаг тул ихэнх либерал сэтгэгчид, тухайлбал Америкийн улс төр, эдийн засгийн онолч Жеффри Бреннан, Жеймс Бьюкенен (1980) зэрэг хүмүүс татварын хэмжээг хязгаарлаж, зориулалтын бусаар шамшигдуулахаас сэргийлсэн бүтцийг бий болгох шаардлагатайг онцолсон. Аараг бүх

нийтийн зөвшилцөлд тулгуурлаж татварыг чухам юунд зарцуулагдах ёстойг шийдвэрлэх нь зүй зохистой гэж тэд үзсэн.

Хувийн эрх чөлөө: Жон Стюарт Миллийн онцолсноор төр нь хүмүүсийн амьдрал, эрх чөлөө, өмчийг хамгаалах хязгаарлагдмал зорилгыг биелүүлэх буюу аюулгүй байдал, эрх чөлөөг нь хангахын тулд л эрх мэдэлтэй байдаг. Хэрвээ төрийн үүрэг нь эрх чөлөөг хамгаалах юм бол хувь хүний эрх чөлөөнд ямар нэгэн хязгаарлалт тавихдаа урьдчилж үүнийгээ зүй ёсны гэдгийг бүрэн зөвтгөх үндэслэлийг гаргаж тавих ёстой. Төрд хүмүүсийн үйлдлийг дур зоргоор эсвэл бүрэн хяналтгүйгээр хязгаарлах эрх байхгүй.

Мөн чухал ач холбогдолтой зүйл гэвэл нийтийн бодлогыг бүрэн хянан хэлэлцэхийн тулд хувь хүн өөрийн хүссэнээр бодож сэтгэж, үгээ хэлж, хууль хүчний байгууллага болон төрийн цензур, шийтгэлээс айхгүйгээр тэднийг шүүмжлэх эрхтэй байх ёстой. Тэд эвлэлдэн нэгдэж улс төрийн нам байгуулж, сонгуульд өрсөлдөх эрх чөлөөтэй байх ёстой. Эдгээрийг либерал ардчиллын үйл ажиллагаанаас салгаж ойлгохын аргагүй бөгөөд үүнд ямар нэг хязгаарлалт тавих бол өргөн хүрээнд хүлээн зөвшөөрүүлж, үүнийгээ зөвтгөх шаардлагатай.

Мөн адил хүмүүс өөрсдийн хүссэнээр

амьдрах эрхтэй. Төр засаг бидний амьдралын хэв маягийг зааж чиглүүлэхийн тулд бус бидний эрх чөлөөг хамгаалахын төлөө оршдог. Түүнчлэн олон ялгавартай үзэл санаа, амьдралын хэв маяг зэрэгцэн орших нь нийгмийг хөгжүүлж, тогтвортой оршин тогтноход тусалдаг. Хүн өөрийн амьдралыг өөрийн хяналтад байлгах эрх чөлөө нь хувь хүний ёс суртахуун суралцах хөгжихийн эх үндэс болдог. Эрх баригчдын хяналтанд байдаг, хувь хүний онцлоггүй улс үндэстэн хөгжиж дэвжих эсхүл хурдацтай өөрчлөгдөж буй ертөнцөд тэсэж үлдэх найдвар үгүй.

Эрх чөлөө болон аюулгүй байдал нь төрийн гол үүрэг учраас бидэнд эдгээрийг хангах үүргээ гүйцэтгэж чаддаггүй эсхүл үндсэн үүргийнхээ эсрэг үйл ажиллагаа явуулж буй төр засгийг зайлуулах бүрэн дүүрэн эрх бий. Үүнийг гүйцэлдүүлэх хамгийн тохиромжтой арга зам нь эрх мэдлийг тайван замаар шилжүүлэх бөгөөд иймээс либерал ардчилалд сонгууль явагддаг. Гэхдээ бид өөрсдийн бие болон өмчийг бусдаас тэр ч бүү хэл төрийн зүгээс ирж буй бурангуй үйлдлээс хамгаалах ч эрхээ хадгалсаар байдаг. Энх тайван улс төр, нийгмийн дэг журам нь хүчирхийлэлд тулгуурлах бус, харин итгэлцэл, хамтын ажиллагаа, харилцаа холбоонд суурилдаг.

Эдийн засгийн эрх чөлөө: Эдийн засгийн эрх чөлөөг хувийн эрх чөлөөнөөс салгаж ойлгох аргагүй. Эдийн засгийн нөөцийг төр хяналтандаа оруулна гэдэг нь хувь хүний амьдралыг мөн адил хянахын нэр юм. Хэвлэл мэдээлэл, зорчих хөдөлгөөнийг хянадаг Засгийн газар нийтийн шүүмжлэл, хэлэлцүүлгийг ч зогсоож чадна.

Чухам ийм учраас л эдийн засгийн эрх чөлөө нь эдийн засгийн нөөцийг улс төрийн зорилгоор хянаж, зохицуулж, удирдан чиглүүлдэг төр засгаас илүү хөгжил дэвшилд биднийг хөтөлдөг. Британийн зохиолч Мэтт Ридли нэгэнтээ (2020) “Хувь хүний шинэ санаа, бизнес эрхлэгчийн санаачилга, олон хүний оюун ухааны хүч чадал нь бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг илүү хямд, чанартай болгоход зайлшгүй чухал. Чөлөөт эдийн засаг нь захиргаадалтын эдийн засгаас хавьгүй илүү хурдацтай өөрчлөлтөнд дасан зохицох чадамжтай.” гэсэн байдаг.

V

ОРЧИН ҮЕИЙН
ТӨЛӨӨЛЛИЙН АРДЧИЛЛУУД

ПАРЛАМЕНТЫН ЗАСАГЛАЛ

Түүхийн дийлэнх хугацаанд хууль тогтоох байгууллагууд нь язгууртан сурвалжтангуудаас бүрддэг байсан түүхтэй бөгөөд нийт ард түмний сонголт, төлөөлөл байх ёстой гэх санаа нь харьцангуй сүүл үед бий болсон. Тухайлбал Их Британийн Парламент нь хааны эрх мэдлийг хязгаарлахыг эрмэлзсэн баронуудын зөвлөлөөс эх үндэстэй. Аажмаар угсаа гаралгүй газрын эзэд гишүүнээр нэмэгдэх болсон ч Дундад зууны парламентуудын зорилго нь өмчтэй хүмүүсийг хааны эрх мэдлээс хамгаалах зорилготой байснаас бус нийт ард түмнийг төлөөлөхийг зориогүй.

Урт хугацааны тэмцэл тулаан явагдсаны эцэст л эрт цагт зөвхөн хаадад харьяалагддаг байсан эрх мэдлийн үлэмж хэсгийг парламент өөрийн хяналтанд авсан. Гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдэл нь бүрэн дүүрэн тусгаарлагдаагүй, Ерөнхий сайд болон сайд нар өөрсдөө хууль тогтоох байгууллагад суудаг уг загвараа Их Британи бусад хуучин колониуд нь байсан Хамтын Нөхөрлөлийн гишүүд гэх мэтийн бусад улсуудад экспортолсон.

Уг загварын нэг давуу тал нь сайд нар сонгогчдынхоо өмнө шууд хариуцлага хүлээдэг явдал юм. Гэвч гүйцэтгэх засаглал нь өөрөө парламент дотор оршдог учраас түүний

гүйцэтгэх эрх мэдлээс ард түмнээ хамгаалах парламентын үүрэг нь сулардаг. Харин АНУ-ын загвар ёсоор эрх мэдлийн хуваарилалт нь гүйцэтгэх засаглалыг илүү өргөн хүрээний мэргэжилтнүүдийн дундаас сонгох боломжтой болгож бие даасан хууль тогтоох байгууллагаар түүний эрх мэдлийг хянах боломжийг бүрдүүлсэн. Гэвч ингэснээр сайдууд олон түмнээс илүү алслагдаж, шууд хариуцлага хүлээх магадлал нь буурдаг.

Нэг танхимт болон Хоёр танхимт: Ихэнх либерал ардчилсан улсууд хоёр танхимтай (bicameral) хууль тогтоох байгууллагыг цогцлоосон байдаг. Хоёр хууль тогтоох танхимтай байх нь нэг танхимынхаа үйлдлийг нөгөөх нь хянаж, хязгаарлах боломжийг бүрдүүлдэг. Хууль батлагдахаас өмнө танхимуудын саналын зөрүүг шийдвэрлэсэн байх ёстой бөгөөд энэ нь хувь хүн эсвэл жижиг бүлгүүдийн эрхийг зөрчигдөхөөс сайтар сэргийлдэг. (Гэхдээ Норвеги, Исланд, Дани, Швед, Шинэ Зеланд зэрэг нэг танхимтай [unicameral] хууль тогтоох байгууллагатай зарим улс орнуудад ч хувь хүний эрхийн баталгааг сайтар хангадаг бол Орос, Зимбабве зэрэг хоёр танхимтай [bicameral] хууль тогтоох байгууллагатай улсууд хувь хүний байр суурийг үл хүндэтгэх нь ч элбэг.)

Хэрвээ танхим бүр гишүүдээ өөр өөр аргачлалаар сонгодог бол ингэснээрээ нийтийн хэлэлцүүлэг нь илүү өргөн хүрээтэй үзэл бодлыг хамарч чадна. Жишээлбэл АНУ-д Төлөөлөгчдийн танхимын гишүүд хүн амын тоо нь тэнцүү хувиарлагдсан бүс нутгаас сонгогддог бол муж бүр хэмжээнээсээ үл хамааран хоёр л сенатчийг сонгодог. Ингэснээрээ жижиг мужуудын байр суурийг орхигдуулахгүй байх боломж бүрддэг. Австралийн сенатчууд нэг шилжих саналын (single transferable vote) тогтолцоогоор сонгогддог бөгөөд энэ нь Төлөөлөгчдийн танхимд хэрэглэгддэг гэнэт хасагдах (instant run-off) эсвэл давуу саналын (preferential) тогтолцоотой харьцуулахад илүү олон үзэл санааг төлөөлөх боломжтой болгодог.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАСАГЛАЛ

Гүйцэтгэх эрх мэдэл нь хууль тогтоох эрх мэдлээсээ бүрэн тусгаарлагдсан тохиолдолд гүйцэтгэх эрх мэдлийг ихэвчлэн ерөнхийлөгч хэрэгжүүлдэг. Улс орнуудын ерөнхийлөгчийн эрх үүрэг харилцан адилгүй. Заримд нь жишээ нь Ирландад ерөнхийлөгчийн үүрэг голчлон бэлгэдлийн шинжтэй. Харин АНУ-д ерөнхийлөгч хүчтэй гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг. АНУ-ын ерөнхийлөгч нь сайд, албан тушаалтнуудаа нэр дэвшүүлж, төсвөө санал болгох, хууль тогтоомжид хориг тавих, гэрээ хэлцэл хийх, тэр ч бүү хэл дайн зарлах бүрэн эрхтэй.

Ерөнхийлөгчийг бүх нийтийн сонгуулиар эсхүл хууль тогтоогчдын санал хураалтаар томилдог. Хэрэв ерөнхийлөгчийг бүх нийтийн сонгуулиар сонгодог тохиолдолд тэд нийт ард түмний эрх чөлөө, аюулгүй байдалд заналхийлж болзошгүй хууль тогтоомжинд хориг тавих хууль ёсны эрх мэдэл, бие даасан байдалтай байхад хүрдэг. Энэ нь хууль тогтоох эрх мэдлийг хязгаарлах нэмэлт, ач тустай хэрэгсэл болдог.

ҮНДСЭН ХУУЛЬТ ХААНТ ЗАСАГЛАЛ

Сонирхолтой нь либерал ардчилсан улсуудын тоонд хэд хэдэн хаант засагтай улсууд багтдаг. Эдгээр улсуудад хааны эрх мэдэл нь бичмэл Үндсэн хуулиар болон тодорхой хууль журмаар хязгаарлагддаг гэдгийг өмнө нь дурдсан. Эдгээрийн тоонд Их Британи болон Британийн Хамтын Нөхөрлөлийн улсууд, тухайлбал Австрали, Шинэ Зеланд, Канад зэрэг улсууд багтдаг. Европт ч мөн адил Бельги, Дани, Нидерланд, Испани зэрэг хязгаарлагдмал хаант засагтай улсууд ч бий.

Улс бүрийн хаадын эрх хэмжээ харилцан адилгүй. Гэвч ихэнхи тохиолдолд хаан нь бэлгэдлийн шинжтэй үүргийг гүйцэтгэдэг бөгөөд эдгээр хаад ч гэсэн зарим эрх мэдлээ хадгалж үлдсэн. Тухайлбал 1981 онд Испанид төрийн эргэлт хийх оролдлого гарах үеэр Хуан Карлос хаан цэрэг армия хуарандаа буцахыг зарлигдсан нь амжилттай болсон. Үндсэн хуулийн хаант засаглалын гол ач холбогдол нь хаадын хэрэгжүүлдэг эрх мэдэл бус харин цэргийн эрхтэн, шүүгчид болон улс төрчид зэрэг хүмүүсийн эрх мэдлийг сөрж тэнцвэржүүлэх үүргийг хаан гүйцэтгэдэгт оршдог.

ОЛОН ТҮМНИЙ ҮҮРЭГ

Сонгогчид мэдлэггүй харанхуй' байгаа нь ардчиллын үндсэн согог гэж олон хүмүүс шүүмжилдэг. Гэвч сонгогчид тодорхой бодлогын нарийн ширийн бүхнийг өөрсдөө хянан ойлгох шаардлага байхгүй. Тэдний гол үүрэг нь зөвхөн өөрсдийнх нь өмнөөс энэ бүхнийг хийх төлөөлөгчдийг сонгох явдал. Нэр дэвшигчдийн тодорхой асуудалд баримталж буй ерөнхий байр суурийг илтгэх намын шошго нь сонгогчдод хэрэгтэй цорын ганц мэдээлэл ч байж болно.

Сонгогчдын хувьд төлөөллийн тогтолцоо нь хүн бүр шийдвэр гаргахад оролцдог 'оролцооны' тогтолцооноос давуу талтай. Сонгогчид өөрсдийн ажил хэрэг, сонирхолдоо хөтлөгдөн завгүй байх учир улс төрийн хэлэлцүүлэгт цаг зав, мэдлэг туршлагаа зарцуулж чаддаггүй. Иймээс л уг үүргийг тусгайлан хариуцах хүнд шилжүүлэх нь энэ бүхний гол утга учир билээ. Түүнчлэн сонгогчид өөрсдийн сонгосон хууль тогтоогчдоо өөрсдөөс нь илүү мэргэшсэн ур чадвартай, улс төрийн зөв шийдвэр гаргахад шаардлагатай чанаруудыг агуулсан гэдэгт итгэдэг.

Тэгвэл сонгогчдын итгэж найдаж олгосон шийдвэр гаргах эрх мэдлийг урвуулж ашиглахаас чухам юу улс төрчдийг хязгаарладаг вэ? Хувьсгалыг эс тооцвол сонгуульд ялагдана

гэх айдас гэж хэлж болно. Дахин хэлэхэд ардчилал дахь олон түмний гүйцэтгэдэг хамгийн гол үүрэг бол эрх баригчдыг томилох бус тэднийг зайлуулах явдал юм.

Олон түмэн хүчирхэг удирдагчдыг илүүд үзэж, тэдэнд ихээхэн эрх мэдлийг олгож болох нь үнэн хэдий ч тэдний дэмжлэгийг алдсан удирдагч урт хугацаандаа хүчирхэг хэвээр байх боломжгүй. Чөлөөт, шударга сонгуулийн тусламжтайгаар улс төрийн удирдлагын өөрчлөлт энхийн замаар явагдах боломжтой.

Үг хэлэх эрх чөлөө, нээлттэй хэлэлцүүлэг, чөлөөт шударга сонгуулийн ачаар л улс төрчид олон нийтийн дэмжлэгийг хүртэхийн төлөө өрсөлдөж, албан тушаалдаа эргэн томилогдохын тулд ард түмэндээ сайн үнэлгээтэй байх шаардлагатай.

ҮЙЛ ЯВЦЫН ХЯНАЛТ

Сонгуульд саналаа өгөх нь хувь хүний хувьд тийм ч чухал үйлдэл биш байж болох талтай. Гэвч энэ нь ардчилалд чухам ямар хүмүүсээр Засгийн газрыг бүрдүүлэх эсэхийг шийдвэрлэдэг. Ингээд төрийн томилгоотой хамт эрх мэдэл дагалддаг учраас сонирхлын бүлгүүд болон улс төрийн фракцууд заль мэх, хээл хахууль, албадлага, саналын луйвар зэрэг хууль бус аргачлалаар сонгуулийн үр дүнд нөлөөлөх аюул үргэлж заналхийлж байдаг. Бидний санааг чилээх ёстой гол асуудал нь албан тушаалтнууд сонгуулийн тойргийг зориуд өөрчлөх, нийтийн санхүүг сонгуулийн сурталчилгаанд ашиглах, төрийн хэвлэл мэдээллийг нэр дэвшигчдийг гутаахад ашиглах, цагдаа, арми, шүүхийг өрсөлдөгчдийнхөө эсрэг тавих эсхүл нэр дэвшигч бүрт өгсөн саналын тоог зүгээр л худал мэдээлэх зэрэг үйлдлийг хийх боломж үргэлж байдагт оршино.

Либерал ардчилал нь өөрийгөө эдгээр аюулаас хамгаалах механизмтай байх ёстой бөгөөд үүнд бие даасан сонгуулийн тойрог, сонгуулийн хороод, олон улсын ажиглагчид болон нэр дэвшигч бүр төрийн нөөц, хэвлэл мэдээллийг хууль ёсны дагуу ашиглах дүрэм журам болон сонгуулийн луйврыг шийтгэх механизма багтана. Мэдээж хамгийн сайн дархлаа бол эдгээр ялзрал

гажуудлыг эсэргүүцдэг соёл олон нийтэд
хэвшсэн байх явдал билээ.

СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

Сонгуулийн олон янзын тогтолцоо байдаг бөгөөд олон хүмүүс аль тогтолцоо нь хамгийн шилдэг үр дүнтэй тухай өөр өөрсдийнхөөрөө л дүгнэдэг. ‘Хамгийн шилдэг’ гэдэг нь субъектив дүгнэлт бөгөөд бодит байдал дээр тогтолцоо бүр давуу болон сул талуудтай.

Эхэнд ирсэн нь ялагч (*First Past the Post - FPTP*) гэх тогтолцоо нь түгээмэл хэрэглэгддэг тогтолцоо бөгөөд хамгийн олон санал авсан нэр дэвшигч сонгогддог. Энэ нь энгийн ойлгоход хялбар, хурдан бөгөөд тодорхой үр дүнтэй тогтолцоо. Мөн сонгогчдод төр засгийн үйл ажиллагаатай холбоотой тодорхой асуудал гарвал хандах боломжтой эсхүл өөрсдийнх нь үзэл бодол, байр суурийг уламжлан илэрхийлэх тодорхой нэг төлөөлөгчтэй байх боломжийг бүрдүүлдэг. Гэвч олон нэр дэвшигчийн хооронд санал хуваагдвал цөөнхийн дэмжлэгтэй хүн ч сонгогдох боломжтой. Энэ тогтолцоо хоёр намын улс төрийг дэмждэг тул нийтийн санал бодлыг бүрэн хамрах аргагүй. Түүнчлэн сонгуулийн жижиг тойргуудтай бол аль нэг намын ялалт бүрэн дүүрэн баталгаажиж, ялагдах хүлээсэн талын сонгогчдын сонголт тэр чигтээ орхигддог.

Энэ мэт асуудлыг шийдвэрлэх үүднээс хувь тэнцүүлсэн төлөөллийн олон янзын тогтолцоог боловсруулсан байдаг. Үүнд хувилбарт сонголт

(alternative vote) гэх мэтийн аргачлал багтдаг. Сонгогчид нэр дэвшигчдийг давуу саналын дарааллаар эрэмбэлдэг бөгөөд хамгийн бага санал авсан нэр дэвшигчдийг нэг нэгээр нь хасч, тэдний хоёр дахь давуу саналыг бусдад шилжүүлж, эцэстээ нэг нэр дэвшигч нийт олонхын саналыг авах хүртэл үргэлжилдэг. Үүний давуу тал нь хүн бүрийн саналыг ядаж тодорхой хэмжээнд тусгаж өгдөгөөрөө онцлог. Гэвч үүнийг ойлгож, хэрэгжүүлэх нь хүндрэлтэй. Эхэнд ирсэн нь ялагч гэх тогтолцооноос ялгаатай нь гуравдагч намын нэр дэвшигчдийг дэмждэг уг тогтолцоо нь хэт радикал намуудад боломж олгох эрсдэлтэй байж болно.

Өөр нэг хувилбарыг дурдвал олон гишүүнт тойрог (multimember constituencies) бөгөөд энэ нь илүү том тойргуудтай учраас дан ганц нэг намын суудлыг баталгаажуулах магадлал багатай. Нэр дэвшигчдийг нэг шилжих саналын (Single Transferable Vote - STV) тогтолцоогоор сонгодог бөгөөд хасагдсан нэр дэвшигчдийн саналыг шилжүүлсээр суудлын тоонд тааруулах хүртэл явагддаг. Гэвч энэ нь бүр ч илүү ойлгож хэрэгжүүлэхэд бэрх. Сонгогчид хэн тэднийг төлөөлж байгаад эргэлзэхэд хүрдэг. Нэр дэвшигчид сонгогчдод таалагдахаас илүүтэй намын жагсаалтад орохоор хоорондоо тэмцэлдэхэд хүрдэг.

Харамсалтай нь эдгээр хувь тэнцүүлсэн тогтолцоонууд нь давамгайлсан намуудын эвсэлд (coalition of convenience) тулгуурласан Засгийн газар байгуулагдахад хүргэдэг нь ихэвчлэн жижиг, радикал намуудыг ч хамруулдаг. Нөгөө талаас FPTP болон бусад хувь тэнцүүлээгүй тогтолцоонууд нь гуравдагч намуудыг хангалттай төлөөлж чадахгүй байх эрсдлийг дагуулдаг.

Мэдээж өөр бусад хувилбарууд бий. Тухайлбал холимог гишүүнт тогтолцоо (mixed members) байна. Үүнд улс төрийн нам улсын хэмжээнд өндөр хувьтай санал авсан ч цөөн суудал хуваарилагдсан бол намын жагсаалтаас нэмэлт суудал хуваарилагддаг. Гэвч уг тогтолцоо нь нэр дэвшигчдийг сонгогчдод таалагдахаас илүүтэй намын жагсаалтын дээгүүр бичигдэхэд гол анхаарлаа төвлөрүүлэхэд хүргэдэг.

Ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд АНУ нь сонгогчдын коллегийн (electoral college) тогтолцоог ашигладаг. Сонгогчид ерөнхийлөгчид шууд санал өгдөггүй харин орон нутгийн нэр дэвшигчдэд санал өгч, тэдгээр хүмүүс нь эргээд Ерөнхийлөгчөө сонгодог. Ингэхийн ач холбогдол нь том мужуудын сонгогчид жижиг мужуудаа давамгайлахаас сэргийлж, улсаа тэр чигт нь төлөөлүүлэх зорилготой. Гэвч уг тогтолцоо нь ерөнхийлөгч

цөөнхийн саналаар сонгогдох боломжийг бий болгодог. Үүний тод жишээ нь Дональд Трампын 2016 оны мөн Жорж В. Бушын 2000 оны ялалтууд юм.

Эцэст нь дүгнэхэд мэдээжийн хэрэг яг таг ‘шударга’ гэж шууд баталгаатай хэлж болохуйц сонгуулийн тогтолцоо огт байхгүй. Гэхдээ сонгуулийн тогтолцоо ерөнхийдөө нээлттэй, шударга, өөрчлөлт бий болгох боломжийг олгодог байх нь ядахдаа нэр дэвшигчид зэвсэг барин босохын оронд ялагдлаа хүлээн зөвшөөрч, дараагийн боломжоо тэвчээр заан хүлээхээс өөр аргагүйд хүрдэг.

ОЛОН НИЙТИЙН ӨМНӨ ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

Либерал ардчилал нь олон нийтийн өмнө олон янзаар хариуцлага хүлээдэг гэдгээрээ онцгой. Жишээ нь хууль тогтоох байгууллага нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагынхаа үйл ажиллагааг хязгаарлаж зогсоож чаддаг. Шүүх эрх мэдэл нь төрийн шийдвэрүүд хуульд нийцэж, хүмүүсийн эрх хамгаалагдах нөхцлийг баталгаажуулдаг. Хэвлэл мэдээлэл болон бие даасан шинжээчид төрийн бодлогын зөв буруу эсэхийг хэлэлцдэг. Сонгогчид сонгуулиар муу ажилласан засгийн газарт хариуцлага хүлээлгэдэг. Америк маягийн урьдчилсан сонгууль (primaries) болон бусад сонгон шалгаруулалтын арга хэмжээнүүд нь нэр дэвшигчид албан тушаалдаа үнэхээр дүйцэхүйц эсэхийг баталгаажуулахад тустай. Референдум болон нийтийн саналын санаачилга (ballot polling) нь эрх мэдэлтнүүдэд нэмэлт хязгаарлалт болж чаддаг. Холбооны федерал буюу эрх мэдлийн төвлөрөлийг боломжит хамгийн доод түвшинд (хувь хүний түвшинд хүртэл) хүртэл задлах нь хүмүүсийг алслагдсан, дарангуй эрх мэдлээс ангижрах боломжийг олгодог. Мөн ямар ч төрлийн иргэдийн бүлгүүд (иргэний нийгэм) нь үндэсний хэлэлцүүлэгт дуу хоолойгоо хүчтэй хүргэсээр байдаг.

Үндсэн хууль нь эрх мэдлийн нэмэлт хязгаарлалт болж, хувь хүний үндсэн эрх, эрх чөлөөний чухал баталгаа болдог. Гэвч үндсэн хууль боловсруулах үйл явцад онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Ингэх нь эрх баригч намуудын дарангуйлалд гулсах эсхүл улс төрийн институциудыг өөрсдийнхөөрөө өөрчлөхийг эрмэлзэгч үзэл суртал-ашиг сонирхлын бүлгүүдэд хууль хулгайлагдах эрсдлээс сэргийлэх болно.

АРДЧИЛАЛ БА ХУВЬ ХҮНИЙ ЭРХҮҮД ХООРОНДЫН ЗӨРЧИЛ

Ардчилал нь хувь хүний эрх болон олонхын хүсэл зорго хоёрын тэнцвэр дээр тогтдог. Либерал ардчилал нь хувь хүний эрхүүдийг нэн тэргүүнд тавьдаг хэдий ч уг тэнцвэр хэзээ ч бүрэн тогтвортой байж чаддаггүй учир нь хүн бүр нарийвчилсан асуудал бүхэн дээр нэг бүрчлэн санал нэгтэй байх боломжгүйд оршино. Олон нийтийн өмнө хүмүүс ямар үйлдлийг юуг хийж, хэлж болох эсэх, өөрсдийн өмчилсөн газар дээрээ ямар барилга байгууламж барих, мөнгөө юунд хэрхэн зарцуулах (тухайлбал, мөрийтэй тоглоом, биеэ үнэлэгч, мансууруулах бодис, согтууруулах ундаа) эрхтэй вэ гэдэг нь хэлэлцүүлэг маргааны хурц сэдэв болдог. Эрх гэх үзэл баримтлал нь огт маргаан дагуулдаггүй гэсэн үг ердөө биш. Эрх нь өөрөө ёс суртахууны зарчмуудын улс төрийн илэрхийлэл учраас хүмүүс энэ тухай санал зөрөлдөхөөс өөр аргагүй. Либералуудын өмнө тулгардаг үүрэг бол олонхын шийдвэрийн хууль ёсны гэх легитим шинжийг цөөнхийн цаашилбал эцэстээ хүн нэг бүрийн эрх чөлөөг нухчин дарах хэрэгсэл болохоос аль болох зайлсхийж, эрхийг баталгаажуулах явдал.

VI

ОРЧИН ҮЕИЙН
ТӨЛӨӨЛЛИЙН АРДЧИЛЛУУД

ЭРХ МЭДЭЛ ТӨВЛӨРӨХӨӨС СЭРГИЙЛЭХ

Либерал ардчиллын хамгийн том давуу тал нь олон түмэн удирдагчдаа энх тайван замаар солих боломжийг олгодогт оршино. Автократ дэглэмд бослого, хувьсгалын аюул байнга заналхийлдэг тул тэд ихэвчлэн байнгын томоохон зэвсэгт хүчинтэй байж, үүгээрээ шүүмжлэл эсэргүүцлийг дарж, эрх мэдлээ бэхжүүлэхийг эрмэлздэг. Харин эрх баригчдыг үе үе сонгуулиар солих нь тэдэнд эсхүл улс төрийн бүлэглэлүүдэд эрх мэдэл хуримтлагдан төвлөрөхөөс урьдчилан сэргийлдэг. Засгийн газар нэр хүндгүй болсон ч, байнгын сонгууль явагддаг тогтолцоонд хувьсгалт хүчирхийллийн аюул заналхийлэл байдаггүй учраас дарангуйллын хүчин бэхжих магадлал бага. Энх тайван цогцолсон үед л хүний эрч хүч, анхаарал илүү бүтээлч үйл ажиллагаанд чиглэгддэг.

ӨӨРЧЛӨЛТӨНД НИЙЦТЭЙ

Либерал ардчилал нь өөрчлөлтөнд дасан зохицох чадамжтай. Тэд нөхцөл байдал, олон нийтийн бодол санааны өөрчлөлтөнд дасан зохицож чаддаг. Нийгмийн үйл ажиллагаа нь нэг төрлийн үзэл, хандлага, хэвшмэл ойлголтоор хязгаарлагддаггүй учраас либерал ардчилал нь бусад тогтолцооноос илүүтэй ийм чадамжтай байхаас ч өөр аргагүй. Үзэл суртал, хэвшмэл хандлага нь тогтсон үйлдлийг л зөвшөөрч, үүнээс хэлбийх явдлыг зөвшөөрдөггүй. Харин либерал ардчилал нь өөрчлөлтийг хүлээн авч, түүнийг нийгэмд тустай байдлаар ашигладаг. Тухайлбал ардчилал нь олон үзэл санаа, амьдралын хэв маягийг хүлээн зөвшөөрдөг. Тиймээс нөхцөл байдал өөрчлөгдөхөд бидний өмнө өөрчлөлтийг даван туулах, шингээх, чиглүүлэх, эсхүл ашигтайгаар хувиргах олон практик сонголтууд бий болдог. Олон жилийн турш олон нийтийн бодол санаа цагаачлал, нийгмийн халамж, цэргийн интервенц, трансжендерүүдийн эрхийн сэдэв зэрэг чухал асуудлуудаар өөрчлөгдөж болно. Ардчиллын хэлэлцүүлэг, шийдвэрүүд нь үүнтэй зэрэгцэн хамт өөрчлөгддөг. Ардчилал бол аль ч нийгэмд тохирох тогтолцоо билээ.

Либерал ардчиллуудын нээлттэй, хүлцэнгүй, олон талт байдал болон харилцан буулт хийх

чадамж нь дайн, байгалийн гамшиг зэрэг томоохон аюул, үймээн самууны үеэр автократ дэглэмүүдтэй харьцуулахад илүү үр дүнгүй мэт харагдаж болно. Гэвч чухам эдгээр чанарууд нь л ардчилалд урт удаан хугацаанд тогтвортой оршин тогтнох тэсвэр, гайхалтай хүч чадлыг өгдөг бөгөөд үүнийг фашист болон бусад автократ дэглэмүүдийн өнгөрсөн түүх ч нэгэнт нотолжээ.

ҮНЭТ ЗҮЙЛД МААНЬ НИЙЦТЭЙ

Олон судлаачид либерал ардчиллын хамгийн том нэг давуу тал нь хувь хүний тэгш байдал зэрэг чухал үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрч, баталгаажуулдагт оршдог гэж үзэх нь бий. Хувь хүмүүс хоорондын орлого, өмчийн ялгаа үлэмж хэмжээнд байсан байлаа ч тэр иргэн бүхэн сонгуулийн үйл явцад оролцох эрхтэй. Тэд ялгаварлан гадуурхал, хавчлагаас дарамтаас айхгүйгээр сонгогч, улс төрийн намын гишүүн, нэр дэвшигч, эсхүл сонгуулийн сурталчилгааны ухуулагч байх боломж нь нээлттэй. Тэд баян ядуу, чадвартай чадваргүй, хотынх хөдөөнийх, язгуур сурвалжтай эсхүл энгийн иргэн, аль ч угсаатан, шашин, арьсны өнгө, нийгмийн давхарга, гэр бүл, улс төрийн үзэл бодолтой байх эсэх нь хамаагүй. Улс төрийн хувьд тэдний санал ижил жинтэйд тооцогддог.

Мөн ардчилал нь нийгмийн оролцоог дэмждэг үгүйдээ л хэн нэгнийг эрх баригчид ‘шаардлага хангаагүй’, ‘зохисгүй’, ‘сахилга батгүй’ эсхүл ‘урвагч’ гэж цоллоод улс төрд оролцох оролцоог нь хязгаарладаггүй гэдгийг нь сайшаах хүмүүс олон. Ардчилалд хүн амыг захирагч ба захирагдагч гэж ангилдаггүй. Харин бусад дэглэмд ингэж ангилах явдал түгээмэл. Либерал ардчилалд хүн бүр идэвхтэй иргэн болж улс төрийн албан тушаалд нэр дэвших эрх

нь нээлттэй бөгөөд сонгогчдын олонх л чухам хэн нь албан тушаалд тохирох эсэхийг шийддэг.

Нийгмийн үйл хэрэгт ийнхүү иргэд өргөнөөр оролцох явдал нь тэдний оюун санаа, ёс суртахуун, улс төрийн хөгжил дэвшлийг дэмждэг гэж ардчиллыг дэмжигсэд үздэг. Энэ нь хүмүүст улс төр, ёс суртахууны асуудлаар бодож, хэлэлцэж, тэдгээрийг шийдвэрлэх хамгийн зүй зохистой бодлогын арга хэмжээг тодорхойлох боломж, сэдлийг нь нэмэгдүүлдэг.

ЗОХИСТОЙ БОДЛОГОД ХӨТӨЛДӨГ

Либерал ардчилал гэдэг нь бид өөрсдийн сонгосон төр засаг, хуулийн дор амьдрахыг хэлж буй хэрэг. Үгүйдээ л эрх баригчдын бидэнд тулгасан бүхний дор бус дээрх зарчмууд тодорхой хэмжээнд үйлчлэхийг хэлнэ. Ингэснээр бид нийгэмд хүч хэрэглэх явдлыг боломжтой хэмжээнд хязгаарлаж, улс төрийн өөрчлөлтийг тайван, зөвшилцлийн арга замаар явагдах боломжийг бүрдүүлдэг.

Чөлөөт шударга сонгууль, нээлттэй засгийн газар, нэр дэвшигчид болон сонгогдсон албан тушаалтнуудын хариуцлага, ил тод байдал гэх мэт нь либерал ардчиллын салшгүй шинжүүд. Улс төрчид сонгуульд олон нийтийн дэмжлэгийг авахын төлөө өрсөлдөхдөө тэдний үйл ажиллагаа, чадвар, зан чанар нь бүгд нарийвчилсан шалгуураар дүгнэгддэг. Америкийн сэтгэгч Х. Л. Менкен (1956) үүнийг маш хоржоонтойгоор “Ардчилалд нэг нам нь нөгөө намаа засаглахад огт тохиромжгүй гэдгийг батлахад гол хүчээ зарцуулдаг. Хоёулаа үүнийгээ амжилттай хэрэгжүүлдэг мөн аль алиных нь ч зөв байдаг.” гэж илэрхийлсэн удаатай. Гэхдээ нам хоорондын өрсөлдөөнөөс гадна нэр дэвшигчдийг сонгогчид нь нарийн тодорхой шалгуурын дагуу үнэлж дүгнэдэг бөгөөд нэр дэвшигчдийн алдаа дутагдлыг

бусад нэр дэвшигчид нь хялбархан олзолдог. Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр нэр дэвшигчдийг олон түмэн магтаал шүүмжээр булдаг бөгөөд тодорхой сонирхлын бүлгүүд тэдний дэвшүүлсэн бодлогын асуудлыг ч хөндөх нь элбэг.

Шударга, зүй бус байсан нь мэдэгдвэл мэдээж тэд шийтгэл хүлээдэг. Хэрэв иргэд өөрсдийн сонгосон албан тушаалтнууд авлигад автсан, ур чадваргүй эсхүл буруу шийдвэр гаргасан гэж үзэх аваас дараагийн сонгуулиар тэднийг өөрчлөх бөгөөд тэр ч бүү хэл зарим улсад албан тушаалтнуудыг эргүүлэн татах санаачлагаар зайлуулдаг.

ШҮҮМЖЛЭЛ БА АХИЦ ДЭВШИЛ

Либерал ардчиллын үндсэн зарчмуудын нэг болох бусдын үзэл бодолд хүлцэн тэвчихүйн үүднээс хандах явдал нь улс орны удирдагчдыг шүүмжлэх бололцоог олгодог нь тодорхой автократ дэглэмүүдийн хувьд зүй бус огтоос боломжгүй үйл хэрэг байх нь олонтаа. Шүүмжлэлээс дархлагдсан автократууд нь дуулиан шуугианыг намжааж, алдаа эндэгдлээ нуух мөн үл тоомсорлох хандлагатай. Парламентыг зөвхөн ‘чалчдаг газар’ гэж шүүмжилдэг боловч нээлттэй талбарт чөлөөтэй үгээ хэлэх боломж нь эрх баригчид болон тэдний үзэл санааг шүүмжлэл, сорилтонд оруулахад маш чухал. Олон нийтийн хэлэлцүүлэг нь дараа дараагийн сонгуульд эрх баригчдад хариуцлага тооцоход шаардлагатай мэдээллийг сонгогчдод дамжуулах хэрэгсэл болдог.

Энэ бол хүн төрөлхтний ахиц дэвшилд тун чухал үүрэг бүхий хүчин зүйл. Шинээр өргөн барьсан нийтийн бодлогын санал санаачлагууд болон аль ч сэдвийг хамарсан санал, санаачлагууд нь нээлттэй хэлэлцүүлгээр шигшигдэж, давуу болон сул талуудыг нь тэнсэн үзэх боломжтой. Энэ нь боломжит сайн санааг сайжруулж, барагтайхан санааг хохирол учруулахаас нь өмнө засаж залруулах эсхүл түүнээс татгалзах боломжийг олгодог. ‘Олон

түмний мэргэн ухаан'-ыг ийнхүү зүй зохистой ашигласнаар ардчилал нь эрх баригчдын шийдвэр нээлттэй хэлэлцүүлгээр шигшигдэж, сорилтонд ордоггүй тогтолцоонуудаас илүү оновчтой бодлогын шийдвэр гаргах боломжийг бүрдүүлдэг.

ХУВЬ ХҮНИЙ ЭРХИЙН БАТАЛГАА

Брюс Буэно де Мескита болон түүний судалгааны хамтрагчид (2003) ардчиллын институциудыг сайтар цогцлоосон улс орнууд нь хүний эрхийг хамгаалах тал дээр өндөр үр дүнтэй байдаг гэдгийг судалгаагаар тогтоосон байна. Ардчилал нь хар аяндаа эдгээр ач тустай бүхнийг бий болгодог гэж хэлэх боломжгүй ч эдгээр эрхийг хамгийн үнэ цэнэтэй гэж үздэг улс орнууд ардчилал л зөвхөн энэ бүхнийг хамгаалах боломжтой хамгийн сайн тогтолцоо гэж итгэдэг гэж хэлэх бүрэн үндэслэл бий. Ямартай ч либерал ардчилсан улсууд л амьдрал, эрх чөлөө, өмч, эвлэлдэн нэгдэх эрх, үг хэлэх эрх чөлөө, улс төрийн үйл явцад тэгш оролцох гэх мэтийн эрхийг хамгаалах хамгийн хүчтэй хамгаалалтыг бүрдүүлсэн байдаг.

Хэдий ардчилсан тогтолцоо болон эрхийн хамгаалалтуудыг өөр хооронд нь бүрэн дүүрэн салгаж ойлгох боломжгүй боловч олонхын хүсэл зорго болон хувь хүний эрх, эрх чөлөө хоёрын хооронд зөрчил байсаар байдаг. Олонх болон тэдний сонгосон улс төрчид хүмүүсийн эрхийг хязгаарлах зүй ёсны үндэслэл байдагт итгэх нь бий. Тухайлбал терроризмын аюулаас олон нийтийг хамгаалахын тулд цагдаа болон аюулгүй байдлын байгууллагуудад хувь хүнийг урт хугацаанд баривчлах, гудамж

тохой, барилга байшинд гэнэтийн нэгжлэг үйлдэх, радикал улс төрийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэхийг хориглох эрх мэдлийг өгөх нь зүйтэй гэх шийдвэрийг гаргадаг. Эсхүл цар тахлаас урьдчилан сэргийлэхийн тулд бизнесүүдийг хааж, хүмүүсийг гэрт нь хорих шийдвэрийг гаргах жишээтэй. Харамсалтай нь иргэдийн амь нас, эрүүл мэнд, өмч, аюулгүй байдлыг хууль ёсоор хамгаалах болон ардчилсан дэглэмийн нэрээр иргэдийг хууль бусаар дарлах хоёрын хооронд үнэндээ яг таг тодорхой хил хязгаар байхгүй. Тиймээс хувь хүмүүсийн эрхийг хязгаарлах эдгээр санаачлагуудыг маш нарийн чамбай нягталж, анхааралтай үнэлэлт дүгнэлтийг өгөх шаардлагатай.

ЭНХ ТАЙВАН, ХӨГЖИЛ ДЭВШИЛ

Ардчилсан улсууд өөр хоорондоо зэвсэгт мөргөлдөөн үйлддэггүй гэх үзэл хандлага түгээмэл. Гэхдээ түүх арай өөрийг өгүүлдэг. Гэвч ардчилсан дэглэм нь бусад төрийн дэглэмээс илүү энх тайвнаар зэрэгцэн орших боломжийн бүрдүүлдэгт олон шалтгаан бий. Сонгогчид цэргийн дарангуйлагчдаас ялгаатай нь ихэнхи тохиолдолд зэвсэгт мөргөлдөөнд тийм ч идэвхи сонирхолтой байдаггүйгээс гадна эцсийн эцэст тэд алдах зүйл ихтэй. Ардчилсан тогтолцоонд засгийн газрууд иргэдийн амь нас, аюулгүй байдал, өмчийг үл тоомсорлох боломжгүй.

Либерал ардчилал нь илүү хөгжил цэцэглэлтэнд хөтөлдөг ч гэх нь бий. Өнгөрсөн хоёр зууны туршид сайн засаглал болон хөгжил цэцэглэлт нь хамтдаа оршсоор ирсэн. Гэхдээ ардчилал нь илүү их хөгжил дэвшилд хөтөлдөг гэдэг нь тодорхой бус. Их Британи зэрэг олон улс орнууд бүх нийтийн сонгуулийн эрхийг хүмүүст олгож, сонгуулиа ил тод болгохоосоо ч өмнө нэгэнт эдийн засгийн хувьд чинээлэг, хүчирхэг байдалтай болсон байв. Иймд тэдний бүтээсэн баялагийг ардчилал л бий болгосон гэж үзэх аргагүй. Хэрвээ хөгжил дэвлийг дэмждэг голлох хүчин зүйл байдаг бол тэр нь чухам ардчилал бус харин хувь хүний эрхийг хүндэтгэх явдал тэр тусмаа хувь хүмүүст

өөрсдийн хүслээр ажиллаж хөдөлмөрлөх, үйлдвэрлэл үйлчилгээ, худалдаа арилжаа хийх боломжийг олгосон явдал гэж хэлэх бүрэн үндэс бий. Гэхдээ ардчилсан улсуудад эдгээр эрхийг хүндэтгэх магадлал нь илүү өндөр байдаг.

Хэдий ардчилал нь маш тогтвортой боловч үүнд бас хөгжил дэвшлийн хөдөлгүүрийг гацаах чадамж бий. Сонгуульд олонхын дэмжлэгийг авсан гэх ёс суртахууны итгэл үнэмшил, бардамнал нь эрх баригчдад баялаг бүтээгчдийг тонон мөлжих итгэлийг төрүүлж болзошгүй.

ДҮГНЭЛТ

Либералын ардчилал нь бусад засаглалын хэлбэрүүдээс өөрчлөлтөнд дасан зохицох, эрх баригчдыг болон улс төрийн бодлогыг тайван замаар зайлуулах гэх мэт чадамжийнхаа хувьд илүү давуу талтай гэдэг нь бодитой. Ийнхүү илүү сайн бодлого боловсруулахад түлхэц болж, хувь хүний эрхийг хамгаалж, хөгжил дэвшлийг дэмжиж, энх тайвныг хөхиүлэн дэмждэг ч байж болно. Гэвч эдгээр боломжит ач тусын дийлэнхи нь бидний төсөөлж байгаа шиг бүрэн тодорхой бус юм. Өөрөөр хэлбэл ардчилал нь шүүмжээс ангид байх ёстой тогтолцоо гэсэн үг ердөө биш.

VII

АРДЧИЛЛЫН ШҮҮМЖ

Ардчилал өөрийн давуу талуудтай ч гэсэн өртөгтэй. Ардчилал нь олон асуудлыг шийдвэрлэдэг ч гэсэн олон шинэ асуудлыг бий болгодог. Ардчиллыг зөвөөр хэрэгжүүлэх нь туйлын хүндрэлтэй бол буруугаар ашиглах нь тун хялбар гэдгийг олон хүмүүс хэлдэг. Ардчиллын гүйцэтгэл хэзээ ч төгс байсангүй. Популист намууд хүчирхэгжиж байгаа нь олон сонгогчид ардчилал нь тэдний өмнө үүргээ гүйцэтгэж чадахгүй байна гэж үзэх болсонтой холбоотой. Ардчилал нь хамсаатны кронизм, хүнд сурталт аппарат, хэт засаглал, тонуул мөлжлөг болон сонгогчдын харалган байдал (богино хугацаанд хэт төвлөрсөн), хувь хүний эрхийн доройтол зэрэг асуудлуудад туйлын эмзэг. Ардчилал нь бодит байдал дээр эсхүл бүр зарчмын хувьд тодорхойлолт шигээ байж чаддаг уу?

СОНГОГЧДЫН ЧАДАМЖ

Зарчмын хувьд сонгогчид чухал шийдвэрүүдийг гаргахад найдвартай суурь болж чадах эсэх тухай асуудал нь маш чухал. Бодит байдал дээр үүнд эерэг хариулт өгөх боломж хомс. Сонгогчид улс төрийн асуудлаар маш бага мэдээлэлтэй байдаг. Тэд өөрсдийнх нь ганц санал сонгуулийн үр дүнг тодорхойлоход ямар ч үр нөлөөгүй гэдгийг мэддэгтэй ч энэ байдал нь холбоотой байж болно. Хувь хүний санал саяын эсрэг нэгтэй харьцах хэмжээний нөлөөтэй. Иймд таны саналын нөлөө бага цаашилбал огт нөлөөгүй гэдгийг та өөрөө мэдэж байгаа тохиолдолд бодлогын асуудлаар өөрийгөө боловсруулах нь ямар ч утга учиргүй.

Суурь шалтгаан нь юу ч байлаа гээд сонгогчдын харанхуй, мэдлэггүй байдал үнэхээр гайхширмаар. Америкийн эдийн засагч Брайан Каплан (2007) ‘Рациональ сонгогчын тухай төөрөгдөл’ номондоо дараах баримтыг

“Америк иргэдийн талаас илүү хувь нь муж бүр хоёр сенатчтай гэдгийг дөрвөн хүн тутмын гурав нь сенатчын бүрэн эрхийн хугацааг мэддэггүй. Ойролцоогоор 70% нь Төлөөлөгчдийн танхимд аль нам зонхилж байгааг хэлж чаддаггүй, 60% нь Сенатад аль нам олонх болсныг огт мэддэггүй. Хагасаас илүү хувь нь тойргийнхоо конгрессын гишүүний нэрийг нэрлэж чаддаггүй, 40% нь

мужийнхаа хоёр сенатчын аль нэгийг ч нэрлэж чаддаггүй ... Цаашилбал, иймэрхүү мэдлэг мэдээллийн түвшин нь санал асуулгын эхэн үеэс хойш тогтвортой байсаар ирсэн бөгөөд олон улсын харьцуулалтаар Америк иргэдийн улс төрийн ерөнхий мэдлэг нь дунджаас тийм ч их доогуур биш” дурдсан байна.

Ардчиллын онолчдын тайлбарладаг шиг сонгогчид сонгуулийн саналаа зөвхөн дэмжсэн нэр дэвшигчээ сонгоход үргэлж ашигладаггүй байна. Харин ч төр засагтаа сэтгэл дундуур байгаагаа илэрхийлэх эсхүл өөрсдийн сэтгэлийн гүн дэх бүрэн тодорхой бус хэвшмэл үзэл бодлоо илэрхийлэхийн тулд зарим тохиолдолд радикал нэр дэвшигчдэд санал өгдөг. (XX зууны Америкийн улс төрч, дипломатч Адлай Стивенсон II өөрт нь АНУ-ын бүх ухаалаг хүмүүс саналаа өгөх болно гэж хэлсэн нэгэн дэмжигчид “Сонсоход таатай байна, гэхдээ надад олонхын санал хэрэгтэй!” гэж хариулсан гэдэг.) Сонгогчид ухаан бодлоороо бус харин зөн совингоороо санал өгдөг учраас нэр дэвшигчид ч гэсэн тэдний сонсохыг хүссэн бүхнийг нь ярихад хүрдэг. Алдар нэр, сонгуулийн саналын төлөөх уралдаанд нэр дэвшигчид (мөн адил сонгогдсон улс төрчид ч гэсэн) ухаалаг, рациональ маргалдаж мэтгэхийн оронд уриа лоозон, товч хэллэг ашиглан оролцдог.

Ардчиллыг шүүмжлэгчдийн үзэж байгаачлан үүний үр дүнд ухаалаг бус мэдлэггүй харанхуй байдлыг удирдлага болгосон сонгуулийн үр дүн, нийтийн бодлого хэрэгжихэд хүрдэг байна.

Нэр дэвшигчид болон сонгогдсон улс төрчид бас лоббичдын нөлөөнд автдаг. Эдгээр лоббичид өргөн хүрээний тууштай саналын блокуудыг цуглуулж чаддаг бөгөөд нэр дэвшигчдийн сонгууль, хэвлэл мэдээллийн кампанит ажил, мөнгө санхүү нь тэднээс хараат байх нь элбэг. Лобби хийснээр авах боломжит шагнал маш өндөр байж болно. Салбарт нь татварын хөнгөлөлт үзүүлэх, бизнесийнхээ өрсөлдөгчдийг хязгаарласан зохицуулалтыг хийлгэх эсхүл засгийн газрын томхон гэрээ хэлцлээс хүртэх боломж нь бизнесүүдийн үйл хэрэгт асар их давуу талыг бий болгодог. Үнэндээ боломжит шагналын хэмжээ том байдаг учраас ардчиллын төв болсон нийслэл хотуудад тухайлбал Вашингтон ДС-ийг тойрсон ‘Бүслүүр’ хурдны замууд болон Лондонгийн Вестминстерийн ‘Тосгон’ гэх дүүргийн орчин тойронд лоббигоор мэргэшсэн корпораци, фирмүүд болон олон нийттэй харилцах албадаар дүүрсэн байдаг.

Гэхдээ лобби хийх нь цаг хугацаа, хүчин чармайлт, мөнгө санхүүгийн зардлыг шаарддаг. (Вашингтоны нэгэн судалгааны хүрээлэнгийн тооцоолсноор зөвхөн санхүүгийн зардал

нь жилд ойролцоогоор 3,5 тэрбум долларт хүрсэн.) Тиймээс лоббигоор дагнагчид ихэвчлэн нийтийн бодлогод өөрчлөлт оруулахыг хүсдэг хүчтэй бүлэг эсхүл хувийн ашиг сонирхолд хөтлөгдөж эрх баригчдаас тусгай эрх олж хүртэхийг эрмэлзсэн хүмүүсээс бүрддэг. Тэдний сонирхол нь олон нийтийн сонирхолтой (ихэнхдээ) зөрчилдөх нь элбэг. Эндээс харахад лобби нь нийт хүн ам дагаж мөрдөх ёстой бодлогын шийдвэрт нөлөөлөх маш өндөр өртөгтэй, гажуудсан, төлөөллийн бус ухаангүй арга болж хувирахад хүрдэг. Гэхдээ үүнийг ардчиллын өөрийнх нь салшгүй нэг хэсэг гэж ардчиллыг шүүмжлэх нь бий.

Аливаа шинэ хууль, зохицуулалт бий болгох тухай санал санаачлага бүхнийг үргэлж маш анхаарал болгоомжтойгоор нарийвчлан хянах ёстой бөгөөд хамгийн няхуур, сэрэмжтэй байдлаар үнэлэлт дүгнэлт өгсөний дараа л батлагдах боломжийг олгох ёстой. Эдгээр санал, санаачлагууд нь нийтийн ашиг сонирхолтой хэзээ ч бүрэн дүүрэн нийцдэггүй бөгөөд ихэнхи тохиолдолд олон түмнийг хуурах, дарлан мөлжих ашиг сонирхолтой хүмүүсийн бүлгээс эх сурвалжтай байдгийг харгалзах ёстой. Тэдгээр хүмүүс олон түмнийг дарлан мөлжсөөр ч ирсэн.

— Адам Смит (1776), "Үндэстнүүдийн баялаг", Ном I,
Бүлэг XI

АРДЧИЛАЛ ҮР НӨЛӨӨ ...

Ардчилсан тогтолцоог маргаан дагуулсан, хүнд хэцүү эсхүл онцгой нөхцөлд түргэн шуурхай гаргах ёстой шийдвэрүүдийг гаргахад үр дүн муутай гэж шүүмжлэх нь элбэг. Олон түмэн, улс төрчдийн дунд олон янзын үзэл бодол зонхилдог учраас зөвшилцөлд хүрэхгүй гацах эсхүл олон төрлийн сонголтуудыг хурдацтай боловсруулах чадамжгүй гэдэг. Улс орны хувьд онцгой байдал тохиож, хурдацтай хариу арга хэмжээ авах шаардлагатай үед парламентаар хэлэлцүүлэг хийгээд байх нь зохимжгүй. Эрх мэдэл хууль тогтоох танхим хооронд эсхүл хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн хооронд хуваарилагсан байдаг учраас тодорхой бодлогыг санал нэгтгэйгээр хэрэгжүүлэх шийдвэрийг гаргахад урт хугацаа шаардагддаг.

Түүнчлэн шийдвэрлэх ёстой асуудлууд яаралтай тулгамдсан шинжтэй биш байсан ч хурц маргаан дагуулсан, зөвшилцөлд хүрэх талуудын тоо олон байгаа үед олон нийтийн болон парламентын түвшинд урт хугацааны, түвэгтэй хэлэлцүүлэг явагдахад хүргэдэг. Их Британийн Ерөнхий сайд асан Клемент Аттли (1957) нэгэнтээ маш хурцаар “Ардчилал гэдэг нь хэлэлцүүлгээр засаглахыг хэлнэ, гэхдээ энэ нь хүмүүсийг амыг нь хамхиулж чадсан цагт л үр дүнтэй.” гэж хэлсэн удаатай. Хэрвээ санал

тэнцэх, эсвэл олон янзын боломжит сонголтууд байсаар байвал шийдвэр гаргах үйл явц бүр ч гацаанд ордог. Ихэнхи тохиолдолд асуудлыг нотолгоо, ухаанд тулгуурлаж биш зөвхөн өөр өөр бүлгүүдийн дэмжлэгийг худалдан авахын тулд харилцан буулт хийх мэтчилэнгийн ‘найраа’-гаар шийддэг.

... МУУТАЙ ШИЙДВЭРҮҮДЭД ХӨТӨЛДӨГ

Ардчиллын замаар сонгогдсон төлөөллийн төр засгуудад муу шийдвэр гаргах олон янзын хөшүүрэг бий. Төрийн эрх мэдэл нь татвар ноогдуулах, өмчийг нийгэмчлэх зэргээр олонхид цөөнхөө дарлан мөлжих хялбар боломжийг бүрдүүлдэг талтай. Олонхын шийдвэрүүд төрийн эрх мэдэл болон ‘ардчилсан’ гэх легитим хамгаалалтаар баталгаажих үед уг мөлжлөгийн цар хүрээ хаа хүрч болохын тухайд тодорхой хязгаар гэж үгүй. Муугаар хэлбэл энэ нь хуульчлагдсан тонуул. Сайндаа өндөр татвар, өмчийг нийгэмчлэх аюул нь хүмүүсийг шаргуу ажиллах, үйлдвэрлэлд шаардлагатай капитал, баялаг хуримтлуулахаас сэргийлдэг. Энэ нь ч бас үр өгөөжгүй. Ардчиллыг шүүмжлэгчдийн хэлж буйгаар хувь хүмүүс өөрсдийн орлогыг албан татвар төлөгчдийн мөнгийг зарцуулдаг улс төрчдөөс илүү хянуур болгоомжтой, үр өгөөжтэй байдлаар зарцуулдаг аж.

Илүү ноцтой нь улс төрчид сонгогчдын харалган үзэл бодолд нийцүүлж илт хор хөнөөлтэй шийдвэрүүдийг ч гаргадаг. Жишээ нь бүх л эдийн засагчид чөлөөт худалдааны ач тусыг хүлээн зөвшөөрдөг боловч улс төрчид олон нийтийн гадаад худалдааны өрсөлдөөнтэй холбоотой айдсыг далимдуулан гаалийн албан татвар, импортын хориг хязгаарлалт зэрэг

протекционист арга хэмжээг дэмждэг. Олон түмнийг “ажлын байраа гадаадын өрсөлдөгчдөд алдахын аюул”-аар айлгах нь чөлөөт худалдааны бий болгох алс холын, бүрхэг ач тусыг сурталчлахаас илүү үр дүнтэй.

БОГИНО ХУГАЦААНД ТӨВЛӨРДӨГ

Сонгуулиар сонгогдсон улс төрчид богино хугацаатай албан үүргээ гүйцэтгэдэг нь муу шийдвэрийг улам бүр өөгшүүлдэг ч гэж хэлж болно. Тэд олон түмний таашаалыг хүртэж буй бодлогын арга хэмжээний богино хугацаанд бий болгосон үр дагаварын алга ташилтыг хүртдэг ч эдгээр бодлогын урт хугацааны хорт үр дагаварын хариуцлагыг хүлээхүйц урт хугацаанд албан тушаалдаа үлдэх нь ховор. Иймээс тэдэнд зардлаа нэмэгдүүлэхийн тулд мөнгө зээлэх эсхүл хэвлэх нь улс төрийн хувьд илүү ач тустай, утга учиртай учраас өөрсдийнх нь халааг залгамжилсан хүмүүст улсын өр, өндөр инфляцийг үлдээх нь маш түгээмэл.

Илүү рациональ улс төрийн тогтолцоо нь богино хугацаанд улс төрчид олон нийтийн талархлыг хүлээхэд зориулагдсан бус иргэдийнхээ урт хугацааны хөгжил цэцэглэлтийг бий болгоход чиглэгдсэн бодлого хэрэгжүүлэх ёстой гэж ардчиллыг шүүмжилдэг. Рациональ тогтолцоо нь зөвхөн олонхын атаа жөтөөг намжаах эсхүл бусдын зардлаар үнэгүй халамж, тэтгэмж авах олонхын хүслийг хангах үүднээс бүтээлч хүмүүст татвар ноогдуулж, тонон мөлжихийг зөвшөөрөхгүй. Гэхдээ хатуу хязгаарлалт тогтоохгүй бол ‘ардчилсан’ тогтолцоонууд яг ийм нөхцөл рүү хальтардаг.

Урт хугацааны хөрөнгө оруулалтыг бий болгоход тустай биш өнөөдрийн хэрэглээний төлөө капиталаа бардаг. Ингэх нь зайлшгүй нийгмийн урт хугацааны хөгжил дэвшилд маш хортой.

Нэгэнт хүн бүр шахуу сонгогч болохын хувьд уг үйл явцад оролцдог учраас энэ бол тэдний ‘өөрсдийн’ төр засгийн болон ‘өөрсдийнх’ нь шийдвэр гэж амыг нь тагладаг. Иймэрхүү суртал ухуулга нь олонхын зүгээс цөөнхийн бүлгүүдийг дээрэлхэх, тонон дээрэмдэх явдлыг хэвийн, хууль ёсонд нийцсэн цаашлаад ёс суртахуунтай үйлдэл мэтээр ойлгуулдаг. Хэн ч байсан ингэх л байсан гэх зэргээр өөрсдийгөө өмгөөлдөг.

ТӨРИЙН ХҮЧ, ЭРХ МЭДЭЛД ДУЛДУЙДДАГ

Ардчиллаар сонгогдсон засгийн газруудын шийдвэр хэчнээн муу байлаа ч үүнээс зайлсхийх боломж танд үгүй. Олонхын шийдвэрүүд нь торгууль, ял шийтгэл, лиценз, худалдааны зөвшөөрлийг нь хүчингүй болгох гэх мэтийн бусад олон хориг арга хэмжээний аюул заналхийллээр дамжуулж үүнийг хүлээн зөвшөөрөөгүй хүмүүст ч гэсэн хүчээр тулгагддаг. Мөн зайлсхийх арга байхгүй бөгөөд энгийн иргэдэд хэн нэгний тэр тусмаа өөрсдийг нь дарлан мөлжигч засгийн эсрэг хүч хэрэглэх эрх байхгүй.

Ардчилсан аргаар шийдвэр гаргах нь ‘үнэгүй зайдлах’ бэрхшээлийг шийдвэрлэхэд тусалдаг нь үнэн. Хүн бүр зэвсэгт хүчний болон цагдаагийн байгууллагын хамгаалалт гэх мэтийн нийтийн бараа үйлчилгээнээс ач тусыг хүртдэг тул хүн бүр түүний зардлаас хуваалцах шаардлагыг тавих нь зүй ёсны мэт санагддаг. Гэвч ардчиллыг шүүмжлэгчдийн үзэж буйгаар асуудал нь бид төрд хүмүүсийг татварлах эрхийг олгомогц логикийн хувьд зогсох цэг байхгүй болчихдогт л гол бэрхшээл буй.

Мөн адил онц байдлын үед засгийн газар хувь хүн болон иргэний эрхийг хязгаарлах нь зүй ёсны гэж үзэх боломжтой. Тухайлбал, терроризм

хийхээр төлөвлөсөн гэж сэрдэгдсэн хүмүүсийг тагнах, баривчлахаас өөр арга байхгүй. Гэхдээ ардчиллыг шүүмжлэгчдийн хэлсэн ёсоор төр ‘онц байдлын’ эрх мэдлийг өөртөө шилжүүлмэгц түүний хэрэглээнд тодорхой хязгаар байхгүй болж хувирдаг. Ф. А. Хайекын (1979) тэмдэглэсэн ёсоор “Онц байдал зарлах нь үргэлж хувь хүний эрх чөлөөний хамгаалалтыг доройтуулахын шалтаг болсоор ирсэн.” байна.

Тухайлбал, 2007-2008 оны Санхүүгийн хямрал нь Өрнөдийн улсуудын засгийн газруудад банкуудыг хяналтандаа авч, бусад санхүүгийн бизнесүүдэд хүнд хүчир зохицуулалт тогтооход хүргэсэн түүхтэй.

Арав гаруйхан жилийн дараа Ковид-19 цар тахлын үеэр хамгийн либерал гэгддэг ардчилсан улсууд хүртэл зорчих хөдөлгөөнийг хориглосон нь (иргэдийг гэрт нь хорих санаачлагыг дэвшүүлэх жишээтэй) гайхалтай. Мөн бизнесүүдийг хааж хорьж (фитнесс, спортын арга хэмжээ, үсчин, ресторан зэрэг) ‘чухал бус’ бараа бүтээгдэхүүний худалдаа арилжааг хориглож, төрийн хэвшлийг асар ихээр тэлсэн. 2020 оны эхээр олон хүн вирусыг хяналтаас алдахгүйн тулд түр зуурын иймэрхүү хязгаарлалтыг сайн дураараа хүлээн зөвшөөрч байлаа. Гэвч хязгаарлалтууд нь он жил дамнан урт хугацаанд үргэлжилж (бүр гүнзгийрсэн)

олон нийтийн дургүйцлийг төрүүлсэн. Улс төрчид хожим нь төрийн эрх мэдлийг ашиглаж энэ арга хэмжээг хүлээн зөвшөөрөөгүй олон иргэдэд хатуу хяналтыг тулгасан бөгөөд эдгээр иргэд өөрсдийгөө ‘цагдаажсан төр’-ийн дор амьдарч байна гэж гомдоллож байсан.

Хэрэв дэлхийн хамгийн либерал гэгдэх ардчилсан улсуудад хувь хүний эрхийг ийм хялбархан түдгэлзүүлэх боломжтой аваас сонгогчдын олонхоос эрх баригчдад олгож буй улс төрийн эрх мэдлийн тухайд маш болгоомжтой хандахгүй бол огт болохгүй гэж ардчиллынг шүүмжилдэг хүмүүс хэлдэг. Тэдэнд ямар ч эрх мэдэл олгосон бай энэ нь бидний эсрэг санаатайгаар болон санамсаргүйгээр ашиглагдах боломжтой. Улс төрчид хувь хүмүүсийн эрхийн хүчтэй хамгаалалтын урт хугацааны нэн чухал ач холбогдлыг ойлгодоггүй. Эсхүл тэд эрхийн зөрчил үйлдэж байгаагаа ч мэдэхгүй байх нь бий. Мөн мэдсэн байлаа ч гэсэн өөрсдийнхөө эрх мэдлийг нэмэгдүүлэх хүчтэй богино хугацааны инсентивтэй байдаг.

Эндээс харахад ардчилсан тогтолцоо нь гайхалтай тогтвортой гэдэг нь нотлогдсон. Либерализмын үнэт зүйлсийг төр баримтлах соёл давамгайлсан цаг үеүүдэд л хүн төрөлхтөн ахицтай хөгжиж дэвшсэн гэдэг нь маргаангүй. Энэ нь зөвхөн эдийн засгийн ололт бус шинжлэх

ухаан, технологи, урлаг, боловсрол, утга зохиол болон бусад олон зүйлийн хувьд ч мөн ижил. Хэн ч ийм ахиц дэвшлийг сайн дураараа золиослох хүсэлтэй байхгүй нь тодорхой. Бидний санааг чилээх ёстой гол асуудал нь дээрхи ахиц дэвшлийг санамсаргүйгээр доройтуулах явдал билээ.

ДАНХАР ТӨРИЙН ЭХ СУРВАЛЖ

Онол ёсоор ардчилал нь цомхон төрийг хүсдэг болон нийгэм, эдийн засгийн асуудалд төрийн оролцоог илүү шаарддаг хүмүүсийн аль алиных нь хувьд төвийг сахисан шинжтэй. Гэвч ардчилал нь хамтын шийдвэр гаргах арга хэрэгсэл гэдгийг бүү мартаарай! Польшийн социалист онолч Роза Люксембург (1899) “Ардчилал нь социализмд зайлшгүй хүргэх хэрэгсэл” гэж тодорхойлсон ч удаатай. Либералууд төрийг хязгаарлахыг оролддог ч чухам аль шийдвэрийг хамтаар, алийг нь хувь хүний түвшинд шийдвэрлэх ёстойг тодорхойлох объектив арга байдаггүй. Практикт ардчиллыг улс төрийн хувьд төвийг сахисан шинжтэй гэж үзэх арга алга. 1900-ээд оны эхээр ардчилсан төрүүд нь үндэсний нийт орлогын ердөө 10 хувийг зарцуулдаг байсан бол 2000-аад оны эхээр 40-50 хувь болж нэмэгдсэн. Эндээс хувь хүний түвшинд бус хамтын шийдвэрээр шийдэгддэг зүйлсийн хүрээ хязгаар улам бүр өргөжсөн болох нь илт харагдаж байна.

XX зууны туршид төрийн нийгмийн үйлчилгээний салбар хүмүүсийн амьдралын олон талбарыг хамарч, нийгмийн халамж, эрүүл мэнд, орон сууц, боловсрол, даатгал, тээвэр, үйлдвэрлэл гэх мэт бүх салбарт улс төрийн оролцоо эрс нэмэгдсэн. Үүнийг сонгуулийн эрхийн өргөжилт зэрэг хүчин зүйлс тухайлбал

эмэгтэйчүүдийн сонгуульд оролцох эрхийг хуульчилсан гэх мэтийн үйл явдлуудтай холбож тайлбарлаж болно. Дэлхийн хоёр их дайны улмаас төсөв нэмэгдэхийн хэрээр олон сонирхлын бүлгүүд улсаас улам бүр их тусгай эрх дарх олж авах шахалтаа нэмэгдүүлж, улс төрчид сонгуулийн саналын төлөө энэ бүхнийг боломжтой болгосоор ирсэн.

Өнөөдөр ч эдгээр хүчин зүйлс үйлчилсээр байна. Улс төрчдийн сонгуулийн саналын төлөөх уралдаан, олонхын саналын рационал легитим шинж гэсэн ойлголт нь “либерал”, “консерватив” эсхүл “чөлөөт зах зээлийн” гэх мэтийн намуудтай хавсарч хамтын шийдвэр гаргах үйл явцыг эдийн засаг, нийгэм, хувь хүний амьдралын олон салбарт улам бүр өргөжин нэвтрэхэд хүргэдэг. Улс төрчид сонгуульд ялахын тулд санхүүгийн зөв менежмент хэрэгжүүлэхээс илүүтэй өр зээлээр санхүүждэг, данхар, сүржин, өндөр өртөгтэй, үрэлгэн төрийн төслүүдийг сурталчилж, үүнд гол анхаарлаа хандуулдаг. Америкийн зохиолч Гор Видал Армагеддон (1987) номондоо “Манай ардчиллын тогтолцоо бол авлигын хамгийн дээд хэлбэр” гэжээ. Ингээд олонхын өөрсдийнх нь огт хүсээгүй данхар төр бүрэлдэн бий болдог.

ДАЛД ӨРТӨГТЭЙ

Ардчилсан тогтолцооны ач тусыг магтаж дээдлэх нь элбэг боловч түүний нийгэм, эдийн засаг болон ёс суртахууны өртөг зардлыг ихэвчлэн авч хэлэлцдэггүй. Ардчилал нь нийгмийн эв нэгдлийг дэмжих бус харин ч улс төрийн намууд олон түмний дэмжлэгийн төлөө дээрмийн бүлгүүд шиг хоорондоо тэмцэлдэж, улс төрчид нь урт хугацааны тогтвортой байдлаас илүү дараагийн сонгуульд гол ач холбогдол өгдөг. Мөн лобби бүлгүүд бусдын зардлаар тусгай эрх дарх, давуу байдал хүртэхийн төлөө тогтолцоог маш зальжин ашиглах зэргээр ардчилал нь олиггүй зан авирыг өөхшүүлдэг гэж ардчиллыг шүүмжилдэг.

Тэдний хэлж буй ёсоор өнгөрсөн зуунд ардчилал нь бидэнд данхар, өндөр өртөгтэй, төвлөрсөн эрх мэдэлтэй төрийн тогтолцоо бүтээж өгсөн нь огт гайхах зүйл биш аж. Улс төрчид, бизнесүүд болон бусад сонирхлын бүлгүүд төрийн хэвшлийг өргөжүүлж ингэснээрээ илүү их эрх мэдэл, тусгай эрх дарх хүртэхийн төлөө явдаг. Олон янзын бүлгүүд өөрсдөдөө илүү их дэмжлэг хүртээхийг санал болгож, зардлыг бусдад тэр тусмаа үүнийг эсэргүүцэх чадваргүй хойч үедээ шилжүүлснээр татвар, өрийн хэмжээ улам бүр нэмэгдэхэд хүрдэг.

“Ардчилал нь өндөр өртөгтэй сонгууль үе үе явагдаж, нэр дэвшигчид нь солигддог ч гэсэн асуудлыг шийдвэрлэж чаддаггүй тогтолцоо.”

— Гор Видал (1991) Цайны газарт төрсөн бодол

Энэ бүхнийг хянан саармагжуулах эсхүл тэднийг хяналтандаа байлгадаг улс төрийн элит давхаргыг зайлуулах нь тун амаргүй. Хамгийн олон санал авсан нь сонгуульд ялдаг тогтолцоонд шинэ, жижиг улс төрийн хүчнүүдэд сонгогдох боломж хомс. Тиймдээ ч одоогийн авлигажсан тогтолцоонд ямар ч хяналт, сорилт гэж алга. Энэ нь эдийн засагчдын хэлдэг улс төрийн босго өндөр, хязгаарлалт ихтэй байгаагийн илрэл. Гэхдээ популист хөдөлгөөнүүдийн хүчирхэгжилт нь нөхцөл байдал өөрчлөгдөж байгааг харуулж байна.

VIII

АРДЧИЛЛЫН ХЭТИЙДСЭН МАГТААЛ

Ардчилал нь энх тайван, хөгжил цэцэглэлт, шударга ёс, эрх чөлөөнд хөтөлдөг гэх бараг л үлгэр домгийн статустай болжээ. Ийм ч учраас ихэнхи улс төрийн лидерүүд өөрсдийн автократ дэглэмийг ардчилсан гэж ойлгуулахаар эрмэлздэг. Иймээс либерал ардчилалд амьдардаг хүмүүс ардчиллын давуу талыг хэт өндөрт өргөх нь элбэг. Эдгээр хэтрүүлгийг няцааж, бодит байдалтай хэр зэрэг нийцэж байгааг нягтлах шаардлагатай.

ХАМГИЙН ШИЛДЭГ ТОГТОЛЦОО

Ардчиллыг ихэвчлэн хамгийн сайн улс төрийн тогтолцоо үгүйдээ л хамгийн шилдэг тогтолцоо гэж ярих нь элбэг. Харамсалтай нь үүнийг батлахын тулд бид бусад бүх боломжит тогтолцоог туршиж үзэх шаардлагатай. Тэгээд ч улс төрийн тогтолцоог чухам ямар шалгуураар дүгнэх вэ? Тухайлбал ардчиллыг олон нийтийн оролцоог сайн хангадаг боловч хямралын үед шийдэмгий бус, хөшүүн гэж үзэж болно. Мөн авлигад өртөмтгий ч хүний сайн сайхан, хөгжил цэцэглэлт, эрх чөлөөг дэмжих тал дээр бусдаас илүү мэт санагдана. Үнэндээ, Америкийн эдийн засагчид Роберт Лоусон, Райан Мерфи, Бенжамин Пауэлл нарын (2020) судалгаагаар ардчилал нь эдийн засгийн эрх чөлөөтэй салшгүй холбоотой байдаг байна. Гэвч ерөнхийдөө “хамгийн сайн” тогтолцоо гэж дүгнэх эсэх нь хувь хүний үзэмжийн асуудал.

“Хэн ч ардчиллыг төгс эсвэл бүрэн рационал гэж хэлээгүй. Үнэндээ, ардчилал бол бусад бүх туршиж үзсэн засаглалын хэлбэрүүдийг эс тооцвол хамгийн муу төрийн хэлбэр гэж хэлэгддэг.”

— Сэр Винстон Черчилль (1947), Хансард, 11-р сарын 11

АРД ТҮМНИЙ ЗАСАГ

Ардчиллыг ихэвчлэн ‘ард түмний засаг’ гэж ойлгодог. Ингэх нь үнэнд нийцэхгүй. Орчин үеийн ардчилалд ард түмэн засагладаггүй, харин тэд өөрсдийн удирдагчдаа сонгодог. Ард түмэн хууль тогтоодоггүй, харин төлөөлөгчид нь л хууль баталдаг.

Цаашилбал, ‘ард түмэн’ гэдэг нь тодорхой нэг шийдвэрийг гаргагч бодгаль бус харин нийтийн хэрэг явдалд олон янзын, заримдаа өөр хоорондоо зөрчилддөг үзэл бодолтой сая сая хувь хүмүүсээс бүрддэг. Тэд нийтийн бодлогын зорилго, түүнд хүрэх арга замын талаар санал нэгтэй байх боломжгүй. Тэд ‘удирдах’ тухайд нэгдмэл шийдэлд хүрч чаддаггүй, ингэх ч боломжгүй. Ардчилал нь хамгийн зүй зохистой, хүмүүсийн зөвшилцлийг урт хугацаанд хадгалах шийдвэрүүдийг гаргадаггүй. Харин хамгийн олон санал цуглуулж чадсан бүлгийн үзэл бодол л давамгайлдаг. Ардчиллыг шүүмжлэгчид уг үйл явцыг ‘ард түмний засаг’ бус харин дээрмийн бүлгүүдийн хоорондын дайнтай адилтгадаг.

ЗӨВШИЛЦӨЛД ТУЛГУУРЛАСАН ЗАСАГ

Ардчиллыг ‘зөвшилцлийн засаг’ ч гэж ойлгодог. Хэдий ийм юм шиг харагддаг боловч ардчиллын бодит байдал нь хууль тогтоох шийдвэрүүдийг улс төрийн элитүүд гаргадаг гэж ардчиллыг шүүмжлэгсэд үздэг. Олон нийтийн “зөвшилцөл” гэдэг бол зөвхөн сонгуульд оролцохыг зөвшөөрсөн хувь хүмүүсийн хязгаарлагдмал зөвшилцөл бөгөөд сонгууль хооронд нь хэдэн жилийн зай бий.

Цаашилбал таны өмнөөс өөр хүмүүс шийдвэр гаргаж байгаа тохиолдолд үүнийг ‘зөвшилцөл’ гэж хэлэх боломжгүй. Гэтэл ардчилал нь ийм шинжтэй. Бодлогын шийдвэрийг олонх гаргаж бусад нь үүнийг хүлээн зөвшөөрөх үгүй бол торгууль, баривчилгаа зэрэг шийтгэл хүлээхэд хүрнэ. Та тэдний эсрэг санал өгсөн байлаа ч олонх л таны амьдралыг хянаж, автократуудын адилаар хэтэвчийг тань хоосолдог.

‘Зөвшилцөл’-д тулгуурласан гэх сонгогчдын шийдвэр ч ухаалаг, мэдээлэл судалгаанд үндэслэсэн байдаггүй. Сонгогчид нарийвчилсан асуудлуудыг мэддэггүй төдийгүй ирээдүйн үр дагаварыг нь урьдчилан таамаглаж ч чаддаггүй. Тиймээс тэд нэр дэвшигчид хэрхэн ажиллахыг, тэдний бодлогын (сайн эсвэл муу) үр дагаврыг урьдчилж хардаггүй. Сонгогчид хэзээ ч ухаалаг шийдвэр гаргадаггүй гэж ардчиллыг

шүүмжилдэг.

Брайан Капланы (2007) шүүмж бүр ч хурц. Тэрээр сонгогчдыг хангалттай ухаалаг байж чаддаггүйгээс гадна зориудын атгаг сэтгэлдээ хөтлөгддөг болохыг анзаарсан. Тэд нөхцөл байдал сайжирч байхад эсрэгээр нь дордлоо гэж тайлбарладаг, үнэ цэнэ бий болгохоос илүү ажлын байр бий болгохыг чухал гэж үздэг, гадаадын иргэдийн эсрэг ялгаварлах хандлагатай, дотоодын үйлдвэрээ өрсөлдөөнөөс хамгаалахыг дэмждэгээс гадна үйл явдлын өрнөлүүдэд ойр ойрхон савладаг аж. Жишээ нь тэд улсынхаа Олимпийн медалийн амжилтад хэт хөөрцөглөдөг байна. Эдгээр хандлага нь бодлогын шийдвэрүүдийг системчлэгдсэн байдлаар иррациональ, гажуудсан, хор хөнөөлтэй болгоход хүргэдэг.

ТЭГШ ОРОЛЦОО

Ардчиллыг нийтийн бодлогын асуудлаар ‘хүн бүрийн тэгш оролцоо’-г хангадаг гэх нь бий. Гэхдээ хүн бүр сонгуульд санал өгөх эрхгүй. Ардчиллын түүхийн дийлэнхи хугацаанд хамгийн либерал гэж тооцогддог улсуудад ч эмэгтэйчүүд, үндэстний цөөнх болон өмчгүй хүмүүст сонгох, сонгогдох эрх байсангүй. Түүнчлэн сонгуульд хүн амын тэн хагасаас илүү хувь хүртэлхи хүмүүс сонгуульд оролцохгүй байхаар шийдсэн байх нь ч элбэг. Саналаа өгсөн байлаа ч гэсэн том улсуудын хувьд таны санал сонгуулийн үр дүнд нөлөөлөх нь магадгүй арван сая эсхүл зуун саяын эсрэг нэгийн харьцаатай байдаг.

Ардчилал нь энгийн хүмүүс өөрсдийнхөө юу хүсэж байгаагаа сайн ойлгож үр дагаварыг нь сайн муугийн аль алинаар нь хүртэх ёстой гэх онол.

— Х.Л. Менкен (1915), Тэмдэглэлийн хуудсууд

Хүмүүсийн санал тэгш тооцогддоггүй. ‘Баталгаатай’ буюу аль нэг нам нь дангаар байнга ялдаг сонгуулийн тойрогт амьдардаг хүмүүсийн санал нь “шийдвэрлэх” буюу өрсөлдөөн хамгийн ширүүн өрнөдөг тойргийнхны саналаас илүү бага нөлөөтэй. Түүнчлэн хүн ам зүйн асуудлын практик шалтгааны улмаас зарим сонгуулийн тойрог бусдаасаа хавьгүй олон сонгогчтой байдаг. Тиймээс хэрэв нэг тойрог

нэг л төлөөлөгч сонгодог бол жижиг тойрогт амьдардаг хүмүүсийн санал илүү их жинг дарна.

Мөн төлөөллийн хувь хэмжээг улс төрийн зорилгоор манипуляцлах боломжтой. Тухайлбал, Зөвлөлт Холбоот Улс байгуулагдсаны дараахан нь хотын оршин суугчдад хөдөөгийн хуучинсаг үзлийг даван туулахын тулд тав дахин их төлөөллийн эрх мэдлийг өгч байсан түүх бий. Америкийн улс төрчид ч урт хугацаанд тойргуудаа ‘баталгаатай’ хэвээр хадгалахын тулд хачирхалтай хэлбэртэй сонгуулийн тойргийн тогтолцоо зохион байгуулсаар ирсэн түүхтэй. (1812 онд Массачусетсийн амбан захирагч Элбридж Герригийн үед ийм тойргуудын нэгний газрын зураг саламандр мэт харагдаж байсан тул ‘gerrymander’ гэдэг нэр томьёо бий болж байлаа.)

ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАДАГ

Ардчилсан тогтолцоог ихэвчлэн хувь хүний улс төрийн (эсхүл ‘иргэний’) тэгш байдал, нэр төрийг баталгаажуулдаг гэж магтдаг. Гэвч бусад тогтолцоонд ч тэр улс төрийн тэгш байдлыг хангах боломжтой. Мөн бид бусдын нэр төрийг хүндэтгэж болох ч тэдэнд сонгуульд санал өгөх эрх заавал өгөхгүй байж болно.

Мөн ардчиллын оролцоо нь хүмүүсийн өөртөө итгэх итгэл, өөрийгөө илэрхийлэх чадамжийг нь хөгжүүлэн дэмждэг ч гэлцэх нь бий. Гэвч зөвхөн дээрхи зорилгын үүднээс сонгуулийн тогтолцоог зохион байгуулна гэдэг нь утга учиргүй. Тухайлбал социопат хэв шинжтэй аюултай хоригдлуудын өөртөө итгэх итгэлийг нь нэмэгдүүлэхийн тулд тэдэнд санал өгөх эрх олгохыг бид хүсэхгүй л байх. Хүмүүсийн өөртөө итгэх итгэл, өөрийгөө илэрхийлэх чадамжийг нь урамшуулан дэмжих сонгуулиас өөр илүү сайн арга замууд олон байгаа гэдэг нь баараггүй.

Ардчилал нь шударга ёс, тэгш байдлыг хангаж, жижиг бүлгүүдийн улс төрийн болон нийгмийн ноёрхлыг бий болгохоос сэргийлдэг гэх ойлголт түгээмэл. Гэвч чинээлэг бүлгүүд хэт нөлөөтэй хэвээр байдаг гэдэгт итгэх бүрэн үндэс бий. Сайд дарга нар болон төрийн өндөр албан тушаалтнууд дундаж хүмүүсээс илүү баян чинээлэг байдаг бөгөөд өндөр төлбөртэй хувийн

дунд болон их дээд сургуулийн төгсөгчид л эдгээр албан үүргийг гүйцэтгэдэг. Түүнчлэн дундаж ангийнхан тэтгэвэр, сургууль, эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг төрийн үйлчилгээнээс ядуусаас илүү ашиг тусыг хүртдэг бололтой. Мөн л тэд улс төрийн хэлэлцүүлгийн үйл явцыг тэргүүлдэг тул өөрсдөд нь ашигтай улс төрийн шийдвэрүүдийг гаргуулж чаддаг. Маш олон оронд төр хэт томорсон гол шалтгаануудын нэг нь тэдний нөлөө ч байж болох талтай. Хэрэв төрийн цорын ганц зорилго нь харьцангуй цөөн тооны төрөөс хамааралтай хүмүүст мөнгө санхүү, үйлчилгээ хүртээх байсан бол ийм хэмжээнд тултлаа данхайх шаардлага ч байсангүй.

ХАМТ ОЛНЫ УУР АМЬСГАЛЫГ БҮРДҮҮЛДЭГ

Өөр нэг аргумент нь ардчилал нь хамт олны уур амьсгалыг бүрдүүлж хүмүүсийн дунд ойр дотно мэдрэмжийг төрүүлж 'эв нэгдэл'-ийг бий болгодог гэх санаа. Гэвч хүмүүсийн тодорхой нэг хамт олны дунд харьяалагдах хүсэл эрмэлзлийг тэдний клуб, буяны байгууллага, сүм хийд, харилцан дэмжлэг үзүүлэх бүлгэм зэрэг иргэний нийгмийн бусад институцуудад оролцох оролцоо л илүү сайн хангаж чаддаг гэж хэлэх нь илүү зохистой. Мөн сонгуулиар бүрдсэн төлөөллийн засаг төр нь хамтын шийдвэрүүдийг тайван замаар гаргахад тусалдаг ч ингэх нь эв нэгдлийг бий болгодог гэдэгт бүрэн санал нийлэх аргагүй. Сонгууль болон хууль тогтоох хэлэлцүүлгүүд нь өөр хоорондоо зөрчилтэй, тэр ч бүү хэл сөргөлдөгч сонирхлын бүлгүүдийн хоорондын тулаан байдаг. Энэ тэмцэл цаашлаад маш хурцадмал байдалд ч хүргэх боломжтой. Учир нь ялагчид нь бусдадаа өөрсдийн бодлоо тулгах эрх мэдэлтэй болдог.

Эдийн засаг, зах зээлийн харилцаанд хүмүүс бусдын төлөө биш өөрсдөдөө зориулж бараа, үйлчилгээг сонгодог. Хүмүүс Apple эсхүл Android, цай юу кофе юу, улаан уу цэнхэр үү гэх мэтчилэнгээр өөр өөрийн сонголтыг чөлөөтэй үйлддэг бөгөөд дээрхи сонголтууд

нь бусдад ямар ч нөлөө үзүүлэхгүй. Харин улс төрийн сонголтууд нь хүн бүрт нөлөөлдөг. Олонх сонгогч тодорхой нэг нэр дэвшигчдийн төлөө санал өгвөл хүн бүр энэ үр дүнг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байдалд ордог. Хэрэв эрх баригч нам шинэ зам эсвэл нисэх буудал барих гэх мэтийн тодорхой бодлого хэрэгжүүлэх шийдвэр гаргавал хүн бүр тэр тусмаа үүнээс болж орон гэр, амь амьжиргаанаасаа хагацах гэж буй хүмүүс хүртэл шийдвэрийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй.

Улс төрийн шийдвэрүүдийн заавал биелэгдэх шинж болон олонхын шийдвэр нь маш олон зүйлд өргөн хүрээтэй нөлөө үзүүлдэг учраас бусдын хийсэн сонголтууд таны амьдралд ч гүнзгий нөлөө үзүүлдэг. Америкийн философич Жейсон Бреннаны (2016) 'Ардчиллын эсрэг' номонд улс төр хөршүүдийг чинь таны найз нөхөр бус харин болзошгүй дайсан чинь болгодог аж. Энэ бол 'хамт олны уур амьсгал'-ын чанх эсрэг нь билээ.

АРДЧИЛАЛ БИДНИЙГ МУУ УДИРДАГЧДААС ХАМГААЛДАГ

Хүн төрөлхтний түүхийн дийлэнхи хугацаанд хүмүүс бид цэргийн эрхтэнгүүд, язгуур сурвалжтангууд, цезариуд, хаад, овгийн ахлагчид болон диктаторууд зэрэг автократ захирагчдын захиргаанд байсаар ирсэн түүхтэй. Ихэнхи тохиолдолд эдгээр захирагчид бидний үхэл, амьдралыг шийдэх эрх мэдэлтэй байлаа. Мэдээж ардчилал нь удирдагчдын эрх мэдлээ төвлөрүүлж, харгис хэрцгий, дур зоргоороо аяглахад нь саад тотгор болдог нь гарцаагүй. Гэхдээ л эрх баригчид болон албан тушаалтнууд нь өөрсдийн хувийн сонирхолтой гэдэгт эргэлзэх хэрэггүй. Тэд албан тушаал, цалингаа нэмэгдүүлэх, олон нийтийн мөнгө санхүүг өөрсдийн дэмжигсэд рүү чиглүүлэхийг хүсдэг нь ойлгомжтой. Ардчиллын үйл явц нь тэдэнд хэдий бусдын ашиг сонирхолд хохиролтой байсан ч өөрсдийн ашиг сонирхлыг хангах эрх мэдэл, хууль ёсны мэт харагдуулах боломжийг олгодог. Ардчилал нь биднийг муу удирдагчдаас хамгаалахын оронд харин ч тэдний захиргаанд оруулах боломжтой.

Мөн бид ардчилал нь үргэлж шударга ёсыг хангаж чаддаг гэдэгт найдах аргагүй. Хэдий ардчилал нь биднийг харгис эрх мэдэлтнүүдийн дур зоргоос хамгаалж болох

ч бүх л монополийн адилаар ардчиллын үйл явц нь өндөр өртөгтэй мөн хөшүүн, үр дүн муутай байх боломжтой. Түүнчлэн нэгэнт л төр шударга ёсыг тогтоодог учраас үүнийг төрийн эрх мэдлийг зайдалсан хүмүүсийн сонирхолд нийцүүлж гажуудуулах нь ч бий. Эцсийн эцэст бидний амьдрал, өмч, үг хэлэх эрх чөлөө болон бусад үндсэн эрхүүдийг хамгаалах хамгийн баталгаат хамгаалалт нь ардчилсан төр, шүүх байгууллага бус харин сонгодог либерализмын үнэт зүйлсийг нийтээр хүлээн зөвшөөрөх явдал байж болох талтай. Хэрэв бидний эрх, эрх чөлөө сайтар хамгаалагдаж, ардчиллын ач тусыг бид хүртэхийг үнэхээр хүсэж байгаа бол либералууд болон ардчилагчид нь олон нийтэд либерализмын зарчмыг ойлгуулж сурталчлах ажлыг зайлшгүй хийх ёстой. Энэ бүхнээс гадна бид ардчиллын шийдвэр гаргах үйл явцын алдаа дутагдалтай талуудыг ойлгож, сонор сэрэмжтэй байх шаардлагатай.

IX

АРДЧИЛСАН ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ

XIX зууны Германы канцлер Отто фон Бисмарк нэг удаа хууль болон хиаманд дурлагчид тэдгээрийг хэрхэн бүтээгддэгийг хэзээ ч харах ёсгүй гэж хэлсэн гэдэг. Ардчилалд шийдвэр гаргах үйл явцын талаар сэтгэл түгшээх шалтгаанууд үнэхээр ч олон бий. Ардчилал нь олон хүний үзэл бодлыг нэгтгэж, нийтлэг хамтын шийдвэр болгон хувиргах ёстой. Гэвч уг үйл явц хаана, хэрхэн хийгддэг мөн яагаад төгс бус байж болохыг бид анхааралдаа авах шаардлагатай.

СОНГУУЛЬ

Сонгууль нь сонгогчдын нэр дэвшигчид болон бодлого хооронд сонголт хийх арга зам хэдий ч маш хязгаарлагдмал шинжтэй. Нэгдүгээрт, сонгууль нь тодорхой хэдэн жил тутам зохион байгуулагддаг. Заримдаа дөрөв, тав эсхүл үүнээс ч урт хугацаанд нэг л удаа явагдана. (Харин зах зээлийн орчинд бид дуртай бараа, үйлчилгээгээ өдөр, цаг, мөч тутам сонгох боломжтой) Сонгуулийн үеэр сонгогчдод олгодог сонголтын хэмжээ хязгаартай. Маш олон янзын ярвигтай нийтийн бодлогын асуудлуудыг хоёр гурван нэр дэвшигчийн танилцуулсан багц хэлбэрээр л сонгогчид сонгодог. (Зах зээлийн орчинд бид хэдхэн багцалсан бүтээгдэхүүнийг бус өргөн хүрээнд сонголтоо хийх боломжтойг дахин дурдмаар байна) Ингээд олонхын шийдвэрийг бүгдэд тулгадаг.

Мөн хайч, чулуу, даавууны парадокс гэх ойлголт бий. Сонгогчид эхний нэр дэвшигчийг удаах нэр дэвшигчээс (даавууг чулуунаас), удаах нэр дэвшигчийг гурав дахь нэр дэвшигчээс илүүд үзэж болох ч гурав дахь нэр дэвшигчийг (чулууг хайчаас) эхнийхээс илүүд үзэх магадлалтай. Үүнээс болж саналын хуудсын жагсаалтын дараалал сонгуулийн үр дүнд маш их нөлөө үзүүлдэг. Франц гэх мэтийн улсуудад анхны санал хураалтаас шалгарсан

нэр дэвшигчид сүүлийн шатны хоёр сонголттой уралдаанд оролцдог бөгөөд эхний шатанд тэргүүлсэн нэр дэвшигчид дараагийн шатанд ялагдах нь элбэг тун түгээмэл.

СОНГУУЛЬ

Сонгогчид ч олон янзын сэдэл зорилготой байдаг. Тэд юу ч болсон бай нэг намыг насан туршдаа дэмждэг байж болно. Мөн зөвхөн эрх баригч намыг унагаахыг хүсдэг. Эсхүл ойролцоох эмнэлэг хаагдах зэрэг орон нутгийн болон хувийн шинжтэй асуудлуудаасаа шалтгаалан сонголтоо хийдэг. Тэд өөрсдийн үнэхээр хүссэн сонголтыг бус харин тактикийн зорилгоор дургүй нэр дэвшигчдээ хүртэл санал өгөх байдлаар бүр ч илүү таагүй ханддаг нэр дэвшигчээ ялагдуулах гэж оролддог. Тэр байтугай болж байгаа бүхний тухай будилж төөрөгдөөд байгаагаа мэдсэн хэдий ч саналаа өгөх үүрэгтэй гэж үздэг сонгогчид ч бий. (Сонгогчдын олонх нь саналын хайрцагны дэргэд зогсож байхдаа л шийдвэрээ гаргадаг нь туйлын хачирхалтай)

Сонгууль бол ухаалаг, мэдээлэлтэй, хараат бус сонгогчид өдөр тутмын асуудлуудыг нухацтай тунгаан, улс орны урт хугацааны сайн сайхны төлөө хамгийн зөв гэж үзсэн бодлогуудад санал өгөхөд тохиромжтой, рациональ үйл явц огт биш.

НЭР ДЭВШИГЧИД

Нийтийн төлөө сэтгэл зүрхээ зориулах хүсэлтэй улс төрч хүртэл тодорхой албан тушаалд томилогдож, зорилгодоо хүрэхийн тулд олон түмний саналыг авах шаардлагатай. Иймээс уг ‘саналын сэдэл’ нь тэдний гол хөдөлгөгч хүч болдог бөгөөд энэ нь шийдвэр гаргах үйл явцыг гажуудуулдаг.

Тухайлбал, улстөрчид ихэвчлэн ‘дундаж’ сонгогчдод анхаарлаа хандуулдаг. Эцсийн эцэст улс төрийн хэт туйлшралаас ихэнхи сонгогчид ангид байдаг бөгөөд тэд хэт туйлшрахаас илүүтэй өөрсдийн үзэл бодлоо тодорхой хэмжээнд өөрчлөхөд бэлэн байдаг. Гэвч нэр дэвшигчид болон нам бүхэн төвийн байр суурь баримтлаад эхэлбэл сонгогчдод бодит сонголт үгүй болдог. Илүү тууштай, хүчтэй итгэл үнэмшилтэй хүмүүсийн сонголт ийнхүү хаягдахад хүрдэг.

Улстөрчид мөн лобби бүлгүүдэд онцгой анхаарал хандуулдаг. Эдгээр бүлгүүд нь хүчтэй сэдэл, зохион байгуулалтаараа дамжуулан тэр тусмаа бусад сонирхлын бүлгүүдтэй нэгдэх үедээ олон саналыг зулгаах чадамжтай байдаг. Эцсийн эцэст ‘чимээгүй олонх’ л энэ бүхний өртгийг төлдөг бөгөөд харамсалтай нь тэдний дуу хоолойг хэн ч төлөөлдөггүй.

ХУУЛЬ ТОГТООГЧИД

Энэ бүхнээс харахад уг процессын дагуу сонгогдсон төлөөлөгчдийг нийтийн ашиг сонирхлын төлөөх хараат бус хамгаалагчид гэж үзэх боломжгүй. Тэднийг өөрсдийг нь дэмжсэн сонирхлын бүлгүүд болон намынхаа шошгыг ашиглуулсан улс төрийн намын удирдлагуудад амласан амлалтаа биелүүлэхээс өөр аргагүй.

Тэдний тодорхой бодлогыг хууль тогтоох байгууллагаар батлуулах үйл явц ч тодорхой зарчмуудад тулгуурладаггүй. Уг үйл явц нь ‘хэрэв миний бодлогыг дэмжвэл би чинийхийг дэмжинэ’ гэсэн харилцан тохиролцоо буюу хуйвалдаанд тулгуурладаг. Жишээлбэл тодорхой нэг төлөөлөгч өөр төлөөлөгчийн тойрогт шинэ сургууль, эмнэлэг барих саналыг үнэ цэнэтэй гэж үзсэндээ биш харин хариу харах байдлаар дэмжих нь олонтаа.

Мөн адил томоохон хууль тогтоох санаачилгууд нь шаардлагатай дэмжлэгийг авахын тулд багц хэлбэрээр боловсруулагддаг. Үүний жишээ гэвэл 1950-аад оны эхээр АНУ-ын Ерөнхийлөгч Дуайт Д.Эйзенхауэр муж улс хоорондын хурдны замын төлөвлөгөөг дийлэнхи муж улсуудад ашиг тустай байх төлөвлөгөөг боловсруулсан. Өөрсдийн мужууддаа илүү сайн зам бариулахын төлөө санал өгөх төлөөлөгчид болон сенатын гишүүд уг төслийг хэрэгжүүлэх

нь зөв буруу эсэхээс үл хамааран төслийг бүхэлд нь дэмжсэн. 2008 онд АНУ-ын санхүүгийн хүндрэлд орсон банкуудыг аврах зорилгоор санаачилсан онц байдлын ‘TARP’ хуулийн төслийг конгресст анх танилцуулахад энэ нь ердөө хоёр хуудастай байв. Гэвч энэ хууль заавал батлагдах ёстой гэдгийг хүн бүр мэдэж байсан тул төлөөлөгчид өөрсдийн дэмжлэгийнхээ хариуд төрөл бүрийн тусламжыг шаардсан. Эцэстээ уг хуулийн төсөл 451 хуудас болж, бөс даавуу үйлдвэрлэгчид, спиртийн үйлдвэрүүд, загас агнуурын флот, мотоспортын цогцолбор, тэр ч бүү хэл модон сумны үйлдвэрлэгчдэд татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг асуудлыг хамарсан байна.

“Мэргэжлийн улстөрчид болон ашиг сонирхолдоо хөтлөгдсөн хүнд сурталтнууд лоббичид болон шахалтын бүлгүүдийн урамшуулалд хариу үйлдэл үзүүлж, засгийн газрын үйл ажиллагааны цар хүрээг тасралтгүй өргөжүүлсээр байна. Амьд явсан ой санамжийн маань аль нэг цаг үед нь хэрэгцээгүй хууль тогтоомжуудыг олноор нь цуцалсан үйл явдлыг та санаж байна уу?”

— Крэйг Смит, Том Майрс (2011),
Өрнөдийн доройтол ба ардчилал

АЛБАН ХААГЧИД

Эдгээр хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэгтэй албан хаагчид ч гэсэн нийтийн сайн сайхны төлөө өөрсдийгөө золиослох сахиусан тэнгэрүүд биш гэдэг нь ойлгомжтой. Тэд олон нийтийн төлөөх ажил албаараа бахархдаг байж болох талтай ч хувийн сонирхолтой гэдэг нь хөдөлшгүй үнэн. Жишээ нь тэд өөрсдийн агентлагийнхаа үйл ажиллагааг өргөжүүлж чадах аваас төсөв хангамж, цалин хөлс, байр суурь, ажлын байрных нь тогтвортой байдал, албан тушаал ахих боломжууд нь бүгд сайжрах нь бий.

Мөн тэдэнд өөрсдийн ашиг сонирхлыг өөр бусад аргачлалуудаар ч хангах боломж байдаг Жишээлбэл, хууль нь хэрэгжихдээ өргөн хүрээтэй нөлөө үзүүлдэг учраас тухайн хуулийг хэрэгжүүлэгч албан хаагчдад л чухам ямар дүрэм журмын хүрээнд тодорхой үйл ажиллагааг зохицуулах, тухайн дүрэм журмыг хэрхэн тайлбарлаж, хэрэгжүүлэх ёстойг шийдэх эрх мэдэл олгогддог. Өөрсдийн Засгийн газрын салбарын мэргэжилтнүүд (магадгүй хууль тогтоож буй улс төрчдөөс ч илүү) болохын хувьд албан хаагчид хуулийг хэрэгжүүлэх үйл явцыг илүү хүндрэлтэй болгож чаддаг бөгөөд ингэснээрээ илүү олон албан хаагчдын хэрэгцээ шаардлагыг бий болгодог.

Тэд мөн хуулийг хэрхэн хэрэгжүүлэх тухайд өөрсдөдөө ихээхэн хэмжээний эрх мэдлийг олгодог. Ингэснээрээ тэд өөрсдийгөө өндөр статустай болгож чаддаг бөгөөд бизнес эрхлэгчид болон олон нийт тэдний хууль журмыг хэрхэн хэрэгжүүлэх тайлбараас эсхүл гэрээ, хэлцэл, тэтгэмж, лицензийг хэнд олгохыг шийдэх эрх мэдлээс нь хамааралтай болдог. Заримдаа тэд шийдвэр гаргасныхаа төлөө хахууль, хөнгөлөлтүүдийг ч хүртэх нь бий.

УЛС ТӨРӨӨС ХАМААРАЛТАЙ ХҮМҮҮС

Хэвлэл мэдээлэл, лобби бүлэг, тинк танк, ТББ-ууд гэх мэтийн Засгийн Газрын зарлагаас хамааралтай хүмүүс бүгд хамтын шийдвэр гаргах үйл явцын хүрээг өргөжүүлж, хадгалах сонирхолтой байдаг.

Хэвлэл мэдээллийн байгууллагууд гэхэд л 24 цагийн туршид юу болсон тухай мэдээллээ тасралтгүй хүмүүст хүргэж байх шаардлагатай. Тэдний аз болоход улстөрчид өөрсдийн үзэл бодлоо илэрхийлж, хэрэгжүүлж буй бодлогуудаа ‘зөв талаас’ нь тайлбарлах байнгын сонирхолтой. Хэвлэл мэдээллийн байгууллагууд нь ‘ноцтой мэдээ’ мэдээллээр хүмүүсийн анхаарал сонирхлыг татах эрмэлзэлтэй байдаг учраас улстөрчид албан ёсны мэдэгдэл хийхээс нь өмнө хэрэгжүүлэх гэж буй бодлогуудыг нь ‘илчилж’, өрсөлдөгчид нь ч юу болж байгааг олж мэдэхээс нь өмнө олон нийтэд тухайн үйл явдлыг өөрсдийнхөө өнцгөөс хүргэхийг хичээдэг.

Тинк танкууд болон кампанит ажлын бүлгүүд нь өөрсдийгөө хараат бус судлаачид гэж танилцуулж болох хэдий ч улс төрийн хэлэлцүүлэгт өөрсдийн сонирхлыг мөн адил тусгадаг. Тодорхой голлох асуудлуудад онцгой анхаарал хандуулдаг кампанит ажлын бүлгүүд нь ихэвчлэн түүнийхээ төлөө илүү их нийтийн

мөнгө санхүү зарцуулах эсхүл татварын хөнгөлөлтийг шаарддаг бөгөөд ингэх явцдаа татвар төлөгчдөд өртөг нь хэр зэрэг тусах тухай асуудлыг авч хэлэлцдэггүй.

Эцэст нь амьдрал нь төрөөс хамааралтай хүмүүсийг нэмж дурдах нь зүйтэй. Төрийн албан хаагчид нь томоохон сонирхлын бүлэг бөгөөд цомхон төр, бюрократ бүтцийг үгүй хийх гэсэн бодлоготой улс төрийн намуудыг сонгох магадлал бага. Үүнээс гадна тэтгэвэрийнхэн болон нийгмийн халамж хүртэгчид, төрийн байгууллагуудын гэрээт нийлүүлэгчид гэх мэт сая сая хүмүүс бий. Зарим хөгжингүй улсуудын хүн амын талаас илүү хувийнх нь амьжиргаа нь тэр чигтээ эсхүл хэсэгчилсэн байдлаар төрөөс хамааралтай байх жишээтэй. Тэдний сонирхол нь татвар төлөгчдийн мөнгийг хэмнэхэд бус харин ч төрийг томруулахад чиглэдэг.

ДҮГНЭЛТ

Ардчилал нь илүү дарангуй бусад улс төрийн тогтолцооноос олон талаараа давуу талтай боловч үүний ач тусыг дэвэргэж, романтик байдлаар тахин шүтэж болохгүй. ‘Ардчилал’ болон ардчилсан шийдвэр гаргах үйл явцын тухай ярихдаа бид үнэндээ улс төр, улс төрийн шийдвэр гаргах үйл явцын тухай л ярьж байгаа хэрэг. Ихэнхи хүмүүс улс төрийн үйл явц хэзээ ч төгс төгөлдөр байх боломжгүй гэдэгт санал нэгдэх байх.

Тиймээс ардчиллаас ашиг тусыг нь хүртэхийн тулд бид үүний төгс бус үйл ажиллагааг бодитоор харж чаддаг байх ёстой. Бид ардчиллын алдаа дутагдалд сонор сэрэмжтэй байж боломжтой хэмжээнд үүнийг засаж сайжруулахаар хичээх хэрэгтэй. Үүнийг бид амжилттай хэрэгжүүлж чадах эсэхээс л ардчиллын ашиг тусыг хүртэж чадах эсэх маань шийдэгдэнэ.

X

ШАХАЛТАНД ОРСОН АРДЧИЛАЛ

Хүн бүр шахуу ардчиллын идеалыг дээдэлдэг болсон гэгддэг ч үнэндээ хүмүүс түүний бодит хэрэгжилтэнд эргэлзэнгүй хандах болсон. Хүмүүс ардчиллыг дээдэлдэг ч улс төрийг үзэн яддаг. Ардчиллыг хүн бүрийн оролцоог хангаж, нийтийн бодлогын асуудлыг нээлттэй хэлэлцэх улмаар рациональ, энх тайван, зүй зохистой байдлаар шийдвэрт хүрэх зүй зохистой аргачлал гэж үздэг. Харин улс төрийн үйл явдлууд болон улстөрчдийг тэд хоёр нүүртэй, хувийн сонирхолдоо хөтлөгдсөн, бэртэгчид гэж хардаг. Олон нийтийн итгэлийн судалгаанд улстөрчид ихэвчлэн хамгийн доогуурт орж барагтайхан байрыг эзэлдэг.

Үнэндээ бүх бурууг улстөрчдөд тохих аргагүй. Сая сая хүний олон янзын үзэл бодлыг нэгтгэж хүн бүрийн дэмжлэгийг хүлээсэн бодлого болгон хувиргах нь бэрх. Тэр тусмаа өнөөдөр аялал жуулчлал, шилжилт хөдөлгөөн нь хүн амын үзэл санааг илүү олон талт болгосон учраас ингэх боломж хомс. Улс төрчид ч гэсэн өөр хоорондоо эсрэг тэсрэг хүчтэй итгэл үнэмшилтэй байдаг учраас томоохон маргаан дагуулсан асуудлаар ширүүн маргалдсаар байдаг. Иймээс олон нийтийн зүгээс тэднийг зарчимд тулгуурлахаас илүүтэй оноо цуглуулахыг эрмэлздэг гэж ойлгоход хүрдэг. Тодорхой асуудлаар тохиролцоонд хүрэхийн тулд улс

төрчид ихэвчлэн буулт хийх ёстой байдаг нь тэднийг бүр ч зарчимгүй мэт харагдуулдаг.

Эдгээр асуудал нь үнэндээ зөвхөн ардчилалд л байдаг шинж эсхүл ардчиллын нөхцөлд л илүү дордчихсон хэрэг биш. Харин ч эсрэгээрээ ардчилал нь олон нийтийн хэлэлцүүлэгт шударга, ил тод байдлыг бий болгодог. Харьцангуй либераль ардчилсан шинжтэй улсуудын улстөрчид ерөнхийдөө бусад тогтолцоотой харьцуулбал илүү шударга, авлигад бага өртдөг байж болзошгүй. Тухайлбал, Берлинд төвтэй Транспэрэнси Интернэшнл (2019) байгууллагын хамгийн бага авлигажсан гэж тодорхойлсон арван таван орноос арван дөрөв нь Экономист Интеллиженс Юнитын (2019) ‘бүрэн ардчилал’ гэх ангилалд орсон улсууд байв. (Онцгой тохиолдол нь Сингапур байсан бөгөөд энэ нь ‘согогтой ардчилал’-ын ангилалд байсан.)

ХЭТ ЗОНХИЛСОН УЛС ТӨРӨӨС ТАТГАЛЗАХ

Өөрөөр хэлбэл ардчилсан тогтолцоонд улс төрчид харьцангуй гэм хоргүй байдаг боловч тэдний үйлдэл олон нийтийн өмнө ил тод учраас шүүмжлэлд илүү өртдөг. Хамгийн их шүүмжлэлийн бай болдог хүмүүс улс төрчид байдгийн голлох шалтгааныг үүнтэй холбож тайлбарлах боломжтой.

Олон улс орнуудад иргэд нь улс төрчдөдөө сэтгэл ханамжгүй болсон нь сонгуулийн ирц буурах, заримдаа хэт радикал популист хөдөлгөөн, намуудын дэмжлэг нэмэгдэхэд хүргэсэн бөгөөд эдгээр хөдөлгөөнүүд урт хугацаанд хэт зонхилсон улс төрийн намууд болон улс төрчдөд сэтгэл ханамжгүй байгаа байдалд дөрөөлдөг. Популист удирдагчид өөрсдийгөө жинхэнэ ардчилагчид гэж тайлбарлаж, орхигдож хаягдсан олон түмний сонирхлыг хамгаалах тухай ярьдаг. Тэд цагаачлал, нийгмийн халамж зэрэг асуудлын ярвигтай шинжийг хэт хялбаршуулдаг. Мэдээж олон нийт ийм нарийн ширийн асуудлаар цаг заваа зарцуулах боломж нь хомс.

НӨХЦӨЛ БАЙДЛЫН ӨӨРЧЛӨЛТ

Ардчилсан улс төрд итгэх итгэлийг эдийн засгийн хямралт нөхцөл байдал үгүй хийдэг. Ажемоглу, Робинсон хоёрын (2012) тайлбарласан ёсоор зүй зохистой улс улс төрийн болон эдийн засгийн институциудыг цогцлоох нь эдийн засгийн өсөлтөнд сайнаар нөлөөлдөг болохыг өмнө нь дурдсан. Эндээс харвал либерал ардчилал нь ихэвчлэн эдийн засгийн ахиц дэвшилтэй тодорхой хэмжээнд холбогддог. Гэвч Өрнөдийн улсуудын 2007-2008 оны санхүүгийн хямрал болон 2020 оны Ковид-19 цар тахлын үеийн эдийн засгийн хямралууд нь ардчилалд итгэх олон нийтийн итгэлийг сулруулсан.

Нөгөө талаас зарим дэлхийн хэмжээний асуудлууд нь улс орнуудын улс төрийн хяналт, шийдвэрлэх чадамжаас хэтийдсэн байх нь ардчилалд урам хугарч байгаагийн бас нэг шалтгаан гэж хэлж болох талтай. Тухайлбал уур амьсгалын өөрчлөлтийн асуудлын хувьд иргэд нүүрстөрөгчийн ялгаралыг бууруулах бодлогод санал өгсөн хэдий ч бусад улсуудад энэ арга хэмжээг авч хэрэгжүүлэхгүй байх нь асуудлын шийдлийг тэр чигт нь бүтэлгүйтэхэд хүргэж байгаа тухай гомдоллох нь их. Аюулгүй байдал, терроризм, цагаачлалын асуудлууд ч гэсэн олон улсын хамтарсан шийдлийг шаарддаг.

Эдгээр дэлхийн хэмжээний асуудлуудыг

шийдвэрлэх оролдлогыг олон улсын байгууллагууд хийдэг. Тухайлбал, Европын Холбоо нь байгаль орчны бодлогоор тэргүүлж, төв банкууд эдийн засгийн тогтвортой байдлыг хангахыг зорьж, олон улсын шүүхүүд хүний эрхийг хамгаалахаар эрмэлздэг. Гэвч олон улсын байгууллагуудын үйл ажиллагаа маш хязгаарлагдмал. Эдгээр байгууллагуудад сонгогчдын сэтгэл зүрхэнд хүрэхээр хэл, соёлын ижилсэл дутмаг мөн гишүүн улсууд нь тэдний зорилго болон арга барилын тухайд санал нэгтэй байж чаддаггүй. Иймээс иргэдэд олон улсын байгууллагууд нь алслагдсан, хариуцлагагүй байгууллага гэсэн ойлголтыг төрүүлдэг учраас тэд улс үндэстнийхээ язгуур эрх ашгийг тэргүүн эгнээнд тавьдаг. Популист улс төрчид үүнд ч гэсэн дөрөөлөх нь бий.

УЛС ТӨРИЙН ТОГТОЛЦООНЫ ӨӨРЧЛӨЛТ

Ардчилалд тулгарч буй өөр нэг сорилт нь улс төрийн шийдвэр гаргах үйл явцаар шийдэгдэх ярвигтай асуудлууд улам бүр олширч улс төрийг мэргэжлийн улс төрчдийн талбар болгосонд оршино. Иймээс энгийн иргэдэд өөрсдийнх нь оролцоо тун хязгаарлагдмал мэт санагддаг. Ихэнхи хүмүүсийн оролцоо сонгуульд саналаа өгөх төдийхнөөр хязгаарлагддаг бөгөөд цөөн тооны хүмүүс л улс төрийн намууд болон кампанит ажлын бүлгүүдэд нэгддэг. Улс төрийн намуудад гишүүд цуглах нь цөөрсөн учраас намууд гялгар сурталчилгаа, хувь хүний харизма, уриа хэлц, толгой эргүүлсэн үг хэллэг гэх мэтэд илүүтэй түшиглэх болжээ. Ийм ч учраас иргэд тэдэнд улам бүр итгэл алдрах болсон.

Өнөө үеийн хэвлэл мэдээллийн технологи нь улс төрчдийг иргэдэд илүү ойртуулсан боловч парламентын энгийн гишүүдийг орхигдуулж голчлон намын лидерүүдэд анхаарлаа төвлөрүүлдэг. Телевизийн мэтгэлцээнд ихэвчлэн сайд дарга нар оролцож өөрсдийн нэр хүнд, эрх мэдлийг нэмэгдүүлээд зогсохгүй, намынхаа нөлөөг сайтар бэхжүүлдэг. Ингэх нь эрх мэдлийг гүйцэтгэх засаглалд шилжүүлж, тэднийг хязгаарлах ёстой төлөөлөгчдөөс нь улам бүр холдуулдаг.

Сонгуулийн зардал өсөхийн хэрээр мөнгөний нөлөө нэмэгддэг нь олон нийтэд улс төрчид нь худалдагдсан гэх ойлголтыг төрүүлдэг. Иргэд улс төрчдөө сонгуулиар зайлуулдаг ч удалгүй тэд улс төрийн тогтолцооны дотоод мэдээлэлд нэвтрэхийг хүссэн компаниудад өндөр цалинтай албан тушаалд томилогддог. Иймээс улс төрчид зөвхөн хувийнхаа сонирхлын төлөө ажилладаг гэсэн ойлголт улам бүр бэхждэг. Бусад тогтолцоонд ч мөн адил улс төрчид хувийн сонирхолдоо хөтлөгддөг нь үнэн боловч ардчиллын нөхцөлд л энэ нь илүү ил тод харагддаг гэж хэлж болно.

СОНГОГЧДЫН ӨӨРЧЛӨЛТ

Сонгогчдын бүтцэд ч мөн адил өөрчлөлт гарсан. Хүмүүсийн хөрөнгө чинээ, боловсрол нэмэгдэж, зорчих хөдөлгөөн чөлөөтэй болсноор анги давхарга, кастын хориг саад нуран унажээ. Ядуу гэр бүлээс гаралтай хүмүүст ч гэсэн өөрсдийн чадлаар бэлжих, алдар нэртэй болох цаашлан эдийн засаг, улс төрийн тогтсон хэм хэмжээг өөрчлөх боломж улам бүр нэмэгдсэн байна. Гэвч уналтанд орсон тодорхой аж үйлдвэрлэлийн салбарынхан өөрсдийгөө орхигдож, гадуурхагдсан мэтээр мэдэрдэг учраас үндсэрхэг үзэл, популизмыг дэмжихэд хүрдэг.

Технологи улс төрд томхон өөрчлөлтийг авчирсан. Тухайлбал өнөө үед ихэнхи хүмүүс мэдээ мэдээллээ онлайнаас авах болжээ. Сошиал медиа нь цөөнхийн бүлгүүдэд ижил төрлийн үзэл санаатай хүмүүсийг эгнээндээ нэгтгэх явдлыг улам бүр хялбаршуулж, улс төрчдийн оролцоогүйгээр бие биенээ дэмжих боломжийг бүрдүүллээ. Урьд нь зөвхөн улс төрчдийн хяналтанд байдаг томхон төрийн байгууллагуудын гүйцэтгэдэг байсан үйлчилгээнүүдтэй (хэвлэл мэдээлэл, нийтийн үйлчилгээ, харилцаа холбоо, тээвэр) хувийн жижиг компаниуд олон төрлийн шинэ аргачлалын тусламжтайгаар өрсөлдөж байна.

Эдгээр үйлчилгээнүүд нь хэрэглэгчдийн улс төрчдөөс хамаарах хамаарлыг багасгаж, сургууль, нийгмийн хамгаалал зэрэг нийтийн үйлчилгээг зөвхөн төр хариуцах ёстой гэх санааг эргэлзээнд оруулж, өөр хувилбар сонголтуудын тухай хэлэлцүүлгийг бий болгов.

Хүн амын насны бүтэц ч өөрчлөгдөж байна. Өрнөдөд “бэби бүүмер” үеийнхэн улс төрд нөлөөтэй болж, харин өөр бусад газарт миллениалуудын нөлөө улам бүр нэмэгдсээр байгаа нь нийгмийн үзэл хандлагад маш их нөлөө үзүүлэх болсон. Улс төрд голлох шийдвэрийг гаргаж буй ахмад үеийнхэн өөрсдийнхөө сонирхлыг хамгаалахын тулд эрх мэдлээ урвуулж ашигласан тухайд залуус гомдоллох нь нэмэгдсэн. Тухайлбал ахмадууд өөрсдөдөө тэтгэвэр, нийгмийн даатгал, үнэгүй эрүүл мэндийн үйлчилгээ зэрэг өгөөмөр тэтгэмжүүдийг дуу нэгтэй батлахын сацуу эдгээрийг санхүүжүүлэх мөнгө санхүүгийн зардлаа хойч үедээ өр төлбөр үлдээх байдлаар шийдвэрлэсэн. Иймэрхүү үйл явдлууд нь ардчилсан улс төрийн үйл явцад итгэл алдрах явдлыг улам бүр нэмэгдүүлсээр байна.

ДҮГНЭЛТ

Дээрхи шалтгаануудын улмаас олон нийт ардчилсан улс төрчдөөс улам бүр зайгаа барих болжээ. Иймээс илүү радикал үзэл баримтлалтай, жижиг намуудын байр суурь аажмаар бэхжиж байна. Ардчиллыг талархан дэмжигчдийн санааг хамгийн зовоох ёстой асуудал нь өнөөгийн улс төрийн элитүүдэд олон нийтийн дургүйцэх хандлага нь эцэстээ ардчилалд итгэл алдрах явдалд хүргэж болзошгүй аюул юм. Либерал ардчиллын олон давуу талыг харгалзан үзвэл ингэх нь ноцтой бэрхшээл дагуулна. Иймээс бид олон нийтийн зүгээс ардчилалд яагаад урам хугарах болсон гол шалтгааныг нь ойлгож ардчилсан улс төрийн үйл явцыг хүмүүст илүү ойртуулах арга замуудыг эрэлхийлэх шаардлагатай.

XI

ИРЭЭДҮЙН ОРОЛЦОО

ОРОЛЦООНЫ ХЭЛБЭРҮҮД

Зарим хүмүүс ардчиллын бэрхшээлийг оролцооны шинэ хэлбэрүүдийг хангаснаар шийдвэрлэх боломжтой гэж үздэг. Тэдний хувьд хамгийн зохистой загвар нь иргэд шийдвэр гаргах үйл явцад шууд оролцдог, эртний утгаараа илүү “оролцоот” ардчилал юм. Үүнийг өнөө үеийн зөвхөн иргэдийн саналыг тоолж, тэнцвэржүүлдэг ‘санал нэгтгэх’ аргачлалын эсрэг сэргүүлэн дэвшүүлдэг.

Албадан санал өгүүлэх аргачлалыг санал болгодог хүмүүс ч байдаг. Үүнийг “оролцооны” хэлбэрийг сайтар хангасан гэж хэлэх боломжгүй. Учир нь хүн ердөө саналаа өгөхөд л хангалттай. Гэхдээ энэ нь олон нийтийн хэлэлцүүлт өргөн хүрээний сонирхлыг төрүүлж болзошгүй гэж найдах хүмүүс элбэг. Австрали, Уругвай, Бельги, Люксембург зэрэг хэд хэдэн ардчилсан оронд албадан саналын арга хэмжээг хэрэгжүүлдэг. Гэхдээ энэ нь сонгуулийн үр дүн эсвэл олон нийтийн хэлэлцүүлэгт ямар нэгэн нөлөө үзүүлдэг гэх нотолгоо хомс.

Өөр нэг санал нь шууд ардчилал буюу референдум болон нийтийн саналын санаачилга (ballot polling) зэрэг арга хэрэгслүүд бөгөөд үүнийг зохион байгуулснаар хүн бүрт хууль тогтоомжийг батлахад шууд саналаа өгөх боломжийг олгодог. Хэд хэдэн газарт аль хэдийн

хэрэгжих болжээ. АНУ-ын зарим мужид ‘хориг тавих’ референдум зохион байгуулагддаг бөгөөд энэ нь сонгогчдод муу хуулиуд батлагдахаас урьдчилан сэргийлэх боломж олгодог. Калифорнид иргэд нь хууль тэр ч бүү хэл мужийн Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санаачилга гаргах эрхтэй.

Гурав дахь стратеги бол зөвлөлдөх санал асуулга юм. Хүн амын төлөөлөл болсон бүлгүүдийг санал асуулгад оролцуулж үзэл бодлыг нь тодорхойлдог. Ингээд тэднийг амралтын өдрүүдэд хамтдад нь цуглуулж судалгааны үр дүнг хэлэлцүүлнэ. Тэдэнд асуудлын талаарх аргументуудын талаар товч мэдээлэл өгдөг бөгөөд тэд өөр хоорондоо болон мэргэжилтнүүд, улс төрчидтэй зөвлөлддөг. Дараа нь дахин санал асуулга явуулснаар шийдвэрлэх асуудлын талаарх мэдээлэлтэй хэлэлцүүлэг нь анхны санал асуулгын үр дүнтэй харьцуулахад хэр зэрэг өөрчлөгдсөн гэдгийг нь харьцуулдаг. Энэ арга нь хууль тогтоогчдод олон нийтийн хувьд жинхэнэ ач холбогдолтой асуудлуудыг илүү сайтар ойлгоход тустай гэдэг.

Үүний нэг хувилбарыг иргэдийн шүүх гэж томъёолдог бөгөөд 12-24 хүртэлх хүнээс бүрдсэн жижиг төлөөллийн бүлэг хуралдаж, мэргэжилтэн гэрчүүдээс асуулт асууж, асуудлуудыг хэлэлцдэг. Уг бүлгийн дүгнэлтийг

олон нийтийн сонголт болон хууль тогтоогчдын шийдвэрт тусгана гэдэг нь гол санаа нь юм.

Цөөнгүй хүмүүс дижитал ардчиллыг сурталчилдаг. Сонгуульд санал өгдөггүй хүмүүсийн гуравны хоёр орчим хувь нь хэрвээ онлайнаар санал өгөх боломжтой байсан бол сонгуульд оролцох байсан тухайгаа хэлдэг. Уг санааг дэмжигчид онлайн саналын тогтолцоо нь сонгогчдод тодорхой асуудал, аргументуудын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжтой гэдгийг онцолдог.

Мэдээллийн технологи нь хэдийнээ ардчиллын үйл явцыг өөрчилжээ. Австралийн ‘MiVote’ зэрэг платформууд нь сонгогчдод парламентад хэлэлцэж буй гол асуудлуудын талаар олон төрлийн үзэл бодлыг олж мэдэх боломжийг олгодог. Исланд 2008 онд Үндсэн хуулийн шинэтгэлээ ‘онлайн олон нийт’-ийн оролцоотой хийсэн. Эстонийн Засгийн газар өөрсдийгөө ‘электрон улс’ гэж тодорхойлж байна. Мөн суралцдаг машин, орчуулгын програмууд нь өнөөгийн дэлхий ертөнц даяар хүмүүсийг хамарсан томхон хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах боломжийг бүрдүүлжээ.

Гэвч технологи үнэхээр хүмүүсийн мэдлэг, мэдээллийг сайжруулж олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнд сайнаар нөлөөлж байгаа хэрэг үү? Ингэж үзэх нотолгоо хомс.

Мэдээллийн технологи хүмүүст их хэмжээний мэдээлэлд нэвтэрч, өргөн хүрээний асуудлаар санал өгөх (зөвхөн нэр дэвшигчдийг сонгохоор хязгаарлагдах бус) боломжийг бүрдүүлсэн ч хүмүүсийн цаг хугацаа нэгэнт хязгаарлагдмал байдгаас хойш тэд иррационал, харанхуй байсаар байж саналын нөлөө нь ч жин багатай хэвээр байна.

ОРОЛЦООГ ДЭМЖИХ АРГУМЕНТУУД

Нэг хариулт нь хүмүүсийг шийдвэр гаргах үйл явцад илүү идэвхтэй оролцуулах явдал гэж хэлж болно. Үүнийг дэмжих бусад аргументууд ч бий. Олон хүн энгийн иргэдийг улс орны хэмжээний чухал шийдвэрүүдэд оролцуулахыг ашиг тустай гэж үздэг. Энэ нь хүмүүсийг асуудлын талаар бодож эргэцүүлэхэд хүргэж нийгмийн ухамсрыг дээшлүүлдэг. Илүү мэдээлэлтэй болсноор зөв сонголт хийж чадна. Үүнийг бүх түвшинд хэрэгжүүлж болох бөгөөд тухайлбал засгийн газар улс орны амин чухал асуудлаар нийт иргэдийнхээ мэргэн ухаанд тодорхой хэмжээнд найдаж болох бол орон сууц өмчлөгчид өөрсдийн орон сууцныхаа менежментийн асуудлыг ч гэсэн ижил төстэй байдлаар шийдэх боломжтой.

Практикч аргументууд ч бий. Хуучны санал өгөх арга барил нь ардчиллыг хэт төвлөрсөн, хүнд сурталт, хөшүүн, хязгаарлагдмал хүрээтэй болгодог. Улс төрчид хүн бүрийн саналыг харгалзан үзэх боломжгүй тул нэг хэсэг нь хожиж үлдсэн нь хохирсон бодлогууд хэрэгждэг. Илүү төвлөрөлгүй шийдвэр гаргах нь түргэн бөгөөд орон нутгийн иргэдэд ч илүү ойр, тогтвортой бодлого боловсруулахад тустай. Хуучны улс төр нь сонгогчдыг уриа лоозон, хэлц үгээр бөмбөгддөг бол онлайн системүүд

нь хүмүүст холбогдох мэдээллийг хүргэсэн вэб сайтуудад хандах боломж бүрдүүлдэг. Энэхүү оролцооны ардчилал нь улс төрд хэтэрхий удаан оршин тогтнож, хяналтаа бэхжүүлсэн зонхилох намуудын нөлөөг сулруулж, шинэ санааг цэцэглүүлж, нийгмийн өөрчлөгдөж буй нөхцөлд хурдан хариу үйлдэл үзүүлэх боломжийг хангана.

ОРОЛЦООНЫ ЭСРЭГ ПРАКТИКЧ АГУМЕНТУУД

Үүний үр дүнд бүрэн дүүрэн итгэлгүй хүмүүс бий. Тэд бүх нийтийн референдум, нийтийн саналын санаачилга зэрэг шууд ардчиллын арга хэрэгслүүд нь сонгогчдоос асуудлыг судалж, хэлэлцэхэд үнэтэй цаг, хүчин чармайлтыг нь зарцуулахыг шаарддаг бас ганцаарчилсан саналын жин маш бага хэвээр байгаа гэж мэтгэдэг. Хэрвээ сонгогчид холбогдох асуудлаар мэдээлэлтэй шийдвэр гаргаж чадахгүй бол шийдвэр гаргах асуудлыг илүү мэдлэг, мэдээлэлтэй төлөөлөгчдөд даатгах нь иүү дээр гэдэгт үнэний хувь бий. “Ардчилал гэдэг нь иргэд байнга цугларч, нийтийн асуудлыг өөрсдөө хэлэлцдэг төлөв байдал биш” гэж Францын хувьсгалын удирдагч Максимилиан Робеспьер (1794) хэлсэн удаатай. “Ардчилал нь иргэд, бүрэн эрхт субъект болж, өөрсдөө сайн хийж чадах зүйлээ хийхийн сацуу өөрсдийн чадахгүй бүхнийг төлөөлөгчдөөрөө дамжуулан хийлгэдэг төлөв байдал”.

Цаашилбал АНУ-ын туршлагаас харахад нийтийн саналын санаачлагыг ихэвчлэн тогтсон улс төрийн намууд зохион байгуулдаг. Учир нь тэдэнд л хамгийн их санхүүжилт, кампанит ажлын чадавхи бий. Мөн иргэдийн санаачилгууд ихэвчлэн хагас дутуу боловсруулагдсан эсхүл

татвар төлөгчдийг мөлжих, өрсөлдөгчдийнхөө эрх ашгийг хохироохыг зорьсон сонирхлын бүлгүүдээс эхтэй байх нь элбэг. Энэ нь сонгууль бүрт бизнесүүд хор хөнөөлтэй эсхүл хагас дутуу боловсруулсан саналуудыг эсэргүүцэхэд сая сая ам.долларыг зарлагадана гэсэн үг. Түүнчлэн уг тогтолцоо нь санхүүгийн болон хууль эрх зүйн хувьд нийцгүй шийдвэрүүдийг ч бий болгодог.

Референдум нь төлөөллийн ардчилалтай зөрчилдөж байгаа мэтээр ойлгогдох нь ч бий. Төлөөллийн ардчиллын гол зорилго бол сонгогчид асуудал бүхнийг шийдэх шаардлагагүй байж үүнийг төлөөлөгчдөөрөө гүйцэтгүүлэх явдал. Тэгвэл референдумын зорилго юу вэ? Тэдэнд хууль хэлэлцэх чадамж бий юу? (Ингэвэл либерал бус хуулиуд батлагдах магадлалтай) Төлөөлөгчид хэрхэн ажлаа хийхийг зааварлах чадамж тэдэнд бий юу? Эсхүл тэдний санал зүгээр л зөвлөмжийн шинжтэй хэрэг үү? (Тэгвэл яагаад зөвхөн санал асуулгад найдах аргагүй гэж?) Эдгээр асуултанд бүрэн тодорхой хариулт байхгүй. Хэдий референдумын төлөөллийн ардчилал дахь яг таг үүрэг нь тодорхой бус байж болох ч эерэг нөлөө үзүүлдэгийг үгүйсгэх боломжгүй.

Америкийн судлаач Жон Г. Мацусакагийн (2004) бүрдүүлсэн баримтуудаас харахад орон нутгийн референдумууд нь улс төрийн

маргааныг тасалж, татвар төлөгчдийн мөнгийг хэмнэхэд тустай байдгийг илтгэсэн.

Дижитал ардчиллын хувьд шүүмжлэгчдийн зүгээс үүнийг эрх баригчид болон санхүүжилттэй лобби бүлгүүдэд үйлчлэх болно гэж үздэг. Мөн зарим иргэд ялангуяа ахмад настангууд санал асуулгад онлайнаар оролцоход хүндрэлтэй байж болох нь улс төрийн тэгш байдлын үзэл баримтлалыг сулруулна. Зөвлөлдөх тогтолцооны тухайд Жейсон Бреннан (2016) мэтийн шүүмжлэгчид ингэх нь уламжлалт санал нэгтгэлийн аргачлалаас илүү муу шийдвэр гаргахад хүргэдэг гэж мэтгэдэг. Хэлэлцүүлгийн бүлгүүд ихэвчлэн тогтсон ойлголтуудыг л хүлээн зөвшөөрч, шинэ санаа туршихад саад учруулна. Оролцогчид хүчтэй итгэл үнэмшилтэй, харизмтай хувь хүмүүсийн нөлөөнд амархан автдаг. Онолын хувьд бие даасан зуучлагчид үүнийг засаж залруулах ёстой ч өөрсдөө хувийн сонирхолдоо хөтлөгдөж хэлэлцүүлэгт өрөөсгөл хандлагатай оролцох нь бий. Нөгөө талаас зарим хүмүүс өөрсдийн уламжлалт бус үзэл бодлоо танихгүй хүмүүсийн өмнө илэрхийлэхээс ичдэг учраас саналын хайрцагт нэрээ нууцлан чөлөөтэй илэрхийлэхийг хүсдэг. Иймээс зөвлөлдөх бүлгүүд олон нийтийн санал бодлыг бүрэн төлөөлж чадахгүйгээс гадна уламжлалт, төвч үзэлтэй дүгнэлтэнд хүрэх магадлал өндөртэй.

ОРОЛЦООНЫ ЭСРЭГ ЗАРЧМЫН ШИНЖТЭЙ АРГУМЕНТУУД

Албан ёсны сувгуудаар дамжуулан оролцох оролцоо нь одоо байгаа тогтолцооноос илүү ‘ардчилсан’ шинжтэй биш гэж маргах хүмүүс байдаг. Иргэд хэдийнээ сошиал медиа болон бусад хэрэгслээр дамжуулж бие биетэйгээ харилцдаг бөгөөд ингэх нь иргэдийн шүүхээс илүү түргэн шуурхай, өргөн хүрээтэй оролцооны хэлбэр юм. Албан ёсны оролцооны аргууд нь сонгогчдыг сургаж, гэгээрүүлэхэд бодитой тус болдог гэдэг нь ч тодорхой бус. Тухайлбал заавал санал өгөх нь иргэдийн улс төрийн асуудлын талаарх мэдлэгийг нэмэгдүүлдэггүй. Бас сонгуулийн үр дүнг өөрчилдөггүй.

Ямартай ч тэдний үзэж байгаагаар асуудал бэрхшээлийн гол шалтгаан нь боловсролд бус сэдэлд оршдог байна. Сонгогчид өдөр бүр мэдээллийн урсгалд өртдөг боловч хувийн шинжтэй, илүү тулгамдсан асуудлууддаа сэтгэлээ чилээдэг тул үүнийг үл тоомсорлодог. Хүн бүрийн оролцоонд тэмүүлэх хүсэл нэг бүрчлэн эрс ялгаатай. Цөөн хүн л намын гишүүн болж, ухуулах хуудас тарааж, улс төрийн хурал цуглаанд оролцож эсхүл өглөг хандив өгдөг. Ийм байхад яагаад хүн бүрт нийтийн асуудлыг хэлэлцэх боломж олговол тэдний оролцоо нэмэгдэнэ гэж таамаглах ёстой гэж? Ихэнх

хүмүүсийн хувьд улс төрөөс илүү уйтгартай зүйл гэж байхгүй.

Албан ёсоор иргэдийн оролцоог тодорхой байдлаар зохион байгуулж хангах явдал нь ихэнх хүмүүст огт тустай үйл хэрэг биш гэж үүнийг шүүмжлэх нь бий. Хүмүүс үүнд үнэ цэн, ач холбогдол өгч хүндэтгэхгүй төдийгүй боломжийг ухаалгаар ашиглаж чадахгүй. Энэ нь бидний одоогийн тогтолцооноос илүүтэй ‘ардчилсан’ шинжтэй эсхүл илүү сайн тогтолцоо гэх баталгаа огт байхгүй.

БИД ИЛҮҮ ИХ ‘АРДЧИЛАЛ’-ЫГ ҮНЭХЭЭР ХҮСДЭГ ҮҮ?

Жейсон Бреннаны (2016) хэлсэн ёсоор илүү их ‘оролцоот’ ардчилал нь бодит муу үр дагаваруудыг бий болгох өөр бусад ноцтой шалтгаанууд ч бий. Сонгогчид нийтийн бодлогын асуудлаар гайхширмаар мэдээлэл муутай, харанхуй байдаг нь нэгэнт тодорхой учраас оролцоо нь тэднийг ямар нэг байдлаар бодлогын мэргэжилтэн болгох найдвар нь угтаа ямар ч утга учиргүй. Тэднийг бүр чадварлаг сонирхогч ч болгох магадлал үгүй бөгөөд хэрэв иймэрхүү оролдлого хийвэл тэд эсэргүүцэл үзүүлж болзошгүй. Ажил, гэр бүл, хобби зэрэг бусад бүхэн нь тэдний хувьд илүү чухал ач холбогдолтой. Тиймээс тэднийг улс төрд хүчээр оролцуулах нь өөрсдөд нь хортой. Тэдний хувьд үнэ цэнэтэй, хийхийг хүсдэг зүйлсдээ зарцуулах цагийг нь хумсалж, хүсээгүй үйлдлийг нь хийлгэхэд хүргэх талтай.

Улс төр бидний амьдралд ийм үлэмж том байр суурийг эзлэх ёстой юу? Улс төр хүмүүсийг илүү ухамсар, ёс суртахуунтай болгодоггүй харин ч тэднийг завхруулах магадлал илүү өндөр. Улс төрийн эрх мэдлийн сэтгэл татам байдал, бусдын амьдралд өөрийн үзэл бодлыг тулгах эрх мэдэл нь хүмүүсийг уруу татдаг. Либерал ардчиллын үндсэн зорилго нь ийм дур зоргыг хязгаарлаж,

эрх мэдэлтнүүдийг бусдыг дарлан мөлжихөөс сэргийлэхэд оршдог. Гэвч хамтын шийдвэр гаргах үйл явцыг 'оролцоот ардчилал гэж нэрлэн хууль ёсны болгох тусам олонхын зүгээс дээрхи бусармаг үйлдлүүдийг хийх боломж улам бүр хялбарчлагдаж цөөнхийн зүгээс үүнийг эсэргүүцэх боломж улам бүр хумигддаг.

ХЯЗГААРЛАГДМАЛ АРДЧИЛЛЫН САНАА

Хэрэв сонгогчид үнэхээр ухаан, боловсрол, мэдээлэл хомс, жалга довын сэтгэлгээтэй мөн хувийн сонирхолдоо хэт хөтлөгддөг нь үнэн аваас гол асуудал нь тэднийг өөрчлөхөд (найдлагагүй мэт) бус тэдэнд яагаад бусдын амьдралыг хянах ямар нэг эрх мэдэл олгох ёстой вэ гэдэгт оршино. Энэ нь илүү их ардчиллыг дэмжих бус харин ч хязгаарлагдмал ардчиллын төлөөх үндэслэл юм. Үүнийг бид өөрсдийн өмнөөс гаргах ёстой шийдвэрүүдийг өмнөөс маань гаргадаг бус харин ч бидний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг хамгаалах үндсэн үүргээ сайтар гүйцэтгэдэг хязгаарлагдмал төрийн тухай санаа гэж хэлж болно.

Либерал ардчиллын гол санаа нь эрх чөлөөг хянахын тулд бус харин ч хамгаалах зорилготой гэдэг. Энэ нь олонхын хүчээр хүмүүсийн амьдралын дийлэнхи харилцааг зохицуулахад зориулагдсан механизм огт биш. Харин зөвхөн хамтын шийдвэр гаргах ёстой цөөн тооны асуудлыг шийдвэрлэхэд илүү мэдээлэлтэй, сонирхолтой, чадварлаг байж болох төлөөлөгчдийг л сонгох аргачлал юм. Сонгогчдыг өөрсдийнх нь хүсээгүй байдлаар хүчээр өөрчлөхийн оронд тэдний бодит байдалд нийцүүлж, хамгийн сайн засаглалыг бий

болгохуйц институциудыг цогцлоох нь илүү
зохимжтой байж мэднэ.

XII

АРДЧИЛАЛ БА ХИЛ ХЯЗГААР

1989 онд Берлиний хана нурснаар автократ дэглэмүүд түгшүүрийн байдалд оров. ЗХУ-ын харгис хэрцгий бодит байдал илчлэгдсэнээр авторитари дэглэмүүдийн легитим байдалд бэрхшээл учрах болжээ. Ингээд ардчилал нь цор ганц зүй ёсны хувилбар мэтээр ойлгогдох болсон. Зүүн Европ, Латин Америк, Африк (ялангуяа 1994 онд апартейд дууссанаар), Өмнөд Ази, Зүүн Өмнөд Ази тэр ч бүү хэл Хятадад хүртэл шинэтгэл реформын төлөөх хөдөлгөөнүүд бий болов. Олон улсын индексүүдээр улам олон улс орнууд ‘эрх чөлөөтэй’ гэж тодорхойлогдох болсон.

Америкийн улс төр судлаач Фрэнцис Фукуяма (1992) ‘түүхийн төгсгөл’ гэх ойлголтыг дэвшүүлж, либерал ардчилал нь дэлхий даяар бусад тогтолцоотой өрсөлдөж ялсан гэх онолыг дэвшүүлсэн. Өрнөдийн улс төрчид уг хандлагыг бодит байдал болгох үүднээс ардчиллыг дэлхий даяар түгээхийг өөрсдийн үүрэг гэж үзэх боллоо. Дарангуйлагчидтай тэмцэж, гадаад тусламж, худалдааны хэлцлүүдийг улс орнууд авлигаа бууруулж, засаглалаа сайжруулж, ардчилсан институциудыг нэвтрүүлэх эсэхээс хамааруулж өгөх болжээ.

Гэвч либерал ардчиллыг хуулбарлах, цогцлоох нь тийм ч хялбар хэрэг биш ажээ. АНУ-ын Дээд Шүүхийн шүүгч Энтони Кеннеди (1999)

“Ардчилал нь үеээс үед дамжин суралцдаг үнэт зүйлс” гэж хэлсэн байдаг. Үнэхээр ч анхны орчин үеийн ардчиллуудыг цогцлоохын тулд олон зууны тэмцэл тулаан өрнөж цус урсгахаас өөр аргагүй байлаа. Өнөөдөр олон улс оронд бодит ардчиллын загварууд бий болсон тул ардчиллыг шинээр хурдацтай, энх тайвнаар байгуулах боломж бүрдсэн байж болох талтай.

Хэдий тийм боловч саад бэрхшээлүүд байсаар байна. Ардчиллын үйл явц бодитой байж, үр өгөөжийг нь иргэд хүртэхийн тулд хүмүүс үүнийг хүлээн зөвшөөрч, ойлгож, үнэлж, хайрлаж, хүндэтгэх хэрэгтэй. Автократ засаглалын дор амьдарч ирсэн хүмүүс ихэвчлэн ардчиллаас айж эсхүл үүнийг буруугаар ойлгодог. Хэдий Египет болон бусад Ойрхи Дорнод, Хойд Африкийн улсууд Хосни Мубарак зэрэг дарангуйлагчдаа ‘ардчилсан’ дэглэмүүдээр сольсон ч эдгээр нь зарим талаараа улам бүр либерал бус шинжтэй болж, сонгуулиар сонгогдсон хувьсгалчид олонхын сонголт тэдэнд хязгааргүй эрх мэдлийг өгсөн гэж эндүүрсэн түүхтэй. Ардчиллаас гадаад хэлбэрийг нь авсан ч түүний үндсэн агуулага болсон зарчмуудыг нь орхигдуулах нь туйлын түгээмэл. Югослав зэрэг улсын Иосиф Тито зэрэг дарангуйлагчид улс орондоо угсаатан болон шашны бүлгүүдийн зөрчлийг дарж байсан боловч тэднийг зайлсан даруйд

улс орон нь дайн дажны хөлд нэрвэгдсэнтэй ижил түүх олон. Автократ дэглэмээс ардчилсан дэглэмд шилжихээс айж болгоомжилж байсан хүмүүсийн айдас зарим талаараа зөвтгөгдөх нь ч бий.

ӨРНӨДИЙН АЛДАА

Ардчиллыг ердөө л хөрсөнд нь суулгачихвал өөрөө ургаж төлжинө гэж найдах аргагүй. Ардчилалд анхаарал, халамж, арчилгаа шаардагдана. Мөн ардчилал нь хөгжил дэвшил, эрх чөлөөнөөс алслагдсан танил бус улсуудад эдгээр зүйлсийг хар аянд нь бий болгоно гэж үзэх аргагүй. Харамсалтай нь Өрнөдийн улс төрчид яг ийм найдлагыг тээсэн билээ. Үүний шалтгаан нь ардчилал нь эрх чөлөө, хөгжил дэвшилд хөтөлдөг гэх төөрөгдөл. (Үнэндээ либерализмын зарчмууд л энэ бүхэнд хөтөлдөг) Тэд ядуу буурай орнууд дарангуйллаас ангижраад өөрсдийн ардчилсан институциудыг тэр даруй цогцлоож чадна гэдэгт гэнэнээр итгэсэн.

Өрнөдийн ард түмнүүд либерал ардчиллын институциуд цогцолсон орчинд урт хугацаанд амьдарсан тул энэ бүхнийг энгийн байдаг л зүйл мэтээр ойлгох жишээтэй. Тэд шударга ёс, хууль дээдлэх ёс, эрх чөлөө, итгэлцэл, үнэнч байдал зэргийг хаа сайгүй л байдаг эсхүл дарангуйллын хүнд сүүдэр арилсан даруид бий болдог үнэт зүйлс гэж таамагладаг. Тэд улс бүрийн нийтлэг үндэсний ухамсар, боловсрол, либерал үзэл хандлагатай дундаж ангийнхан ардчилсан шинэтгэлийг ойлгож, талархаж хүлээж авна гэж төөрөгддөг.

Харин олон зууны турш автократ засаглалын

дор амьдарсан улс орнуудад эдгээр үнэт зүйлсийн сүүдэр ч үгүй, тэр ч бүү хэл эдгээрийн талаарх тодорхой ойлголт ч огт байхгүй. Угсаатны болон бусад бүлгүүдийн хооронд гүн гүнзгий үзэн ядалт эсхүл үл итгэлцэл зонхилдог. Иргэд нь улс орон хүчирхэг автократ удирдлагагүйгээр оршин тогтнох боломжгүй гэдэгт итгэдэг. Тэд хөгжингүй ардчилсан улс орнуудыг сул дорой, хэт тансаг, зохион байгуулалтгүй гэж ойлгодог. Тэдний хувьд эрх чөлөөнөөс илүүтэй тогтвортой байдлыг, хөгжил дэвшлээс илүүтэй уламжлалыг, хуулиас илүүтэй шашныг илүү эрхэмлэх хандлагатай байдаг.

Райан Мерфи судалгаагаараа (2018) бусад бүх хүчин зүйлсийг харгалзан үзэхэд автократ засаглал нь үнэндээ илүү дээр үр дагаварыг бий болгодог гэх нотолгоо байдаггүй болохыг харуулсан. Гэвч дэлхий дахинд ардчиллын ашиг тустай байдалд хүмүүсийг итгүүлэх нь тийм ч хялбар хэрэг биш бололтой.

ШИНЭ ТУТАМ АРДЧИЛЛУУДАД ТУЛГАРДАГ БЭРХШЭЭЛ

Улс орнууд сонгууль, парламент, шүүх гэх мэт ардчиллын гадаад хэлбэрийг хуулбарласан ч түүний бодит зарчмуудыг хэрэгжүүлж чадахгүй байх нь элбэг. Хууль дээдлэх ёсыг сахидаггүй, шүүх байгууллага нь авлигад идэгдсэн, эрх чөлөөний баталгаа сул эсхүл цөөн хүмүүсээр хязгаарлагддаг гэх мэт. Мөн шашны үзэл суртлын дарангуйлал хувь хүний эрх чөлөөг боомилдог. Хуурамч сонгууль зохион байгуулагддаг. Парламентанд зөвхөн нэг нам зонхилдог. Мөн сонгуульд ялсан удирдагчид ардчиллаар олгогдсон ‘бүрэн эрхэндээ’ дулдуйдаж өрсөлдөгчдөө хавчин гадуурхах, нухчин дарах нь түгээмэл.

Түүнчлэн, үндэстний ижилсэл буюу бид нэг улс үндэстэн гэх тогтсон үзэл санаа ч зарим ард түмэнд байхгүй. Угсаатны, овгийн, соёлын, үзэл суртлын болон шашны зөрчилдөөн нь урт хугацаанд үргэлжилсэн хагарал, тэмцэл, эмгэнэлийг бий болгосон байх нь бий. Улс төрийн намуудын хоорондын тэмцэл нь сул дорой, үйл ажиллагаа нь доголдсон төр засгийг бий болгох нь ч элбэг. Зарим тохиолдолд олонд хүндлэгдэж, хүлээн зөвшөөрөгдсөн цөөн хувь хүмүүс нь өөр хоорондоо дайсагнасан цэргийн эрхтэнгүүд байдаг. Хүмүүс зэвсэгт хүчнийг

тогтвортой байдлыг бий болгох цорын ганц арга зам гэж үзэх эсхүл өөрсдийн шашны болон улс төрийн үзэл суртлыг бусдад тулгахад зайлшгүй шаардлагатай хэрэгсэл ч гэж харах боломжтой. Иймээс хүчирхэг цэргийн засаглал нь эрх чөлөөт, ардчилсан дэглэмийн санаанаас илүүтэй нийгмийн дэмжлэгийг хүлээх боломжтой. Мөн шашны болон улс төрийн хэт туйлшрагчид өөрсдийн өрсөлдөгчдөө засаршгүй муу муухай гэж цоллосноор либерал ардчилал нь олон янзын ялгаатай амьдралын хэв маягийг хүлээн зөвшөөрдөг учраас тэдний үнэт зүйлсэд нь харшилна ч гэж харах боломжтой. Иймэрхүү хэт туйлшрагчид өөрсдийн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд терроризм эсвэл цэрэг зэвсгийн хүч ашиглахад бэлэн байдаг бөгөөд шинэ тутам ардчиллын эмзэг институциуд нь ийнхүү өлгийндөө устахад хүрдэг.

АРДЧИЛЛЫН ҮНЭТ ЗҮЙЛСИЙГ ТУЛГАН ХҮЛЭЭЛГЭХ

Эдгээр бэрхшээлтэй тулгарсан газруудад либерал ардчиллын ирээдүй тун бүрхэг харагдаж байгаа ч Өрнөдийн улсуудын засгийн газрууд ардчилал л зөвхөн хамгийн зүй зохистой шийдэл гэсэн итгэл үнэмшлээр үүнийг турших өндөр сонирхолтой байдаг. Ардчилал нь энх тайван, эрх чөлөө, хөгжил дэвшилд хөтөлсөн гэж итгэсэн тэд бусад улс орнууд ч бас эдгээрийн ашиг тусыг хүртээсэй гэж хүсдэг. Тэд чөлөөт сонгууль, бүх нийтийн сонгуулийн эрх зэрэг ардчилсан институциудыг нийгмийн болон улс төрийн өөрчлөлт шинэтгэлийн хөдөлгүүр гэж хардаг. Тэд бүр ардчиллыг өөрийг нь тэмүүлэх ёстой идеалд тооцож, хүний эрхэм чанар, улс төрийн тэгш байдал зэрэг чухал зарчмуудын илэрхийлэл гэж харахыг хүсдэг.

Гэвч ардчиллыг бусад улсад экспортлох тэдний оролдлогуудыг бүрэн дүүрэн амжилттай хэрэгжсэн гэж үзэх аргагүй. Тухайлбал 2003 оноос эхэлсэн Иракийн дайн нь автократ дарангуйллыг зайлуулах гэсэн хязгаарлагдмал зорилгыг тээж байв. Ингэснээр либерал ардчиллын үзэл санаа, зарчим, институциуд хар аяндаа цогцолно гэж таамагласан. Гэвч энэ нь хэт өөдрөг гэнэн санаа байсан нь нотлогдсон. Харамсалтай нь дэглэмд үнэнч хүмүүсийг

системчлэн зайлуулсан явдал нь улс төрийн голлох институциудыг (цагдаа, шүүх, иргэний захиргаа) нь удирдлагагүй болгож, эмх замбараагүй байдалд хөтөлж, хүн хоорондын итгэлцлийг устгаж, ардчилсан шинэтгэлүүдийг нэвтрүүлэхэд илүү бэрх болгосон.

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУД

Олон улсын байгууллагууд тухайлбал Нэгдсэн Үндэстний Байгууллага дэлхийд ардчиллыг цогцлооход гол үүргийг гүйцэтгэж чадах уу? Үүнд эргэлзэх хэд хэдэн том шалтгаан буй.

Нэгдүгээрт, Дэлхийн Банк эсхүл Олон Улсын Валютын Сан зэрэг олон улсын байгууллагууд нь ихэвчлэн нео-колонилогчид гэж ойлгогддог бөгөөд өөрсдийн санхүүгийн эрх мэдлийг ашиглаж улс төрийн тодорхой үзэл баримтлалыг бусдад тулгадаг. Жишээлбэл, тэд нийтийн хариуцлагын талаарх өөрсдийн үзэл баримтлалд нийцээгүй улс орнуудад санхүүгийн тусламж өгөхөөс татгалздаг.

Хоёрдугаарт, олон улсын байгууллагуудад нь том улсууд эсхүл хуучин үеийн дэлхийн гүрнүүдийн сонирхолд үйлчилдэг. Жишээлбэл Хятад, Франц, Орос, Их Британи, АНУ зэрэг улсууд НҮБ-ын алив чухал тогтоолд хориг тавих эрхтэй атал Япон, Герман, Энэтхэг зэрэг улсууд нь Их Британи, Францаас ч илүү том эдийн засагтай нь хоржоонтой.

Гуравдугаарт, маш олон хүн НҮБ нь өөрийн Хүний Эрхийн Зөвлөлдөө Конго, Эритрей зэрэг улсуудыг багтаасан байдаг нь либерал ардчиллыг дэлхийд тогтоох үйл хэрэгт үүрэг гүйцэтгэж чадахгүйг нотолж байна гэж үздэг.

Эдгээр улсууд олон улсын эрх чөлөөний индексүүдэд тааруу үнэлгээтэй.

Дөрөвдүгээрт, олон улсын байгууллагууд нь ард түмнүүдийг бус засгийн газруудыг төлөөлдөг. Ихэнхдээ эдгээр засгийн газрууд өөрсдийн ард түмнийхээ талархал дэмжлэгийг хүлээх бус харин ч тэдний хараалыг бардаг байх нь элбэг. Хэдий тийм боловч тэд өөрсдийгөө улс орноо бүхэлд нь төлөөлөх зүй ёсны эрхтэй ард түмний төлөөлөгчид гэж бусдад ойлгуулахаар чармайдаг. Иймд эдгээр олон улсын байгууллагууд ардчилсан шинэтгэлийн найдвартай хөтлөгч, манлайлагч болж чадахгүй байх магадлал өндөр.

ДЭЛХИЙН АРДЧИЛАЛ

Өнгөрсөн зууны туршид идеалистууд дэлхийг хамарсан ардчилсан тогтолцоог байгуулахыг мөрөөдсөөр ирсэн. Гэвч энэ санаанд ч гэсэн ноцтой бэрхшээлүүд бий.

Нэгдүгээрт, ардчилал нь дэлхийн хэмжээнд хэрэгжих магадлал бага. 7,8 тэрбум хүн дэлхийн сонгуулийн үйл явцад бодитоор оролцож чадах уу? Их гүрнүүд болон эдийн засгийн хувьд хүчирхэг улсууд өөрсдийн хяналтыг тогтоохгүйгээр хүн бүрийг төлөөлсөн шударга төлөөлөл бүхий дэлхийн засаглалыг хэрхэн зохион байгуулах вэ? Дэлхийн түүх, соёл, худалдааны харилцаа хамаарал, соёлын харилцаа холбоо, үзэл бодлын ялгаатай байдлуудыг харгалзаж үзвэл цөөн хүмүүс ‘дэлхийг’ төлөөлөх боломжтой гэж нотлох боломжгүй.

Тэр ч бүү хэл бүс нутгийн засгийн газар хоорондын нэгдсэн байгууллага байгуулах оролдлого ч бүтэлгүйтэж байна. Европын Холбооны Парламентад 30 орчим улс төлөөлөгчдөө илгээдэг. Хэдий эдгээр төлөөлөгчдийг олон нийтээс сонгодог боловч маш олон улс, улс төрийн намууд оролцож, олон янзын үндэсний ашиг сонирхлын тоглоом явагддаг учраас уг парламентыг бодитоор эрх мэдэл, нөлөөтэй гэж хэлэх аргагүй. Бодит

шийдвэрүүдийг олон түмнээс сонгогдоогүй, үндэсний засгийн газруудын төлөөлөгчдөөс бүрдсэн байгууллагууд гаргадаг. Үүнийг ардчилалгүй гэж хурцаар шүүмжилдэг боловч ардчилал нь улс орнуудын хил хязгаараас давах нь нь бодит байдалд боломжтой эсэх нь эргэлзээтэй.

Хоёрдугаарт, төлөөллийн байгууллагууд томрох тусам тэднийг ил тод байлгаж, төлөөлж буй хүмүүсийнх нь өмнө хариуцлага хүлээлгэх магадлал нь улам бүр буурдаг. Дэлхийн засаглалын хувьд засаглаж буй хүмүүс болон тэдний захиргаанд байгаа хүмүүс хоорондын зай (биет утгаараа болон зүйрлэлийн хувьд) хэтэрхий алслагдмал учраас хэл, соёл болон олон ялгаатай үзэл бодлын зөрүүгээс шалтгаалж бодит төлөөлөл, хяналтыг бий болгох нь бараг л боломжгүй. Сонгогчид өөрсдийн засгийн газруудаас ч илүү эдгээр байгууллагуудад үл итгэх нь тодорхой.

Мөн улс орнуудын хууль эрх зүйн тогтолцоонууд ялгаатай гэдгийг санаарай. Олон зууны туршид хөгжсөн эдгээр уламжлалууд нь гүн бат суурьтай бөгөөд өөр өөр түүх, хэл соёл, нийгмийн нөхцөл байдлуудын тусгал байдаг. Эдгээр нь ялгаатай үнэт зүйлсэд тулгуурлаж, өөр зарчмуудын үндсэн дээр үйл ажиллагаа нь явагддаг. Олон ард түмний хууль, шударга

ёсны талаарх үзэл хандлагууд ч өөр хоорондоо эрс ялгаатай. Эдгээр ялгааг үл тоомсорлож тогтолцоо бүхнийг нэгтгэж болно гэж итгэх нь гэнэн хэрэг. Гэвч ардчилал нь зөвхөн хууль дээдлэх зарчмыг нийтээр хүлээн зөвшөөрсөн нөхцөлд л боломжтой билээ.

ЖИЖИГ БҮЛЭГТ ТОХИРОМЖТОЙ ТОГТОЛЦОО

Ардчилал жижиг бүлгүүдийн дунд маш үр дүнтэй. Жижиг улсуудын хувьд нийтлэг үнэт зүйлс, хүмүүс хоорондын харилцааны бат бөх сүлжээ, ойр дотно мэдрэмж, илүү их итгэлцэлтэй байх магадлал өндөр байдаг. Харин олон янзын үнэт зүйлстэй өөр өөр бүлгүүдээс бүрддэг, хүмүүс нь бие биенээ төдийлөн сайн мэддэггүй өргөн хүрээтэй нийгэмд итгэлцлийг бий болгох нь маш хэцүү.

Гэхдээ ийм нийгэмд ч итгэлцлийг бий болгож, үүнд тулгуурласан ардчиллыг цогцлоож болох ч Винсент Остромын (1997) тайлбарласнаар уг үйл явц хэцүү бөгөөд үүнд нэлээд урт хугацаа шаардлагатай гэнэ. Ардчилсан институциудын үйл ажиллагааг үр дүнтэй байлгах үүднээс тусгай зохицуулалтууд ч хийх шаардлага гардаг. Жишээлбэл хэл соёлын бүлэг буюу угсаатны зөрчилтэй улсуудад төвлөрсөн шийдвэр гаргах үйл явцыг хязгаарлаж холбооны федерал засаг захиргааны тогтолцоог хэрэгжүүлж болно. Швейцарь, Канад зэрэг нь үүний тод жишээ юм. Мөн газар нутгийн хэмжээгээр хамгийн том ардчилсан улсууд (жишээ нь, Канад, АНУ, Австрали, Энэтхэг) федерал тогтолцоотой байдаг нь санамсаргүй хэрэг биш.

Дахин хэлэхэд дэлхий даяар хамгийн

боломжгүй мэт санагдах улсуудад ч ардчилсан засаглалыг бий болгосон олон жишээ буй. Ардчиллын ашиг тусыг эрэлхийлэгчид өөрсдийн нөхцөл байдалдаа тохируулж хуулбарлаж, засвар өөрчлөлт хийх олон сонголтууд өнөө үед бий. Ингэх нь амаргүй байж болох хэдий ч (хүмүүс ихэвчлэн улс төрчдийн талаар гомдоллодог) харьцангуй либерал ардчилалд амьдардаг дийлэнхи хүмүүс үүнийг оролдоод үзэхэд буруудахгүй хүчин чармайлт гэдэгт санал нэгтэй байна гэдэгт итгэлтэй байна.

XIII

ТУРШЛАГААС ҮҮДЭЛТЭЙ СУРГАМЖУУД

БИД ҮНЭХЭЭР АРДЧИЛЛЫГ ХҮСДЭГ ҮҮ?

“Ардчилал гэх үг нэгэн цагт муу муухай утга санаагаар ойлгогддог байв. Энэ үгийн анхны утгыг мэддэг хэн бүхэн ард түмний засаглал буюу ард түмний дийлэнхи олонхын хүслийн дагуу явагдах засаглал нь хувь хүний эрх чөлөөнд ноцтой аюул учруулсан муу муухай үр дагаварт хүргэдэг гэдгийг мэддэг байсан. Хожим нь тавин жилийн дотор ардчилал гэх үгийн утга сайнаар ойлгогддог болчихсон” гэж Канадын улс төр судлаач С. Б. Макферсон (1966) бичжээ.

Ардчиллын санаа нь хүн бүхний амны уншлага шахуу болсон ч үнэн хэрэгтээ ихэнх хүмүүсийн төсөөлдөгөөс өөр, ойлгож хэрэгжүүлэхэд маш бэрх шинжтэй. Ардчилал нь хувь хүний эрхийг хүндэтгэх соёл, хууль дээдлэх ёс, бусдын үзэл бодлыг хүлцэх, харилцан итгэлцэл гэх мэтийн институцид тулгуурладаг. Энэ бүхний хөгжил урт хугацааг шаардах нь дамжиггүй. Иймээс бусад соёлд (жишээ нь, Хойд Африк, Ойрхи Дорнод, Ази дахь дарангуй дэглэмүүдийг түлхэн унагаж) ардчиллыг цогцлоох оролдлогууд нь ихэвчлэн гамшигт үр дагаварт хүргэж, олонхын, үзэл суртлын, эсвэл шашны хэт туйлширсан үзэл суртлын дарангуйллыг оронд нь бий болгосон.

Ардчиллыг АНУ-ын Ерөнхийлөгч Абрахам Линкольны (1863) Геттисбургийн тунхагтаа хэлсэн “ард түмний өөрсдийн, ард түмний

төлөөх засаглал” гэх идеалаар л төсөөлдөг. Гэвч орчин үеийн ардчилал нь үүнээс өөр. Ард түмэн зөвхөн төлөөлөгчдөө сонгодог бөгөөд шийдвэрийг зөвхөн төлөөлөгчид нь гаргадаг. Хэрвээ та ялагдал хүлээсэн талд байгаа бол ардчиллыг таны төлөөх засаглал гэж хэлэх боломжгүй. Тэгээд ч ‘ард түмэн’ гэдэг нь чухам хэн бэ? Эмэгтэйчүүд санал өгөх эрхтэй болоход олон зуун жил шаардагдсан. Зарим улсад өөр өөр угсаатны ‘ард түмэн’ өөр хоорондоо эвлэрэшгүй зөрчилтэй болсон байдаг. Мөн олонх чухам ямар эрхийн үндсэн дээр цөөнхийг засаглах ёстой вэ зэрэг философийн асуултууд ч бий.

Ардчилал улс төрийн тэгш байдал, оролцоо, шударга ёс, нийгмийн хариуцлага зэрэг ашиг тустай үнэт зүйлсийг бий болгох боломжтой. Английн зохиолч И. М. Форстер (1951) “ардчилалд хоёр удаа баяр хүргье” гэсэн байдаг. “Эхний шалтгаан нь ардчилал олон талт, ялгаатай байдлыг хүлцдэг, удаах шалтгаан нь шүүмжлэлийг зөвшөөрдөг”. Гэвч ардчилал нь өөрөө сайн арга хэрэгсэл байсан ч хангалттай гэсэн үг ердөө биш. Энэ нь сайн үр дүнг бий болгох ёстой. Ардчилал нь зөвхөн үр дүнтэй байгаа цагт л түүнийг зөвтгөх боломжтой.

АРДЧИЛЛЫГ ЮУ ЗӨВТГӨДӨГ ВЭ?

XX зууны Австрийн улс төр, эдийн засгийн судлаач Жозеф Шумпетер (1942) дундад зууны үеийн масс шулам шатаахын төлөө саналаа өгөх байсан нь эргэлзээгүй гэж хэлсэн удаатай. Өнөөдөр ч зарим улсад олонх нь өөрсдийн дургүйц цөөнхид хавчлага дарамт үзүүлэхийг бүрэн зөвшөөрнө.

Бид олонхид бусдыг захирах эрх байх ёстой нь маргаангүй гэж үзэж болохгүй. Мөн олонхын шийдвэрүүд хар аяндаа ‘зөв шударга’ байдаг ч гэж үзэх аргагүй. Улс төрийн хангалттай их үйл явдлыг үзэж туулсны үндсэн дээр л өнөөгийн мэдлэг боловсролтой, гэгээрсэн, либерал үеийнхэн олонхын засаглал нь хүний эрхэмлэх ёстой үнэт зүйл биш гэсэн дүгнэлтэнд хүрсэн. Бусдын санаа бодлыг хүлцэн тэвчих, ялгаатай амьдралын хэв маягийг нь хүндэтгэх гэх мэтийн үнэт зүйлс олонхын шийдвэрээс дээгүүрт тавигдах ёстой. Гэхдээ хэрэв ардчилал нь олонхид хяналтгүй эрх мэдэл өгөх зорилготой биш юм бол бид үүний үйл ажиллагаа зөв буруу байгаа эсэхийг ямар хэмжүүрээр дүгнэж болох вэ? Олон боломж бий. Тухайлбал, ардчилал нь үнэхээр зөрчилдөөнийг бууруулж, тайван замаар эрх мэдлийг шилжүүлэх боломжийг олгож байгаа эсэх? Мөн ардчилсан үйл явцаас гарч буй шийдвэрүүд үнэхээр урт хугацаанд

төвлөрсөн, үр ашигтай байдалд хөтөлж чадаж байгаа эсэх зэрэг асуудлууд нь бидний хувьд туйлын ач холбогдолтой.

ТОГТВОРТОЙ АРДЧИЛЛЫН ДҮР ЗУРАГ

Урт хугацаанд, тогтвортой байхын тулд ардчилал нь өөрийн үндсэн зорилгодоо төвлөрөх ёстой. Либерал үзэл санааны үүднээс бол ардчиллын үндсэн зорилго нь хувь хүний эрхийг хамгаалах, албадлагыг бууруулах, зөвхөн хамтын шийдвэрээр л шийдэгдэж болох цөөн асуудлыг шийдвэрлэх гэсэн утгыг илэрхийлдэг. Ардчилал нь хувь хүний эрхийг тэргүүн эгнээнд тавьж эдгээр эрхүүд л бусдын болон төрийн албадлагаас хувь хүнийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Эдгээр чанар үгүй бол ардчилал тогтвортой оршин тогтнох магадлал бага.

“Ардчилал үргэлж үймээн, тэмцлийн талбар байсаар ирсэн ... ерөнхийдөө үүний орших хугацаа богино байдгийн ижил мөхөл нь ч гэсэн хүчирхийлэлтэй байсаар ирсэн”.

— Жеймс Мэдисон (1787), Федералист захидалууд

Хэдий ийм боловч үгүйдээ л ардчилалд боломжтой хугацаанд тогтвортой байлгах боломжийг олгодог институциуд бий. Олонх болон тэдний төлөөлөгчдийн эрх мэдлийг хязгаарлах хууль журам зайлшгүй шаардлагатай. Чөлөөт, шударга, өрсөлдөөнт сонгуулиуд зохион байгуулагдаж тэдгээр нь сонгогчдод бодитой сонголтын багцыг санал болгох ёстой. Иргэний эрх чөлөөг өргөн хүрээнд хамгаалж, чөлөөт

хэвлэл, үг хэлэх эрх чөлөө, эрх баригчдаас айх айдас дарамтгүйгээр чөлөөтэй эвлэлдэн нэгдэх зэрэг эрхийг хүмүүс эдлэх учиртай. Олон нийт болон хууль тогтоогчдын сонголтыг хязгаарлах эрх мэдэлтэй цэргийн, хааны, эсхүл шашны хатуу дэг жаягуудыг хориглох шаардлагатай.

Өнөө үед насанд хүрсэн хүн бүрийг сонгуулийн эрхтэй байлгахаас өөр арга зам гэж үгүй. Үүнгүйгээр орчин үеийн ардчиллыг төсөөлөх боломжгүй байсан ч гэж хэлж болно. Гэхдээ л бид сонгогчид заримдаа гамшигт хөтөлсөн сонголтуудыг хийдэг гэдгийг мартаж болохгүй. Тухайлбал 1932 онд тэд Германы Рейхстагт Нацист намыг олонх болгосон. Тэр ч байтугай хамгийн либерал улсуудад ч гэсэн сонгогчид үргэлж нийтийн ашиг сонирхлыг бус өөрийнхөө хувьд хамгийн сайн гэж итгэсэн сонголтоо л хийдэг. Олон сонгогчын амьдрал төрөөс хамааралтай бөгөөд энэ нөхцөл байдал нь сонгуулийн үр дүнд зайлшгүй нөлөөлдөг. Ихэнхи сонгогч ухаалаг сонголт хийх чадваргүй. Бид чадваргүй шүүгчдэд хэн нэгэн эрх чөлөөтэй байх эсэхийг даатгахыг зөвшөөрдөггүй гэдгийг Жейсон Бреннан (2016) цохон тэмдэглээд тэгвэл яагаад чадваргүй сонгогчдод хүн бүрийн эрх чөлөөний асуудлыг хариуцуулах ёстой юм бэ гэх асуултыг тавьсан байдаг. Гэхдээ сонгогчдын чадварыг үнэлэх объектив, маргаангүй хэмжүүр

гэж байхгүй учраас ардчилал нь тэдний алдаа дутагдлыг даван туулах чадамжтай гэж найдахаас өөр сонголт бидэнд алга.

“Өөрийгөө устгаагүй ардчилал гэж хэзээ ч байсангүй” гэж Америкийн хоёр дахь Ерөнхийлөгч Жон Адамс (1814) бичжээ. Гэвч парадокс байдлаар ч харсан ардчилал нь хүмүүс түүнээс татгалзах эрх чөлөөтэй учраас л хамгийн хүчирхэг гэж хэлж болно. Хөлөөрөө санал өгөх буюу улс орноосоо дүрвэх нь саналын хуудсаас ч илүү хүчтэй мессежийг эрх баригчдад илгээдэг. Жейми Лемкийн (2016) хэлсэн ёсоор, хэрэв төр нь хүмүүсийн ашиг тусын төлөө ажиллаж байгаа бол иргэд үлдэх магадлал өндөр, харин дүрвэж зугтах аваас төр шинэтгэл хийх илүү хүчтэй шахалтанд ордог. Холбооны федерал тогтолцоонууд хамгийн хялбар гарц болж болох талтай. Учир нь хувь хүмүүс өөр өөр засаглалын тогтолцоотой муж хооронд шилжин суурьших нь харьцангуй саад тотгор багатай. Гэвч өнөөдөр улс хоорондын шилжин суурьших үзэгдэл улам бүр нэмэгдсээр байна.

АЛЬТЕРНАТИВ АРДЧИЛЛЫН ТОГТОЛЦООНУУД

Ардчилал олон асуудалтай боловч эдгээр асуудлыг илүү их ‘ардчилал’-ыг бий болгосноор хар аянд нь шийднэ гэж бодох нь өрөөсгөл. Хууль тогтоомжийг шууд санал хураалт буюу референдумаар шийдэх нь популист, зөрчилтэй үр дагаварт хүргэж болзошгүй. Хэлэлцүүлгийн тогтолцоо болон онлайн санал хураалт нь одоо байгаа алдааг улам бүр хүндрүүлж болно. Энгийн иргэд бодлого боловсруулах хэлэлцүүлэгт оролцох цаг зав, сонирхолгүй байдаг тул бодлогын асуудлыг иргэдийг төлөөлдөггүй, явцуу ашиг сонирхолдоо хэт хөтлөгдсөн цөөн хүн хяналтандаа авчих эрсдэл зэрэг практик асуудлууд ч бий. Түүнчлэн олонхын шийдвэрийг илүү легитим харагдуулснаар эдгээр ‘оролцооны’ механизм нь цөөнхийн эрхийг улам эрсдэлд оруулах ч боломжтой.

Мөн бид хэр олон асуудлуудаа хамтаар шийдэх шаардлагатай вэ? Нийгэмд бүхнийг дээрээс өгсөн тушаал заавар, хамтын шийдвэргүйгээр зохион байгуулах чадамж өөрт нь байдаг. Австрийн эдийн засагч Ф.А.Хайек (1988) үүнийг ‘аяндаа бий болсон дэг журам’ гэж тодорхойлсон. Зах зээл, хэл ярианы хөгжил, Википедиа зэрэг онлайн байгууллагууд, хувь хүмүүсийн харилцан үйлчлэлээр аяндаа бий

болж улам бүр хөгждөг Нийтлэг хууль эрх зүйн (Common Law) тогтолцоо нь аяндаа бий болох дэг журмын тод жишээ билээ. Нийтлэг хууль нь үйлдэл, ёс суртахууны хэдхэн энгийн дүрэмд л тулгуурладаг. Америкийн улс төрийн идэвхтэн Мэтт Киббегийн (2014) ижил нэртэй номонд “Хүмүүсийг гомдоож болохгүй, тэдний эд зүйлийг бүү булаа!” гэсэн нь бий.

Эдгээр ёс суртахууны зарчмуудад тулгуурлаж хүмүүс иргэний нийгмийн байгууллагууд болон жижиг засаг захиргааны нэгж зэрэг өөрсдийн нийгэмлэгийг цогцлоох боломжтой. Олон төрлийн засаг захиргааны нэгж байх нь хүмүүст сонголт өгч, хэрэв тэд хайхрамжгүй хандлага, дарлал мөлжлөгтэй тулгарвал тухайн нэгжээс ‘зугтах’ боломжтой. Ингэх нь мэдээж ‘дэлхийн засаглал’-ын нөхцөлд огтоос боломжгүй. Цаашилбал аяндаа бий болсон нийгмийн үйл ажиллагааны дүрмүүд нь жижиг бүлгүүдийн хувьд илүү энгийн, зөвшилцөлд тулгуурласан байх магадлалтай. Ардчилал гэдэг бол зөвшилцөлд суурилсан, зөвшилцөлд хүрэхийг зорьдог хүний институци байгууламжуудын цогц юм. Үүнд хүмүүс хоорондын бодит харилцаа маш чухал. Ардчилал нь хийсвэр байдлаар үр дүнтэй ажиллах чадамжгүй.

Технологи бидэнд бусдын төлөвлөгөөгүйгээр өөрсдийн амьдралаа хянах илүү их боломжийг

олгож байна. Мэдээллийн технологи нь жижиг бүлгүүдэд нийтлэг сонирхлын үндсэн дээр нэгдэх, ойртох боломжийг олгодог. Тэгвэл том төр хэнд хэрэгтэй вэ? Төрийн үйлчилгээ, нийгмийн даатгалыг хувь хүнд илүү нийцсэн шинэ арга замаар хэрэгжүүлэх боломжтой. Хүмүүс онлайнаар өөр хоорондоо шууд арилжаа хийх боломж бүрдсэн нь худалдаа, арилжааг илүү хялбаршуулсан.

Үнэн хэрэгтээ хүмүүс өөрсдийгөө засаглаж чадахгүй гэдэг аргумент (урьд цагт эмэгтэйчүүд, боолчууд зэрэг хүмүүсийн саналын эрхийг хязгаарлахад ашиглагдаж байсан) улам бүр утгагүй сонсогдох боллоо. Хүмүүсээс л шинэлэг санаа гардаг. Өнөөдөр тэд такси, амралтын газар, хүргэлтийн үйлчилгээ, нийтийн үйлчилгээ гэх мэтийг нийт нийгмийн хамтын шийдвэрээс ангидаар онлайн орчинд үр ашигтай, туйлын хөгжингүй байдлаар зохион байгуулсаар байна.

АРДЧИЛАЛ БҮХ ЗҮЙЛ БИШ

Ардчиллын төлөө тэмцэгчид ихэвчлэн ардчиллыг өргөн хүрээнд түгээхийг хүсдэг. Тэд бусад улс орнуудад ардчиллыг цогцлоож, өөрсдийн улс орнууддаа хамтын шийдвэр гаргах үйл явцын хүрээг өргөжүүлэхийг зорьдог. Гэвч тэд олонхын шийдвэр ямагт төгс бус болохыг мөн ‘ард түмний’ (хэрхэн тодорхойлохоос үл хамааран) шийдвэрүүд нь хар аяндаа зүй ёсны болчихдоггүй гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой. Тухайлбал, шулам шатаахыг эрт цагт олон түмэн дэмжих магадлалтай байсан нь баараггүй.

Харин ч эсрэгээрээ ардчилал нь сайн засаглалын зөвхөн нэг л элемент бөгөөд хувь хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх ёс, үг хэлэх эрх чөлөө зэрэг бусад үнэт зүйлстэй хамт оршдог. Ардчилал үр дүнтэй байхын тулд түүний хүрээг зайлшгүй шаардлагатай даалгаваруудаар нь хязгаарлаж, хувь хүмүүс өөрсдийн хүслээр үйлдэх боломжтой хувийн орон зайг нь аюулгүй байлгах ёстой. Мөн ардчиллын үйлдлүүдийг хязгаарлах шаардлагатай бөгөөд энэ нь эрх мэдлийг ард түмний тусын тулд бус тэдний эсрэг урвуулж ашиглахаас урьдчилан сэргийлнэ. Үүнд Үндсэн хуулийн хязгаарлалт, эрх мэдлийн тэнцвэр, зарим шийдвэрт зөвхөн дийлэнхи олонхын санал шаардлагатай байх зэрэг аргачлалууд багтана. Үүнээс гадна либерал

ардчилал нь мэдлэг ойлголт, соёлтой гүн гүнзгий хэлхээ холбоотой.

Ардчиллыг хэрэгжүүлэх нь амаргүй. Энэ нь маш өргөн хүрээнд хүмүүсийн хамтын ажиллагааг шаарддаг. Ялангуяа олонх эсхүл эрх мэдэлтнүүдээс өөрсдийгөө хянах чадварыг шаарддаг. Энэ нь биднээс хувийн сонирхол, богино хугацааны сэтгэл ханамжаасаа татгалзаж, урт хугацаандаа анхаарлаа төвлөрүүлэхийг шаарддаг. Бид алдаа эндэгдлээ хүлээн зөвшөөрч, түүнээсээ чин сэтгэлийн сургамж авах ёстой. Ардчилал бол бэлэн шийдэл биш. Учир нь ардчилал нь тухайн улсын түүх, соёлын онцлогт тохирсон байдлаар хэрэгжих ёстой. Ардчилал нь олон төрлийн дүрэм журмыг нийтээр хүлээн зөвшөөрөхийг шаарддаг бөгөөд үүнд ардчиллыг үр дүнтэй байлгахад шаардлагатай ерөнхий үзэл баримтлалаас эхлэн олон нарийн ширийн асуудлыг зохицуулсан зохицуулалтууд багтдаг. Ардчилал нь хүмүүст нийцтэй байдлаар зохицуулалт хийх боломжтой нээлттэй нийгмийг бий болгохыг шаарддаг. Мөн эдгээр нийгмүүд нь дэлхийн өөр бусад нээлттэй нийгмүүдтэй харилцаа холбоо тогтоох боломжтой байх шаардлагатай.

Улс төрчдийн хувьд иргэдийг зохион байгуулах бус иргэд өөрсдөө зохион байгуулагдахад нь дэмжлэг үзүүлэх ёстой.

Нийгэм хэт нарийн түвэгтэй, комплекс учраас төвлөрсөн эрх мэдэл нь түүнийг төлөвлөж, зохицуулах нь бүү хэл бүрэн ойлгоход ч хэцүү гэдэг үнэнийг харгалзаж үзвэл улс төрийн оролцоог хамгийн бага түвшинд барих ёстой гэдэг нь ойлгомжтой. Хувь хүний эрх чөлөөнд аль нэг зөвтгөл шаардлагагүй. Та өөрийн үйлдлийн үр дагаварыг өөрөө л хариуцна. Харин ардчилалд зөвтгөл шаардлагатай. Учир нь хамтын шийдвэр нь бусдын амьдралд нөлөөтэй.

Бид ардчиллыг бүрэн дүүрэн зөвтгөгдсөн гэж хэт магтах боломжгүй. Ардчилал нь одоо ч үргэлжилж буй туршилт. Ардчилал нь хувь хүний эрхийг хүндэтгэх, тэдэнд илүү хөгжиж дэвжих боломж олгох зэрэг либерал үнэт зүйлстэй бусад засаглалын хэлбэрүүдээс илүү ойр төдий. Нэгэнт бат бөх байр сууриа үндэслэж чадсан ардчилал нь гайхалтай урт хугацаанд тогтвортой оршдог болох нь түүхээр нотлогдсон. Ардчиллын институциуд нь хэдий төгс бус ч либерал үнэт зүйлсийг дэмжигчдэд өөрсдийн байр сууриа илэрхийлэх, жинхэнэ либерал ардчиллын практик болон ёс суртахууны ашиг тусыг тайлбарлах гол талбар нь болж чаддаг.

XIV

АРДЧИЛЛЫН ТУХАЙ ЭШЛЭЛҮҮД

ОЛОНХЫН ДАРАНГУЙЛАЛ

“Хязгааргүй ардчилал гэдэг бол олигархийн адил олон хүний зүгээс ирэх дарангуйлал юм.”

— Аристотель (МЭӨ 350), Улс төр

“Ардчилал нь эрх чөлөө биш. Ардчилал нь хоёр чоно, нэг хонь өдрийн хоолондоо юу идэх тухай санал хураалт явуулж байгаатай ижил. Эрх чөлөө нь 99 хувийн саналаар ч хүчингүй болгох боломжгүй тодорхой тооны эрхийг хүлээн зөвшөөрч, танин мэдэхээс эх сурвалжтай.”

— Марвин Симкин (1992), ‘Хувь хүний эрх’, Лос Анжелес Таймс

ЭРХ МЭДЛИЙН ЗАВХРАЛ

“Хүмүүс эрх мэдэлтэй болмогцоо муу муухайг үйлдэж, заримдаа галзуурах нь бий. Учир нь эрх мэдэл тэднийг ердийн шударга байвал хохирол амсах нөхцөлд оруулдаг.”

— Э.М.Форстер (1951), Ардчиллын төлөөх хоёр ёсолгоо

“Бүх төрийн засаглал нийтлэг бэрхиээлтэй тулгардаг. Эрх мэдэл нь эмгэгтэй зан чанартай хүмүүсийг өөртөө татдаг. Эрх мэдэл муу үйлдэлд хөтөлдөг бус харин муу муухайг үйлдэгчдийг соронз мэт өөртөө татдаг.”

— Фрэнк Херберт (1965), Манхан

“Засаглагчид ёс суртахууны болон оюуны хувьд дундаж түвшнээс дээгүүр байсан нь ховор. Ихэнхи тохиолдолд тэд дунджаас доогуур байдаг гэж би боддог. Тиймээс улс төрд хамгийн мууд байнга бэлэх байх зарчмыг баримтлах нь зүйтэй.”

— Карл Поппер (1945), Нээлттэй нийгэм батүүний дайснууд

АРДЧИЛЛЫН СОЁЛ

“Хэрэв эрх чөлөө, тэгш байдал нь зарим хүмүүсийн боддог шиг ардчилалд хамгийн их хамааралтай аваас энэ нь бүх хүн тэгш хэмжээнд засаглалын үйл ажиллагаанд оролцох үед л хамгийн сайн хэрэгжинэ.”

— Аристотель (МЭӨ 350 орчим), Улс төр

“Төрийн төлөө хувь хүнийг золиослосноор Ромын эзэнт гүрний удирдагчид тэднийг дэмжин тэтгэж байсан жинхэнэ ашиг тусыг үгүй хийсэн. Тэд идэвхитэй, өөрийгөө хүндэлдэг иргэдээ идэвхигүй, хувиа хичээгч болгож хувиргасан.”

— Сэр Артур Брайант (1984), Мөнгөн далайд орших ертөнц: Британи ба Британийн ард түмний түүх

“Аль ч төлөөлөгч өөрийн үзэл санаатай зөрчилддөг намын саналыг сохроор дагах ёсгүй, энэ бол зохистой хүн тэвчих огтоос боломжгүй боолчлолын хэлбэр юм.”

— Эдмунд Бёрк (1741), Жентлемений ба Лондонгийн сэтгүүл

“Дэлхий ертөнцийг ардчилалд аюулгүй болгох ёстой. Дэлхийн энх тайван нь улс төрийн эрх чөлөөний баталгаат суурин дээр тогтох ёстой.”

— Вудроу Вилсон (1917), Дайны асуудлаар Конгрессд хийсэн мэдэгдэл

УНШИЖ СУДЛАХ МАТЕРИАЛУУД

ТАЙЛБАР БА ТОЙМ

Beetham, D. (2005) Democracy: A Beginner's Guide. London: Oneworld Publications. Ардчиллын тухай маш энгийн танилцуулга бөгөөд ардчиллын үйл ажиллагаа үр дүнтэй байхад шаардлагатай зарчим, институциудыг тодорхой тайлбарлаж, бодит байдал дээр хэрхэн хувьсан өөрчлөгдсөнтэй харьцуулсан. Энэ ном нь ардчилалд тулгамдсан шинэ бэрхшээлүүд, улс төрд итгэл алдагдаж буй байдал болон оролцооны өөр хувилбаруудыг тайлбарласан.

Butler, E. (2012) Public Choice: A Primer. London: Institute of Economic Affairs. Сонгогчид, шахалтын бүлгүүд, улс төрчид болон албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын үүрэг болон үүний ардчилсан шийдвэрүүдийн үр дагавар, бодит байдалд хэрхэн нөлөө үзүүлж, эргэлзээ төрүүлдэгийг энгийнээр тайлбарласан гарын авлага.

Butler, E. (2013) Foundations of a Free Society. London: Institute of Economic Affairs. Нийгэм, эдийн засгийн эрх чөлөө болон либерал ардчиллын үндэс тулгуур болсон зарчмуудыг энгийнээр тайлбарласан ном. Хүлцэн тэвчих, шударга ёс, өмчийн эрх, иргэний тэгш байдал зэрэг сэдвүүдийг хамарна.

Crick, B. (2003) Democracy: A Very Short

Introduction. Oxford University Press. Эртний Грекээс эхлэн ардчиллын түүхийг өгүүлж, популизм, сайн засаглалын институциуд болон иргэншил зэрэг сэдвүүдийг товч тайлбарласан танилцуулга.

Cartledge, P. (2018) Democracy: A Life. Oxford University Press. Эртний Грекээс Ромын Бүгд Найрамдах Улс, Сэргэн Мандалтын үе, Америкийн Үндсэн Хуулийг хүртэлх үеийг хамарсан өнөөгийн либерал ардчиллын үндэс тулгуурыг хөндсөн өргөн хүрээтэй түүх. Эрх болон олонхын зөрчлийн асуудлыг тус бүр хэрхэн шийдвэрлэсэн тухай өгүүлнэ.

Weale, A. (2007) Democracy. London: Palgrave. Бага зэрэг онолын болон философийн шинжтэй ч ардчиллын мөн чанар, түүний сорилтуудыг бид эрхэм дээд үнэт зүйлстэйгээ харьцуулж үнэлэх ёстой гэсэн чухал асуултыг хөндсөн.

ШҮҮМЖ

Achen, C. and Bartels, L. (2017) *Democracy for Realists*. Princeton University Press. Сонгогчдын мэдлэггүй байдал, жалга довны үзэл, богино хугацаандаа төвлөрсөн харалган байдал гэх мэтийн асуудлуудын шүүмж. Зохиогчид референдум болон бусад оролцооны шийдлүүдийг үгүйсгэж, эрх мэдлийн төвлөрөлөөс сэргийлэхийн тулд тогтмол, ойрхон давтамжтай сонгууль зохион байгуулахыг дэмжсэн.

Brennan, J. (2016) *Against Democracy*. Princeton University Press. Философич бээр сонгогчдын системчлэгдсэн гажууд зан чанарыг онцолж, эдгээрийг оролцоог илүү их хангаснаар ‘засах’ боломжгүй, харин ч улам дордуулдаг гэх санааг дэвшүүлсэн. Тэрээр ардчилал комплекс сонголтыг хялбаршуулж, хүчээр тулгадаг, хувь хүмүүст бусдыг захирах боломж олгодог тул үл таних хүмүүсийг хооронд нь дайсан болгодог гэж дүгнэсэн.

Caplan, B. (2007) *The Myth of the Rational Voter*. Princeton University Press. Сонгогчдын системчлэглсэн гажууд зан чанар нь ялангуяа зах зээлийн эдийн засаг, гадаадын иргэдийн

эсрэг гутранги үзэл нь ардчиллын үр дүнг гажуудуулж, амжилтгүй болгодог тухай тайлбарласан сонгодог бүтээл.

—

Karsten, F. and Beckman, K. (2012) *Beyond Democracy*. Scotts Valley, CA: CreateSpace. Либертари өнцгөөс дүгнэсэн баримт, логикт тулгуурласан маш сайн шүүмж бөгөөд ардчилал нь хамтач үзэл учраас өнөө цагт хямралд ороод байгаа тухай тайлбарладаг. Зохиогчид ардчилалтай холбоотой төөрөгдлүүд болох ард түмний засаг, шударга ёс, эрх чөлөө, хүлцэл гэх мэтийг жагсааж эдгээрт тулгарсан бэрхшээлүүдийг тухайлбал хүнд суртал, халамжийн бодлого, харалган сэтгэлгээ гэх мэтийг онцолдог. Тэд энгийн ойлгомжтой хууль журамд тулгуурласан цомхон төрийг номолсон.

—

Ostrom, V. (1997) *The Meaning of Democracy and Vulnerability of Democracies*. University of Michigan Press. Ардчилсан тогтолцоо хөгжихөд шаардлагатай нийгэм, соёлын нөхцөл байдал болон 'ардчилсан' хүчирхэг засаглалын өмнө хувь хүний эрх чөлөө, иргэний нийгмийг хадгалахад тулгарч буй бэрхшээлүүдийг судалсан. Мөн дэлхий даяар ялангуяа коммунизмаас ангижирсан улсуудад ардчилсан

нийгмийг байгуулахад тулгарсан сорилтуудыг хөндсөн.

Smith, C. and Miers, T. (2011) *Democracy and the Fall of the West*. Exeter: Imprint Academic. Энэхүү бяцхан номонд ардчилал нь өөрийн үндсэн эх сурвалж болох хууль дээдлэх ёс, хүлцэн тэвчихүй, өмчлөх эрх, чөлөөт зах зээл, иргэний нийгэм, нийгмийн эрх чөлөө зэрэг либерал үнэт зүйлсийг устгадаг шинэ дарангуйллыг бий болгосон гэх санааг дэвшүүлсэн. Улс төрчид ардчиллыг өөрсдийн зорилгод шаардлагатай эрх мэдлийн эх сурвалж гэж хардаг учраас том төрийг бүтээдэг.

Stoker, G. (2007) *Why Politics Matters: Making Democracy Work*. New York: Palgrave Macmillan. Хамтын шийдвэрүүд нь хүн бүрт чухал учраас улс төр нь ардчиллын зайлшгүй нэг хэсэг гэдгийг онцолдог. Гэвч улс төр нь 'мэргэжил' болсноор олон нийтийг өөрөөсөө түлхсэн. Хэвлэл мэдээллийн хоёр нүүр ч үүнд нөлөөлжээ. Илүү их ил тод байдал, хариуцлага, улс төрийн намын санхүүжилтийн хязгаар, иргэдийн эргүүлэн татах эрх, нутгийн өөрөө удирдлах ёсыг дэмжсэн бүтээл.

ГОЛЛОХ НЭР ТОМЬЁОНУУД

АВТОКРАТ (AUTOCRACY) Грекийн autos (өөрийн) болон kratos (эрх мэдэл) гэсэн хоёр үгнээс гаралтай. Ганц хүн (автократ) хууль эсвэл сонгуулийн ямар ч хязгаарлалтгүйгээр хяналтаа хэрэгжүүлдэг засаглалын хэлбэр.

НИЙТИЙН САНАЛЫН САНААЧИЛГА (BALLOT INITIATIVE) Сонгогчдын бүлгээс эхлүүлсэн, бодлого батлах, хууль тогтоох байгууллагад санал хураалт явуулах, эсвэл референдум зарлахыг шаардсан санал.

ҮНДСЭН ХУУЛЬ (CONSTITUTION) Засгийг хэрхэн зохион байгуулж, үйл ажиллагаа явуулах, түүнд оролцогчдын эрх мэдлийн хязгаарыг тодорхойлдог уламжлал, хууль, жишиг тогтоомжийн цогц.

ҮНДСЭН ХУУЛЬТ ЗАСАГЛАЛ (CONSTITUTIONAL GOVERNMENT) Эрх мэдлийг үндсэн хууль, уламжлал эсвэл бичмэл ('кодификаци') Үндсэн хуулиар тодорхойлж, хязгаарладаг засаглалын аль ч хэлбэрийг үүнд хамруулна. Үүнд төрийн тэргүүний албыг угсаа залгамжлуулдаг үндсэн хуульд хаант засаг, эрх бүхий иргэд эрх мэдэлтнүүдийг сонгож, хариуцлага тооцдог үндсэн хуульд ардчилал, эрх мэдлийг жижиг бүлэг хэрэгжүүлдэг үндсэн хуульд олигархи зэрэг багтана.

АРДЧИЛАЛ (DEMOCRACY) Грекийн demos (ард түмэн) болон kratos (эрх мэдэл) гэх үгсээс гаралтай. Эртний Грект эрх бүхий иргэд хуралдаж, хууль, бодлогыг хэлэлцэн шийдвэрлэдэг засаглалын хэлбэр байв. Өнөөдөр эрх бүхий иргэд хууль, бодлогын асуудлуудыг хэлэлцэн шийддэг төлөөлөгчдөө сонгодог засаглалын аль ч хэлбэр.

ДАРАНГУЙЛАГЧ (DICTATOR) Латины dicto (захиран тушаах) гэх үгээс гаралтай. Улс оронд хязгааргүй эрх мэдэлтэй, ихэвчлэн хүчээр хяналтаа тогтоосон удирдагч.

ЛИБЕРАЛ АРДЧИЛАЛ (LIBERAL DEMOCRACY) Олонхын засаглалаас илүүтэй хувь хүний эрх, эрх чөлөөг чухалчилдаг ардчиллын хэлбэр. Либерал ардчилал нь чөлөөт, шударга сонгууль, эрх мэдлийн хуваарилалт, хүлцэн тэвчихүй, хууль дээдлэх ёсоор тодорхойлогддог.

ОЛИГАРХИ (OLIGARCHY) Грекийн olígos (цөөн) болон arkho (захирах) гэдгээс гаралтай. Гэр бүл эсвэл цэргийн хунта зэрэг жижиг бүлгийн хяналт бүхий засаглалын хэлбэр.

АШИГЛАСАН БОЛОН НЭР
ДУРДСАН БҮТЭЭЛҮҮД

Acemoglu, D. and Robinson, J. (2006) Economic Origins of Dictatorship and Democracy. Cambridge University Press.

Acemoglu, D. and Robinson, J. (2012) Why Nations Fail. New York: Crown Publishing Group.

Adams, J. (1814) Letter to John Taylor (XVIII). Washington, DC: National Archives (<https://founders.archives.gov/documents/Adams/99-02-02-6371>).

Alves, A. and Meadowcroft, J. (2014) Hayek's slippery slope, the stability of the mixed economy and the dynamics of rent seeking. Political Studies 62(4): 843–61.

Aristotle (350 bc) Politics.

Attlee, C. (1957) Speech at Oxford, 14 June.

Brennan, G. and Buchanan, J. M. (1980) The Power to Tax. Analytic Foundations of a Fiscal Constitution. Cambridge University Press.

Burke, E. (1774) Speech to the electors of Bristol (<https://www.econlib.org/book-chapters/chapter-vol-4-miscellaneous-writings-speech-to-the-electors-of-bristol/>).

Burke, E. (1790) Reflections on the Revolution in France. London:James Dodsley.

Butler, E. (2015a) Classical Liberalism: A Primer. London: Institute of Economic Affairs.

Butler, E. (2015b) Magna Carta: A Primer. London: Adam Smith Institute.

Economist Intelligence Unit (2019) Democracy Index 2019 (<http://www.eiu.com/topic/democracy-index>).

Forster, E. M. (1951) Two Cheers for Democracy. New York: Harcourt, Brace and Company.

Fukuyama, F. (1992) The End of History and the Last Man. New York: Free Press.

Hayek, F. A. (1944) The Road to Serfdom. London: Routledge.

Hayek, F. A. (1979) Law, Legislation and Liberty, Volume 1. London: Routledge.

Hayek, F. A. (1988) The Fatal Conceit: The Errors of Socialism. London: Routledge.

Hobbes, T. (1651) Leviathan. London: Andrew Crooke.

Hume, D. (1758) Essays, Moral, Political and Literary. Edinburgh: Alexander Kincaid.

Kennedy, A. (1999) Frontline interview: Justice for Sale. Public Broadcasting System.

Kibbe, M. (2014) Don't Hurt People and Don't Take Their Stuff. New York: Harper Collins.

Lawson, R., Murphy, R. and Powell, B. (2020) The determinants of economic freedom: a survey. Contemporary Economic Policy 38(4): 622–42.

Lemke, J. S. (2016) Interjurisdictional competition and the Married Women's Property Acts. Public Choice 166(3): 291–313.

Lincoln, A. (1863) Gettysburg Address (<http://www.ourdocuments.gov/doc.php?doc=36&page=transcript>).

Locke, J. (1689) Second treatise of government. In Two Treatises of Government. London: Awnsham Churchill.

Luxemburg, R. (1899) Social Reform or Revolution? (<https://www.marxists.org/archive/luxemburg/1900/reform-revolution/>).

Machiavelli, N. (1513) The Prince. Rome: Antonio Blado

d'Asola.

Macpherson, C. B. (1966) The Real World of Democracy. Oxford: Clarendon Press.

Matsusaka, J. G. (2004) For the Many or the Few: The Initiative, Public Policy and American Democracy. Chicago University Press.

Mencken, H. L. (1956) Minority Report. Baltimore: Johns Hopkins University Press.

Mesquita, B. B. De, Smith, A., Siverson, R. M., Morrow, J. D. (2003) The Logic of Political Survival. Cambridge, MA: MIT Press.

Mill, J. S. (1861) Considerations on Representative Government. London: Parker, Son, and Bourn

Montesquieu, C.-L. (1748) The Spirit of the Laws (<https://oll.lib.ertyfund.org/title/montesquieu-complete-works-vol-1-the-spirit-of-laws>).

Murphy, R. (2018) Governance and the dimensions of autocracy. Constitutional Political Economy 30: 131–48.

Orwell, G. (1946) Politics and the English language. Horizon 13(76): 252–65.

Pericles of Athens (c. 431 bc) Funeral Oration. In The History of the Peloponnesian War.

Popper, K. R. (1945) The Open Society and Its Enemies. London: Routledge.

Ridley, M. (2020) How Innovation Works. London: Fourth Estate.

Robespierre, M. (1794) Report on the Principles of Public Morality. Philadelphia: Benjamin Franklin Bache.

Schumpeter, J. (1942) Capitalism, Socialism and Democracy. New York: Harper & Brothers.

Tocqueville, A. de (1835) Democracy in America. London: Saunders and Otley.

Transparency International (2019) Corruption Perceptions Index. Berlin: Transparency International. Vidal, G. (1987) Armageddon. London: Grafton.

Эймон Батлер нь дэлхийн тэргүүлэх бодлогын судалгааны байгууллага болох Адам Смитын хүрээлэнгийн захирал юм. Тэрээр эдийн засаг, сэтгэл судлалын чиглэлээр бакалаврын зэрэг, философийн чиглэлээр докторын зэрэг (PhD), мөн хүндэт DLitt зэргүүдийг хүртсэн. 1970-аад онд тэрээр Вашингтонд Д.С дахь Төлөөлөгчдийн танхимд ажиллаж, Мичиганы Хиллсдейлс коллежид философи зааж байгаад Их Британидаа буцан ирж Адам Смитын хүрээлэнг үүсгэн байгуулахад тусалсан. Эймон одоо Мон Пелериний нийгэмлэгийн нарийн бичгийн даргаар ажилладаг. Эймон олон номын зохиогч бөгөөд эдийн засаг, сэтгэлгээний тэргүүлэгчдийг танилцуулж Адам Смит, Мильтон Фридман, Ф.А.Хайек, Людвиг фон Мизес, Айн Рэнд нарын тухай ном бүтээлүүд туурвисан. Тэрээр мөн сонгодог либерализм, нийтийн сонголт, Магна Карта, Эдийн засгийн ухааны Австрийн дэг сургууль зэрэг олон сэдвээр гарын авлага бичсэн. 'The Condensed Wealth of Nations', 'The Best Book on the Market', 'School of Thought: 101 Great Liberal Thinkers', 'An Introduction to Entrepreneurship' зэрэг номуудыг ч эрхлэн гаргасан. Түүний 'Foundations of a Free Society' ном 2014 оны Fisher Prize-ын шагналыг хүртсэн. Тэрээр 'Forty Centuries of Wage and Price Controls' номын хамтран зохиогч бөгөөд IQ-ийн тухай цуврал номыг мөн бусдын хамтаар гаргасан. Эймон хэвлэл мэдээлэл, нэвтрүүлэг, онлайн орчинд идэвхитэй хувь нэмрээ оруулсаар байна.

ННА *****
Я-*****
ДАА*****



ISBN: